

Барилгын норматив баримт бичгийн тогтолцоо
МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ

**ХОТ, ТОСГОНЫ ТӨЛӨВЛӨЛТ,
БАРИЛГАЖИЛТЫН
НОРМ БА ДҮРЭМ**

БНБД 30.01.04

Албан ёсны хэвлэл

МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ЯАМ

Улаанбаатар хот

2004 он

ХОТ, ТОСГОНЫ ТӨЛӨВЛӨЛТ БАРИЛГАЖИЛТЫН НОРМ БА ДҮРЭМ

2004 оны 07-р сарын 01-ний

өдрөөс эхлэн мөрдөнө.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү норм ба дүрмийг шинээр барих, сэргээн шинэчлэх хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын ерөнхий төлөвлөгөө болон үе шатны төсөл зохиоход дагаж мөрдөнө.

Тайлбар:

1. Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөө боловсруулахад нутаг дэвсгэрийн үүргийн бүсчлэл, архитектур орон зайн зохиомж, бүтэц зохион байгуулалт, дэд бүтэц, гудамж, замын сүлжээ болон барилгажилт, цэцэрлэгжилт, хот орчны бүсийн төлөвлөлтийг иж бүрэн авч үзнэ.
2. Энэ норм, дүрэм нь хот, тосгоны эдэлбэр газрын зориулалтын бүсчлэл, тэдгээрийн харилцан шүтэлцээтэй байдал, архитектур-орон зайн зохиомж, барилгажилт болон инженерийн шугам сүлжээний төлөвлөлт, нутаг дэвсгэрийн экологи, эрүүл ахуй, ариун цэвэр, галын аюулгүйн шаардлагыг нормчлон тогтооно.
3. Ерөнхий төлөвлөгөөний үе шатны ажил нь: а) судалгаа, б) экологи, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, в) төлөвлөлтийн үндсэн шийдэл г) хэрэгжүүлэх арга зам, хөрөнгө оруулалтын ойролцоо өртөг тооцох гэсэн дараалалтай байна.
4. Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын төслийг боловсруулахад нэгдүгээр хавсралтад заасан хууль, эрх зүйн баримт бичгийг дагаж мөрдөнө. Норм дүрмийн нэр томъёоны тайлбарыг заавал мөрдөх хоёрдугаар хавсралт ёсоор; хот, тосгоны төсөл зохиоход баримтлах уур амьсгалын (1 дүгээр зураг) бүсчилсэн үзүүлэлтийг заавал мөрдөх гуравдугаар хавсралт ёсоор; хот, тосгоны галын аюулаас хамгаалах шаардлагыг заавал мөрдөх дөрөвдүгээр хавсралт ёсоор; хот, тосгоны нутаг дэвсгэрийн ашиглалт, барилгажилт болон хүн амын төлөвлөлтийн шалгуур үзүүлэлтүүдийг тооцох зарчмыг тавдугаар хавсралт ёсоор; нутаг дэвсгэрийн хүн амын багтаамжийг тооцох зарчмыг зургадугаар хавсралт ёсоор; нисэх онгоцны буудлын эдэлбэр газрын төлөвлөлтөд тавих шаардлагыг заавал мөрдөх долоодугаар хавсралт ёсоор; инженерийн төвлөрсөн болон хэсэгчилсэн хангамжтай газар бүхий сууцны эдэлбэр газрын зөвшөөрөгдөх хэмжээг заавал мөрдөх наймдугаар хавсралт ёсоор; суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийн хүн амын нягтралын тооцоог зөвлөмжийн есдүгээр хавсралт ёсоор; хөдөөгийн тосгон суурингийн суурьшлын бүсийн хүн амын тооцооны нягтралыг зөвлөмжийн аравдугаар хавсралт ёсоор; өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний агуулахын 1000 хүнд ногдох эдэлбэр газрын талбайн хэмжээг зөвлөмжийн арваннэгдүгээр хавсралт ёсоор; хот, суурины цэцэрлэгжүүлэлтийн зураг төсөл зохиох аргачилсан зөвлөмжийг арванхоёрдугаар хавсралт ёсоор; олон нийт, иргэний барилга байгууламжийн эдэлбэр газрын талбайн доод хэмжээг зөвлөмжийн арвангуравдугаар хавсралт ёсоор; тээврийн хэрэгслийн зогсоолын нормативыг зөвлөмжийн арвандөрөвдүгээр хавсралт ёсоор; гараж, тээврийн хэрэгслийн паркийн эдэлбэр газрын хэмжээг зөвлөмжийн арвантавдугаар хавсралт ёсоор; хотын тохижилтын нормативыг зөвлөмжийн арванзургаадугаар хавсралт ёсоор; цахилгаан хэрэглээний томсгосон үзүүлэлтийг зөвлөмжийн арвандолоодугаар хавсралт ёсоор; хот, сууринд тахир дутуу хүмүүст зориулсан төлөвлөлтийн шаардлагуудыг зөвлөмжийн арваннаймдугаар хавсралт ёсоор тус тус төлөвлөнө.

БНБД 30.01.04

- 1.2. Шинээр барих, сэргээн шинэчлэх хот, тосгоны барилгажилтыг хэрэгжүүлэх явцад мэргэжлийн экспертизийн дүгнэлт хийлгэж, баталгаажсан ерөнхий төлөвлөгөө, хот төлөвлөлтийн баримт бичгийн дагуу гүйцэтгэнэ.
- 1.3. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад хот байгуулалтын төрийн бодлого, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Монгол улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, эдийн засгийн салбаруудын хөгжлийн төсөл, мастер төлөвлөгөөнүүд, байгаль орчныг ашиглах, хамгаалах хөтөлбөр, газар хөдлөлийн бичил мужлал, инженер-геологи, гидрогеологийн дүгнэлтүүд болон энэхүү нормын 1 дүгээр хавсралтад заасан Монгол улсын хууль, тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 1.4. Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөө боловсруулахдаа зөвлөмжийн 3 дугаар хавсралтад заасан уур амьсгалын (1-р зураг) бүсчлэлийн үзүүлэлтийг дагаж мөрдөнө.

**ХОТ СУУРИНЫ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД МӨРДӨХ
УУР АМЬСГАЛЫН БҮСЧЛЭЛ**



1 дүгээр зураг

- 1.5. Хот, тосгоны ангилал, хүн амын тоог 1 дүгээр хүснэгтэд заасан ёсоор төлөвлөнө.

1 дүгээр хүснэгт

Хот суурины ангилал, хүн амын тоо

Хот, тосгоны ангилал	Хүн ам (мян/ хүн)	Тайлбар
Хот:		
Их хот	500.0 мянгаас дээш	-
Том хот	100.0-500.0	-
Дунд хот	50.0-100.0	-
Бага хот	20.0-50.0 хүртэл	-
Тосгон:		
Хоторхуу тосгон	0.5 – 20.0	Уул уурхай, тээвэр, амралт, сувилал, аялал жуулчлалын тосгон
Хөдөөгийн тосгон	0.5 – 10.0 хүртэл	Сумын төв, багийн төв

1.6. Хот, тосгоныг хүн амын нутагшилт, суурьшлын үндсэн элемент гэж тооцон түүний тухайн бүс нутгийн нийгэм, эдийн засагт эзлэх байр суурьтай нь уялдуулж, үйлдвэрлэл, нийгэм соёл, зам тээврийн болон бусад дэд бүтцийн таталцах бүлэг суурингийн үйлчилгээний хүрээг тооцон төлөвлөнө. Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг дотор нь дараах байдлаар ангилна. Үүнд:

1. Бүс нутгийн хөгжлийн төсөл;
2. Аймгийн хөгжлийн төсөл;
3. Бичил бүсийн хөгжлийн төсөл;
4. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө;
5. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө;
6. Барилгажилтын төсөл

Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн хугацааг 20 жил, төлөвлөлтийн дунд хугацааг 5-10 жил, хэрэгжүүлэх үе шатны барилгажилтын эхний ээлжийг 1-5 жил, хэтийн төсөөлөлийг төлөвлөлтийн хугацаанаас цааш 10 жилээр тус тус төлөвлөнө.

1.7. Төлөвлөлтийн хугацаан дахь хот, тосгоны хүн амын хөгжлийн хэтийн төлөвийг тухайн бүс нутаг болон орон нутгийн түвшинд хүн амын ердийн өсөлтийн итгэлцүүр, шилжих хөдөлгөөний сүүлчийн 5 жилийн өсөх, буурах хандлага, ундны усны нөөц, газар нутгийн багтаамж, экологийн даац, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хүн ам зүйн бодлоготой уялдуулан тодорхойлно. Төлөвлөлтийн хугацааны хүн амын ердийн өсөлтийг дараах томъёогоор тооцно. Үүнд:

$$N_t = N_0 (1 + Kt)$$

N_t – t хугацаан дахь хүн амын тоо, хүн

N_0 – одоо байгаа хүн ам, хүн

K - хүн амын жилийн дундаж өсөлтийн итгэлцүүр

t – төлөвлөлтийн хугацаа, жил

Тайлбар:

1. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн хугацаанаас цаашхи алс ирээдүйд хөгжүүлэх хот, тосгоны нөөц нутаг дэвсгэрийн асуудлыг ерөнхий төлөвлөгөөний шатанд хамруулан үзнэ.
2. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа:
 - а. Хот, тосгоны нутаг дэвсгэрийн хуваарилалт, ашиглалт экологийн хүчин зүйлстэй уялдуулан шийдэх;
 - б. Хот, тосгоны гудамж, зам тээврийн сүлжээ эрүүл, аюулгүй, тав тухтай орчныг бүрдүүлэх зарчмаар төлөвлөх;
 - в. Хот, тосгоны хүн амын нийгмийн дэд бүтэц, соёл, ахуйн үйлчилгээг хүн амыг жигд хамарсан шуурхай, дөт байх зарчмаар төлөвлөх;
 - г. Инженерийн барилга, байгууламжийг иж бүрэн оновчтой шийдэх.
3. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахын тулд хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцооны үндсэн элемент болох дэд бүтцийн хөгжил болон ирээдүйд хэлбэршин тогтох олон нийт, нийгэм ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж, архитектур-орон зайн хөгжлийн чиг хандлага, байгалийн эрдэс

түүхий эд, байгаль экологийн тэнцвэрт байдал, хүрээлэн буй орчныг ашиглах, хамгаалах арга замыг урьдчилан тодорхойлно.

4. Хүн амын багтаамжийг энэхүү нормын заавал мөрдөх 6 дугаар хавсралтын дагуу тооцно.

1.7. Хот, тосгоны нутаг дэвсгэрийг зонхилох ашиглалтын зориулалтаар нь суурьшлын, үйлдвэрийн, амралт зугаалгын, хот орчмын нутаг дэвсгэр гэж ангилна.

Суурьшлын нутаг дэвсгэрт. Үйлчилгээний зохистой хүрээ бүхий орон сууцны хороолол, архитектурын хувьд өвөрмөц, төгс зохиомжтой дээд зэрэглэлийн сууцны хороолол, инженерийн бүрэн болон хэсэгчилсэн хангамжтай жижиг сууцны хороолол, орон сууцны бүлэглэл, жижиг сууц, жижиг, дунд үйлдвэрлэл-үйлчилгээ хосолсон сууцны бүлэглэл, гэр хороолол, хүн амын өдөр тутмын хэрэгцээний соёл, ахуй үйлчилгээний барилга байгууламж, цогцолборууд, ариун цэвэр-эрүүл ахуйн хувьд байгаль орчинд халгүй жижиг, дунд үйлдвэр, хувь хүний болон хэсэг бүлгийн сонирхолд нийцсэн, төрөл бүрийн насны хүн амд зориулсан олон нийтийн үйлчилгээний газар, нийтийн хэрэгцээний цэцэрлэгт хүрээлэн, зам талбай, спортын байгууламж, инженерийн дэд бүтцийн байгууламжийг байрлуулахад зориулагдана.

Үйлдвэрийн нутаг дэвсгэрт: Үйлдвэрийн болон хотын нийтийн аж ахуйн агуулахын зориулалттай барилга байгууламж, үйлдвэрлэлийн цогцолбор, тэдгээрийн туслах барилга, ажиллагсадын соёл, ахуйн үйлчилгээний барилга байгууламж байрлахын зэрэгцээ зам тээврийн үйлчилгээ, эрчим хүч, инженерийн шугам сүлжээний байгууламжуудийг байрлуулна .

Ландшафт-амралтын нутаг дэвсгэрт: Хот орчмын ой, ойн хамгаалах зурвас, амралт сувилалын газар, усан сан, цэцэрлэгт хүрээлэн, цэнгэлдэх хүрээлэн, спортын цогцолбор бүхий орон зайн задгай орчин хамрагдана.

Хот орчмын нутаг дэвсгэрт: Нисэх онгоцны буудал, төмөр замын өртөө, зуслан, амралт-сувилалын газар, хотын чанартай агуулах, зоорь, хог хаягдлын цэг, шарилын газар, унд, ахуйн усны эх үүсвэрийн худгууд, цэвэрлэх байгууламж, газар тариалан, фермерийн аж ахуй зэрэг бусад туслах чанарын аж ахуй хамрагдана.

1.8. Дээрх ангиллын нутаг дэвсгэр бүрт орон сууцны, олон нийтийн, төвийн, үйлдвэрийн, шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн, нийтийн аж ахуйн, агуулахын, зам тээврийн, олон нийтийн амралт зугаалгын, амралт-сувилалын, тусгай хамгаалалттай газар нутгийн зэрэг хүн амын аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан үүрэг зориулалтын бүсчлэлийг тогтооно. Тайлбар:

1. Эрүүл ахуй, ариун цэврийн нормын шаардлагыг хангасан нөхцөлд төрөл бүрийн чиглэлийн үйл ажиллагаатай үйлдвэрлэл үйлчилгээний барилга байгууламжийг нэгдсэн эдэлбэр газарт төлөвлөхийг зөвшөөрнө.

2. Байгалийн аюултай үзэгдэл, гамшиг тохиолддог газарт хот тосгоны газар нутгийг эрсдлийн зэргээр нь ангилан бүсчилж, урьдчилан сэргийлж хамгаалах арга хэмжээг хот, тосгоны эдэлбэр газарт авах бөгөөд эрсдэл өндөртэй газарт цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбай зэрэг барилгажилт багатай бүс төлөвлөнө.

3. Газар хөдлөлийн идэвхитэй бүсэд байрладаг хот, тосгоныг өргөтгөх болон шинээр барих барилгажилтыг төлөвлөхдөө газар хөдлөлийн бичил мужлалын зураглалыг үндэслэж аль болох аюул багатай орчныг сонгоно.

4. Инженер геологийн хүнд, төвөгтэй нөхцөлтэй бүсэд баригдах хот, тосгоны барилгажилтын эдэлбэр газрыг инженерийн бэлтгэл арга хэмжээнд хамгийн бага өртөг зарцуулах нутаг дэвсгэрийг сонгон төлөвлөнө.

1.10. Хот, тосгоны орон зайн төлөвлөлтийг боловсруулахад нутаг дэвсгэрийн зориулалтын бүсчлэлийг оновчтой тогтоох, эдгээр бүсүүд нь хоорондоо болон олон нийт, нийгмийн үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламжийн архитектур, тээврийн болон инженерийн дэд бүтэцтэй уялдан зохицсон байх, түүхэн явцад бүрэлдэн тогтсон хотын архитектур-орон зайн тогтолцооны уламжлал, байгаль, цаг уур, физик газар зүй, газар хөдлөлийн бичил мужлалын онцлог, инженер-геологи, гидрогеологи, экологи, хүрээлэн буй орчны нөхцөл, орчны ландшафт, хүн амын үндэсний зан заншил, түүх, соёлын дурсгалт байгууламж, тохиолдож болох байгалийн гамшиг зэрэг асуудлыг иж бүрэн авч үзнэ.

Тайлбар:

1. Газар хөдлөлийн идэвхитэй бүсэд баригдах хот, тосгоны барилгажилтын эзлэхүүн-орон зайн зохиомж, хүн амын төвлөрөл ихтэй объектууд, тэсэрч дэлбэрэх барилга байгууламжийн байршлыг газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх норм ба дүрэм (БНБД 22-01-01) болон холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр төлөвлөнө.
2. Түүх, соёлын дурсгалт байгууламжийг хот, тосгоны сэргээн засварлах иж бүрэн хөтөлбөрийн үндсэн дээр хөгжүүлэхээр тооцож төлөвлөнө.
3. Хот, тосгоны хөгжлийн төслийг боловсруулахдаа өндөр настан, тахир дутуу иргэдийн хотын орон зайд зорчих асуудлыг холбогдох техникийн баримт бичиг болон энэхүү нормын 18 дугаар хавсралтын дагуу төлөвлөнө.

1.11. Их хот, том хотын нутаг дэвсгэрийн газар доорхи орон зайд хотын тээвэр, худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээний болон агуулахын барилга байгууламж, үзвэрийн ба спортын тухайлсан байгууламж, инженерийн тоног төхөөрөмжийг байрлуулахаар тооцож төлөвлөхийг зөвшөөрнө.

1.12. Хот, тосгоны эдэлбэр газрын хилийн цэсээс гаднах орчинд нөөц нутаг дэвсгэр, хотын нийгмийн хангамж, дэд бүтцийн болон ХАА-н цогцолборууд байрлахаар; хот, тосгоны орчмын бүсэд хотын хүн амын түр хугацааны амралт-зугаалгын бүсийг байгуулж, хотын бичил уур амьсгалыг сайжруулах нөлөө бүхий усан сан, цэцэрлэгжүүлсэн бүстэй байхаар төлөвлөнө. Хот орчмын бүсийн хилийн цэсийг дагуул хот, бүлэг суурин хоорондын харилцан таталцлын оновчтой хүрээг тогтоосны үндсэн дээр цогц нэгдмэл байхаар төлөвлөнө.

Тайлбар:

1. Нийтийн тээврийн хэрэгслээр 45 минутаас ихгүй хугацаанд зорчин хүрэх хот орчмын бүсэд эдлэн газартай болон эдлэн газаргүй жижиг сууцны хорооллыг төлөвлөж болно.
2. Хөдөөгийн тосгоны хот байгуулалтын хөгжлийн төслийг боловсруулахдаа түүнд хамааралтай бүлэг суурин болон хөдөө аж ахуйн эдэлбэр газрын хөгжлийн асуудлыг нэгтгэн авч үзнэ.

Хоёр. Суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийн төлөвлөлт

2.1. Суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийн орон зайг шинээр буюу шинэчлэн төлөвлөхдөө архитектур-орон зайн хөгжлийн түүхэн явцад бүрэлдэн тогтсон залгамж чанар, инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх шинэ хандлага, орон сууцны бүсийг иж бүрэн шинэчлэх, нийгмийн дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх, байгалийн үзэсгэлэнг хүн амд ойртуулах, төрөл бүрийн насны хувь хүний болон хэсэг бүлгийн сэтгэл зүйн хэрэгцээнд зохицсон нийтийн үйлчилгээний газар, зах зээлийн элементүүдийг байгуулах, суурьшлын барилгажилтад гүн нэвтэрсэн цэцэрлэгжилтийн нэгдсэн систем бий болгох, оюун ухаан, бие бялдараа хөгжүүлэх, олон нийтийн амралтын газар хамрагдан чөлөөт цагаа өнгөрүүлэх зэрэг хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах нутаг дэвсгэр, архитектур-орон зайн орчин бий болгох асуудлыг иж бүрэн авч үзнэ. Суурьшлын бүсийн архитектур-орон зайн төлөвлөлтийг боловсруулахдаа энэхүү нормын 4, 5, 6 дугаар хавсралтуудыг тус тус дагаж мөрдөнө.

Тайлбар:

1. Бичил хороолол, орон сууцны бүлэглэл болон хэд хэдэн бичил хороололос бүрдсэн орон сууцны хорооллыг сэргээн шинэчилж хөгжүүлэх төслийг боловсруулахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - а) Бичил хорооллын эдэлбэр газрыг тэлэхгүйгээр нягтруулан төлөвлөх;
 - б) Орон сууцны хорооллын эдэлбэр газрын хэмжээ 250 га хүртэл байх;
 - в) Орон сууцны хорооллын бүрэлдэн тогтсон архитектур - орон зайн зохиомжийн уламжлалт төрхийг аль болохоор хадгалах зарчмыг баримтлан орчинтой нь уялдуулах,
 - г) Гудамж, замын сүлжээг оновчтой болгон цэгцэлж, хүн амын нийгмийн дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээний хүрээг ойртуулах,
 - д) Дэвсгэр газрын ашиглалтыг сайжруулах.
2. Гэр хорооллыг нам давхар сууцны хорооллын нэгэн адил энэхүү нормын 8 дугаар хавсралт ёсоор, бүх төрлийн үйлчилгээтэй нь хамт ариун цэвэр-эрүүл ахуйн шаардлага хангасан, ундны усны нөөцтэй орчинд байрлуулж, 1000 хүнд 22 га-гаас багагүй нутаг дэвсгэр ногдохоор тооцож төлөвлөнө.
3. Шинээр барих орон сууцны иж бүрэн хорооллын нутаг дэвсгэрийг 80 га хүртэлх талбайд төлөвлөнө.
4. Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын үйлчлэх хүрээг энэхүү нормын 7 дугаар хүснэгтэд зааснаар төлөвлөнө.
5. Орон сууцны барилга байгууламжийн үлдээх, буулгах хэмжээг тухайн барилга байгууламжийн эдийн засгийн үзүүлэлт, түүхийн үнэлэмж болон техникийн үзүүлэлт, сууцны ашиглалтын байдал, орчных нь түүхэн нөхцөл байдлыг харгалзан тогтооно.
6. Суурьшлын бүсийн цахилгаан соронзон туяаны цацралтын хэмжээг ариун цэврийн нормын дагуу төлөвлөнө.

Бүрэлдэн тогтсон орон сууцны барилга байгууламж, барилгажилтын орчинг иж бүрэн өргөтгөж, шинэчлэх төслийн даалгаврыг нормативын шаардлагын хүрээнд боловсруулж, холбогдох төрийн захиргааны байгууллагуудтай тохиролцон шийдвэрлэнэ. Энэ зөвшилцлийн баримт бичигт БНБД 21-01-02, БНБД 21-02-02 болон энэхүү нормын заавал мөрдөх 4 дүгээр хавсралтын шаардлагыг тусгасан байна.

2.2. Хот, тосгоны суурьшлын бүсийн архитектур-орон зайн зохиомжийг энэхүү нормын заавал мөрдөх 5, 6 дугаар хавсралт ёсоор шинэчлэн өргөтгөх, шинээр барих орон сууцны төрөл, хэв шинж, давхрын тоог тогтоож сууцны эдэлбэр газрын хэмжээ, нягтралыг газрын үнэ, газар эдэлбэрийн хуультай уялдуулан төлөвлөнө. Суурьшлын бүсэд шаардагдах дэвсгэр газрын урьдчилсан хэрэгцээг 1000 хүн тутамд ногдох талбайгаар тодорхойлох бөгөөд энэ нь орон сууцны барилгын дундаж давхар нь 3 хүртэл бол эдэлбэр газаргүй барилгад 10 га, эдэлбэр газартай бол 15 га, 4-8 давхар барилгад 8 га, 9 ба түүнээс дээш давхар барилгад 7 га байна. Харин уур амьсгалын I, II А бүсэд дурдсан үзүүлэлтийг 30 хүртэл хувиар бууруулан төлөвлөхийг зөвшөөрнө.

Суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийн сууцны хэсгийг газар зохион байгуулалтын 2 түвшинд төлөвлөнө.

Тайлбар: Хотын суурьшлын бүсийн нутаг дэвсгэр нь 250 га-гаас ихгүй талбайтай, хоорондоо 100 м-ээс багагүй өргөнтэй гол зам буюу ногоон зурвасаар тусгаарлагдсан хэд хэдэн хорооллуудаас бүрдэхээр төлөвлөнө.

2.3. Суурьшлын бүсийг зонхилох салхины эхэнд, үйлдвэр, аж ахуйн бүсийг салхины дор байрлуулан төлөвлөнө.

2.4. Суурьшлын бүсийн эдэлбэр газрын хэмжээг өрх бүр тусдаа сууцтай байхаар тооцож, тодорхойлно. Сууцны хэрэгцээг барилгынх нь хэв шинж, шинээр барихаар төлөвлөж буй сууцны нийт хэмжээ, өрхийн гишүүдийн тооны дундаж үзүүлэлтийг үндэслэн тооцож тогтооно. Сууцны барилгын эдэлбэр газрын талбайг БНБД 31-01-01- ийн шаардлагын дагуу төлөвлөнө.

2.5. Нам давхар сууцны хорооллыг дараах зарчимаар байрлуулан төлөвлөнө. Үүнд:

- Хот, тосгоны барилгажилтанд тохиромж муутай, тухайн үед ашиглагдаж байгаа нягтрал багатай болон сэргээн засварлаж буй барилгажилтын нутаг дэвсгэрт;
- Хотын дүүргийн орон зайд хамаарах захын нөөц нутаг дэвсгэр буюу хотын төвөөс тээврийн хэрэгсэлээр 30-40 мин хүртэлх хугацаанд зорчин очих жижиг суурин газарт;
- Жижиг орон сууцыг олон давхар барилга барьж хөгжүүлэх орон зайн орчинд байрлуулахгүйгээр тооцох, гадна орчныг нь иж бүрэн тохижуулж, инженерийн төвлөрсөн хангамжтай, өдөр тутмын нийгмийн дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээний хамгийн зохистой хүрээг хангахаар тооцож төлөвлөнө.

2.6. Орон сууцны барилгажилтын давхрын тоо хэмжээг архитектур эзэлхүүн- орон зайн зохиомж, нийгэм ахуйн, эрүүл ахуйн, хүн амын амьдралын хэрэгцээ, барилгын баазын онцлог, инженерийн тоног төхөөрөмжийн түвшинг харгалзан техник-эдийн засгийн тооцоог үндэслэн тодорхойлно.

2.7. Их хот, том, дунд хотын дүүргийн нутаг дэвсгэр болон 250 га хүртэлх эдэлбэр газартай суурьшлын бүс, бага хот, тосгоны нийт нутаг дэвсгэрийг хамруулан үйлчилгээний зохистой хүрээ бүхий орон сууцны хороололтой уялдаатайгаар худалдаа, үйлчилгээ амралт зугаалгын бүс, цэцэрлэгт хүрээлэн, соёл, спорт, олон нийтийн байгууламж бүхий архитектур-орон зайн нэгдсэн чуулбар үүсгэсэн нийтлэг үйлчилгээний цогцолбор төв төлөвлөж болно.

Тайлбар: Хотын нийтлэг үйлчилгээний цогцолбор төв нь архитектур-орон зайн зохиомжийн дараах зарчимтай байна. Төвийг бүрдүүлэгч элементүүд нь өөр хоорондоо гудамж замаар

БНБД 30.01.04

холбогдсон нутаг дэвсгэрийн зохион байгуулалттай, харилцан таталцсан орон зайн нэгдсэн чуулбар байна. Энэ төвд түүх соёлын дурсгалт байгууламжийг хамруулан төлөвлөж болно.

- 2.8. Орон сууцны бичил хороолол, сууцны бүлэглэлийн эдэлбэр газарт нэвтрэх тээврийн хэрэгслийн орц, үргэлжилсэн барилгын доогуур нэвт гарах гарцын хоорондын зайг 300м-ээс ихгүйгээр, харин сэргээн шинэчилж байгаа, хүрээ маягаар барьсан барилгажилтын тухайд энэ зай 180м-ээс ихгүй байна. Эдгээр орц нь хөдөлгөөний зохицуулалттай гол гудамж, замын зорчих хэсэгтэй огтлолцохдоо замын уулзварын тээврийн хэрэгслийг зогсоох тэмдгээс 50 м-ээс багагүй, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолоос 20 м-ээс багагүй зайд огтолцоно.

Орон сууцны хорооллын болон нийтлэг үйлчилгээний цогцолбор төвийн барилга байгууламжид үндсэн, туслах гудамж замаар, бусад барилга байгууламжид хоёрдогч туслах гудамж замаар дамжин очихоор төлөвлөнө. Эдгээр замын хэмжээг энэхүү нормын 10 дугаар хүснэгтэд зааснаар төлөвлөнө.

Орон сууцны хорооллын эдэлбэр газарт 2 зурвастай зам төлөвлөнө. Барилгын орцын орчинд замын өргөн 5.5 м-ээс багагүй байна.

Төгсгөлдөө эргэх талбайтай мухар замын урт 150 м байж болно. Энэ замын төгсгөлийн талбай нь машин эргэх боломжтой байх ёстой.

Явган хүний болон унадаг дугуйн зам нь тээврийн хэрэгсэл зорчих хэсгийн замын түвшинээс 15 см өндөр өргөгдсөн байна. Явган хүний зам болон унадаг дугуйн зам, туслах замтай огтлолцох буюу ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдийн байгуулагад очих орчны гол замтай огтлолцох хэсэгтээ нэг түвшинд байх бөгөөд налууугийн урт нь 1.5 ба 3.0 м байна.

Тайлбар: Тахир дутуу иргэдэд үйлчлэх замын төлөвлөлтийг энэхүү нормын зөвлөмжийн 18 дугаар хавсралтад зааснаар төлөвлөнө.

- 2.9. Хот, сууринд барих нам давхар сууц болон тухайлсан жижиг сууцны эдэлбэр газрын хэмжээг холбогдох төрийн захиргааны байгууллагын шийдвэрт үндэслэн тухайн үеийн онцлогт тохируулан төлөвлөнө. Эдгээр сууцны эдэлбэр газрын хэмжээг тогтоохдоо хотын нутаг дэвсгэрийн багтаамжаас хамааруулан хотын орон зайн зохиомжийн онцлог, сууцны барилгын хэв шинж, барилгажуулах орчны шинж чанарыг тооцож, энэхүү нормын зөвлөмжийн 8 дугаар хавсралтыг баримтлан төлөвлөнө.

- 2.10. Орон сууцны хорооллын ногоон бүсийн нэг хүнд ногдох талбай 6 м^2 -аас багагүй байна. Энэ тооцоонд ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын барилгын эдэлбэр газрын талбай хамаарахгүй.

Барилгын уур амьсгалын I бүс болон IIБ дэд бүсэд байрлах орон сууцны хорооллын нэг хүнд ногдох цэцэрлэгжүүлсэн талбай 3 м^2 -аас багагүй, харин IIА дэд бүсэд энэ талбайн хэмжээ 5 м^2 -аас багагүй байна.

Тайлбар: Орон сууцны хорооллын ногоон бүсэд амралтын, хүүхдийн тоглоомын, явган замын талбайг оруулан тооцох ба нийт эзлэх талбай нь ногоон бүсийн талбайн 30 хувиас ихгүй байна.

- 2.11. Орон сууц хоорондын, орон сууц олон нийтийн барилга байгууламж хоорондын болон орон сууц, үйлдвэрийн барилга байгууламж хоорондын нарны тусгалд хамааралтай зайг энэхүү нормын 9.19 дүгээр зүйлд заасны дагуу, харин барилга хоорондын нарны гэрэлтүүлгийн үргэлжлэх хугацааг холбогдох норм дүрмийн дагуу, галын аюулаас хамгаалах шаардлагыг БНБД 21-01-02 болон энэхүү нормын 4 дүгээр хавсралтанд зааснаар тус тус төлөвлөнө. 2-3

давхар сууцны барилгын тууш талуудын хоорондхи зай 15м-ээс багагүй, 4 давхар бол 20м-ээс багагүй, харин ийм барилгын тууш болон хөндлөн талуудад байрлалтай сууцны өрөөний цонхнуудын хоорондхи зай 10 м-ээс багагүй байх ёстой. Хэрэв зэрэгцээ хоёр барилгын сууцны ба гал тогооны өрөө хооронд цонхоор нэвт харагдахгүй байдал хангагдсан нөхцөлд нарны гэрэлтүүлгийн нормын шаардлагад зохицуулан хоёр барилгыг хооронд нь ойртуулан байрлуулж болно.

Тайлбар: Жижиг сууцны барилгын сууцны өрөө, гал тогоо болон шиллэсэн тавцангийн цонхноос туслах аж ахуйн пин, гараж, халуун усны барилгын хана хүртэлх зай ариун цэвэр-эрүүл ахуйн шаардлагын дагуу 6м-ээс багагүй байх ёстой. Туслах аж ахуйн зориулалттай барилгуудыг эдэлбэр газрын хилээс 1м-ээс багагүй зайд байрлуулна.

- 2.12. Сууцны болон олон нийтийн барилга байгууламжийн эдэлбэр газрын нэг хүнд ногдох талбай, эдэлбэр газар дахь барилгын хана, цонх хүртэлх зайг 2 дугаар хүснэгтэд зааснаас ихгүйгээр төлөвлөнө.

2 дугаар хүснэгт

Талбай	Талбайн хувийн жин м ² /хүн	Талбайгаас сууцны ба олон нийтийн барилга хүртэлх зай, м
Сургуулийн өмнөх насны болон бага ангийн хүүхэд тоглох Насанд хүрэгчдийн амрах	0.7 0.1	12 10
Биеийн тамирын талбай Аж ахуйн зориулалтад ашиглах	2.0 0.3	10 20
Автомашин зогсоолд зориулагдсан	0.8	энэхүү нормын 10-р хүснэгтэд зааснаар

Тайлбар:

- Биеийн тамирын талбай хүртэлх зайг орчинд нөлөөлөх дуу шуугианы тооцоог үндэслэн тогтооно. Цагаан хэрэглэл хатаах талбай хүртэлх зайг нормчлохгүй. Хогийн савнаас биеийн тамирын, хүүхдийн тоглоомын, насанд хүрэгчдийн амрах талбай хүртэлх зай 20м-ээс багагүй, аж ахуйн зориулалттай талбайгаас сууцны хамгийн алсын орц хүртэлх зай 100м-ээс ихгүй байна.
- Дээр дурьдсан талбайн хувийн жинг холбогдох тооцоог үндэслэн 50%-иас ихгүйгээр багасгахыг зөвшөөрнө.

- 2.13. Нэгдүгээр давхартаа орон сууцтай барилгыг улаан шугам тавих зааврын дагуу улаан шугамаас зай авч байрлуулна. Нэгдүгээр давхарт буюу залгаж барьсан барилгад нийгмийн үйлчилгээний цэг салбартай орон сууцны барилгыг гудамжны улаан шугаманд тулгаж байрлуулахыг зөвшөөрнө. Мөн сэргээн шинэчилж байгаа хороололд нэгдүгээр давхартаа орон сууцтай барилгыг улаан шугамын дагуу байрлуулахыг зөвшөөрнө. Эдлэн газартай сууцны хороололд хувийн сууцны байшинг тухайн орчных нь уламжлалыг хадгалан сууцны гудамж үүсгэх зарчмаар энэхүү нормын 8 дугаар хавсралтыг баримтлан улаан шугамын дагуу байрлуулж болно.

- 2.14. Орон сууцны хорооллын нутаг дэвсгэрийн 1 га-д ногдох хүн амын нягтралын тооцоог үндэслэн энэхүү нормын зөвлөмжийн 9 дүгээр хавсралтад заасан ёсоор суурьшлын бүсийн барилгажилтын төслийг төлөвлөнө. Гэхдээ хорооллын хүн амын тооцоот нягтрал 450 хүн/га-гаас ихгүй байх ёстой.

БНБД 30.01.04

- 2.15. Хот хоорондын чанартай автозам болон хөдөө аж ахуйн техник хэрэгсэл зорчих зам, мал тууврын замыг суурьшлын бүсийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрөхөөр төлөвлөхийг хориглоно.
- 2.16. Суурин газарт бие даасан эдэлбэр газартай хувийн тухайлсан болон 1-2 айлын орон сууц, мөн нийтийн зориулалттай орон сууц барихаар төлөвлөж болно. Тус бүрдээ эдэлбэр газартай олон айлын блокчилсон жижиг сууц төлөвлөхийг зөвшөөрнө. Харин 4 хүртэлх давхар сууцны барилгыг техник-эдийн засгийн тооцооны үндсэн дээр төлөвлөнө.
- 2.17. Суурин газрын орон сууцны барилга болон туслах аж ахуйд олгох эдэлбэр газрын хэмжээг газар эдэлбэрийн хуулийн дагуу холбогдох төрийн захиргааны байгууллага тогтооно.
- 2.18. Сууцны эдлэн газарт байх малын саравч, гэрийн тэжээвэр амьтдын байрнаас сууцны өрөөний цонх хүртэлх зай 12.0 м-ээс багагүй байна.

Тайлбар: Хэрэв малын саравч, гэрийн тэжээвэр амьтдын байр нь бүлэглэсэн бол бүлэгт байх тооноос нь хамааруулан тогтооно. Үүнд: бүлэгт байх саравчны тоо 1 буюу 2 үед 15 м-ээс багагүй, 3-аас 8 хүртэл бол 25 м, 8-аас 30 хүртэл бол 50 м, 30 –аас дээш бол 100 м байна.

Хөдөөгийн суурин дахь секцлэн барьсан орон сууцанд оршин суугчдын мал аж ахуйд зориулсан эдлэн газар болон мал аж ахуй эрхэлдэг аж ахуйтны хорооллыг суурьшлын бүсийн гадна орчинд төлөвлөнө. Секцлэн барих сууцны барилгын зэрэгцээ эсвэл газар доор нь зургийн даалгаварыг үндэслэн хүнсний бүтээгдэхүүний нэгдсэн агуулах байхаар төлөвлөж болно. Малыг байрны блокчлон барих саравчны талбай 800 м²-аас их байж болохгүй. Саравчийг энэхүү нормын 4 дүгээр хавсралтын 1 дүгээр хүснэгтэд заасны дагуу төлөвлөнө.

Тайлбар: Хот, тосгоны орон сууцны барилгын эдэлбэр газарт барих аж ахуйн зориулалттай барилгыг БНБД 21-01-02, БНБД 31-01-01-ийн дагуу төлөвлөнө.

- 2.19. Хот, тосгоны суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийн 1 га-д ногдох хүн амын нягтралыг энэхүү нормын зөвлөмжийн 10 дугаар хавсралт ёсоор төлөвлөнө.

Гурав. Үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрийн төлөвлөлт

- 3.1. Үйлдвэрийн болон хотын нийтийн аж ахуйн агуулахын бүсийн орон зайн зохиомжийг төлөвлөхдөө үйлдвэрийн болон нийтийн аж ахуйн агуулахын барилга, туслах барилгын үүрэг зориулалт, хүчин чадлыг нарийвчлан тогтоож, цаашид хөгжүүлж, өөрчлөн байгуулах шинэ хандлагыг дэд бүтэц, инженерийн байгууламжтай нь уялдуулан нутаг дэвсгэрийг технологи, ариун цэвэр-эрүүл ахуйн, галын шаардлагын дагуу бүсчилж, ажиллагсадын ажиллах, амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх таатай орчинг бүрдүүлэх асуудлыг иж бүрэн авч үзнэ.
- 3.2. Үйлдвэрийн ба суурьшлын бүсийн хоорондын уялдааг үйлдвэрийн ажилчид ажилдаа хамгийн бага хугацаа зарцуулан ирэх оновчтой хүрээлэлд байхаар тооцож төлөвлөнө. Үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрийн хэмжээг тогтоох, түүнийг эрчимтэй ашиглах төлөвлөлтийг хийхдээ тухайн бүсийн хотын орон зайн бүтэц дэх байршлын онцлог, түүний газар нутгийн хот байгуулалтын үнэ цэнэтэй уялдуулан барилгажилтын давхрын хэмжээг нэмэгдүүлэх, газар доорхи орон зайг ашиглах зэргээр оновчтой төлөвлөнө.
- 3.3. Үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрийн үүргийн бүсчлэл, зохион байгуулалтыг үйлдвэрийн барилгыг төлөвлөх норм дүрэмд заасны дагуу тухайн байгууллагын салбарын онцлогийг харгалзан үндсэн болон туслах үйлдвэрлэлийн ашиглалт, зориулалтанд нь тохируулан

төлөвлөх бөгөөд тэдгээрийн байршлыг тогтоохдоо эрүүл ахуй-ариун цэврийн хамгаалалтын бүс, гал түймрийн аюулаас хамгаалах шаардлага, ачаа тээврийн эргэлтийн хэмжээ, барилгажилтын ээлж дарааллыг тооцно.

- 3.4. Үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрийн 60-аас доошгүй хувийг үйлдвэр, үйлдвэрлэлийн бүс дэх нийгмийн үйлчилгээний болон туслах барилга байгууламж эзлэх ёстой.

Тайлбар:

1. Үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрийн ашиглалтын хувийн жинг гаргахдаа үйлдвэр, түүнтэй холбоотой барилга байгууламжийн эдэлбэр газрын талбайн нийлбэр дээр үйлчилгээний барилгуудын болон төмөр замын өртөөний эдэлбэр газрын талбайг нэмсэн нийлбэрийг хотын ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлогдсон үйлдвэрийн бүсийн нийт талбайд харьцуулсан хувиар гаргана. Үйлдвэрийн эдэлбэр газарт үйлдвэрийг өргөтгөх нөөц талбайг оруулсан байна.
2. Үйлдвэрийн газрын эдэлбэр газрын норматив хэмжээг тодорхойлохдоо уг үйлдвэрийн барилгажсан талбайг үйлдвэрийн газрын ерөнхий төлөвлөгөөний нормд заасан тухайн үйлдвэрийн нормативт нягтралд харьцуулсан харьцаагаар тодорхойлно. Мөн ажиллах хүчний нягтралын шалгуур үзүүлэлтүүдийг хэрэглэж болно. Үүнд:

- 30-60 ажилчин/га (цемент, тоосго, элсэн чихэр, сүлжмэлийн үйлдвэрүүдэд гэх мэт.);
- 150 ажилчин/га (төмөрлөг, зүсмэл, цаас, хүнсний үйлдвэрүүдэд гэх мэт.);
- 500 ажилчин/га (машин, цахилгаан хэрэгсэл, шилний үйлдвэрүүдэд гэх мэт.);
- 1000-1500 ажилчин/га (гутал, бэлэн хувцас, радиогийн үйлдвэрүүд гэх мэт.);
- Технологийн хувьд хорших үйлдвэрийн нэгжүүд;
- Хаягдал материалыг нөгөө үйлдвэр ашиглах зорилгоор хорших үйлдвэрийн нэгжүүд;
- Технологийн үйл явцаараа нэг нь нөгөөдөө сөргөөр нөлөөлөх үйлдвэрийн нэгжүүд.

- 3.5. Хорт бодис ялгаруулдаггүй, үйлдвэрлэлийн гал түймэр гарахгүй, тэсрэх бодисын аюулгүй үйл ажиллагаатай, нормын зөвшөөрөгдөх хэмжээнд дуу шуугиан гаргадаг, төмөр зам тавих шаардлагагүй болон бохирдолгүй үйлдвэр, аж ахуйн газруудыг хот, тосгоны суурьшлын бүсэд байрлуулахыг зөвшөөрнө. Гэхдээ үйлдвэрийн барилгын эдэлбэр газрын хилийн зурвас нь орон сууцны барилга, амралт зугаалгын бүс, эрүүл мэндийн байгууллага, сургууль, цэцэрлэгээс 50 м-ээс багагүй зайд байрлах шаардлагатай.

- 3.6. Үйлдвэрийн бүсийн ариун цэвэр-эрүүл ахуйн хамгаалалтын зурвасын талбайн хэмжээг эрүүл ахуйн нормын шаардлагыг баримтлан тогтоосны үндсэн дээр үйлдвэр, аж ахуйн газруудыг байршуулж энэхүү нормын 9 дүгээр бүлэгт заасны дагуу төлөвлөнө.

Тайлбар: Тэсэрч дэлбэрэх бодис үйлдвэрлэх үйлдвэр, түүнийг хадгалах агуулахыг тусдаа эдэлбэр газарт барьж байгуулах бөгөөд барилгажилтын төслийн даалгаврыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулна.

- 3.7. Ариун цэвэр-эрүүл ахуйн 1000 м-ээс багагүй өргөнтэй хамгаалалтын бүсээр суурьшлын бүсийн нутаг дэвсгэрээс тусгаарлагдсан үйлдвэрийн бүсэд, эрүүл ахуйн хамгаалалтын 100 м хүртэлх бүс бүхий хүнсний ба хөнгөн үйлдвэрийг оролцуулан төлөвлөхгүй.

- 3.8. Ариун цэвэр-эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд орон сууц, сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага, сургууль, эрүүл мэндийг хамгаалах байгууллага, амралт, биеийн тамирын байгууламж, цэцэрлэгт хүрээлэн болон цэцэрлэгжсэн талбай байрлуулахыг хориглоно.

- 3.9. Ариун цэвэр-эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн цэцэрлэгжүүлэх талбайн доод хэмжээг, тухайн бүсийн өргөнөөс нь хамруулан хувь(%) -иар тодорхойлно. Үүнд:

БНБД 30.01.04

300 м хүртэл	- 60
300-аас 1000 м хүртэл	- 50
1000-аас 3000 м	- 40

Уг бүсэд, суурьшлын бүс талаас 50 м-ээс багагүй өргөнтэй мод, сөөгний зурвас төлөвлөнө. Харин бүсийн өргөн 100 м хүртэл байвал түүний ногоон зурвасын өргөн 20м-ээс багагүй байна.

- 3.10. Үйлдвэрийн хог, хаягдал зайлуулах цэгийг зөвхөн уг хаягдлыг эргүүлэн ашиглаж болохгүй тохиолдолд байгуулна. Гэхдээ үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрт хог хаягдлын төвлөрсөн цэг байх ёстой. Хог хаях цэгийг үйлдвэрийн ба эрүүл ахуйн норм дүрмийг баримтлан гүний усыг хамгаалах II бүсийн гадна байрлуулан төлөвлөнө.

Нүүрс, занар, хүнцэл, хар тугалга, мөнгөн ус бусад шатамхай буюу хордуулах бодис агуулсан хаягдал хураах цэгийг орон сууц, олон нийтийн барилга байгууламжаас тусгай тооцоог үндэслэн тогтоосон зайд байрлуулна.

- 3.11. Үйлдвэрийн бүсэд тухайн үйлдвэрийн үйл ажиллагааны онцлог, хүчин чадлаас нь хамааруулан шинжлэх ухаан, туршилт-үйлдвэрлэлийн бүс төлөвлөнө. Энэ бүсэд шинжлэх ухаан, туршилт-үйлдвэрлэлийн барилга байгууламж, тухайн үйлдвэртэй холбоотой дээд, дунд сургууль, үйлчилгээний байгууллага, туршилтын үйлдвэрүүд, мөн инженерийн шугам сүлжээ болон тээврийн байгууламж байрлана.

Тайлбар: Эрдэм шинжилгээ, туршилт-үйлдвэрлэлийн газрыг байршуулахад орчинд нөлөөлөх бохирдлын сөрөг хүчин зүйлүүдийг тооцох ёстой.

- 3.12. Суурьшлын бүсэд байрлах эрдэм шинжилгээ, туршилт-үйлдвэрлэлийн бүсийн хүчин чадлыг техник-эдийн засгийн тооцооны үндсэн дээр тогтооно.

- 3.13. Шинжлэх ухаан, туршилт-үйлдвэрлэлийн байгууллагын эдэлбэр газрын хэмжээг барилгын нийт ашигтай талбайн 1000 м² тутамд доор зааснаас багагүй талбай (га) ногдохоор төлөвлөнө. Үүнд:

Байгалийн ба техникийн шинжлэх ухааны	0.14-0.2
Нийгмийн ухааны	0.1-0.12

Тайлбар: Эдэлбэр газрын тооцоонд туршилтын талбай, нөөц нутаг дэвсгэр, ариун цэврийн хамгаалалтын бүс ороогүй болно.

- 3.14. Нийтийн аж ахуй – агуулахын бүсэд хүнсний (талх, нарийн боов, мах ба сүүний) үйлдвэрүүд, өргөн хэрэглээний бүтээгдэхүүний (хүнсний ба хүнсний бус) тусгай зориулалтын агуулахууд (хөргөгч, төмс ногоо, жимсний), нийтийн тээврийн болон аж ахуйн үйлдвэр, үйлчилгээний газрууд байрлана. Хүн амын өдөр тутмын үйлчилгээнд ашиглагддаггүй агуулахуудыг их хот, том хотуудын барилгажилтын хилийн гадна, ихэвчлэн төмөр зам болон хот хоорондын замд ойр байрлуулна.

Улсын нөөцийн агуулах, нэгдүгээр группийн нефть болон нефтийн бүтээгдэхүүний дамжлага бааз, шингэн хийн агуулах, шатах дэлбэрэх материалын агуулах, хүчтэй хорт бодисуудын суурь агуулах, хүнсний бүтээгдэхүүний суурь агуулах, бордоо ба үйлдвэрийн түүхий эд, ойн болон барилгын материалын агуулахыг хот, тосгоны нутаг дэвсгэрийн хилийн гадна ба ногоон бүсэд, эрүүл ахуй, гал түймрийн аюулгүй байдлын норм дүрмийн шаардлагын дагуу тусгай зориулалттай агуулахуудын бүсэд байрлуулна.

Тайлбар:

1. Бага хот ба тосгоны хэрэгцээнд үйлчлэх төвлөрсөн агуулахуудыг бүлэг суурингийн төвд буюу замын өртөөний эдэлбэр газарт байрлуулна.

3.15. Хүн амын өдөр тутмын хэрэгцээний барааны агуулахын эдэлбэр газрын 1 хүнд ногдох талбайг доор зааснаас багагүйгээр төлөвлөнө. Үүнд:

- | | |
|---|--------------------|
| • Их хот, том хотод | 2 м ² |
| • Бусад суурин газарт | 2.5 м ² |
| • Амралт сувилалын хот, тосгонд | 6 м ² |
| • Ургамлын хүлэмжтэй амралт, сувилалын хот, сууринд | 8 м ² |
| • Нэг гэр бүлд | 4-5 м ² |

Гэр бүлийн хэрэгцээнд зориулах агуулахын аж ахуйн эдэлбэр газрын талбайг батлагдсан зургийн даалгаврыг үндэслэн тогтооно.

Тусгай зориулалтын болон өргөн хэрэглээний бүтээгдэхүүний агуулах, хүнсний ногоо, жимс жимсгэний агуулах, шатах тослох материал, барилгын материалын агуулахын эдэлбэр газрын талбайн хэмжээг энэхүү нормын зөвлөмжийн 11 дүгээр хавсралтын дагуу төлөвлөхийг зөвшөөрнө.

Тайлбар. Жимс жимсгэнэ, хүнсний ногооны агуулахын ариун цэврийн хамгаалалтын бүсийн хэмжээ 50 м байна.

3.16. Бага хот, тосгоны хөдөө аж ахуйн үйлдвэрийн барилга байгууламжийн байршил хоорондын зайг эрүүл ахуйн, мал эмнэлзүйн болон галын аюулгүйн шаардлага, технологийн төслийн нормын хүлцэх хамгийн бага хэмжээгээр авна. Харин хөдөө аж ахуйн үйлдвэрийн барилгажилтын талбайн нягтралыг хөдөө аж ахуйн барилгын төлөвлөлтийн норм дүрэмд зааснаас багагүй байхаар тооцож төлөвлөнө.

3.17. Цахилгаан дамжуулах шугам, холбооны шугам болон бусад орон нутгийн зориулалттай шугамуудыг зам дагуулж, тариан талбай, ойн зурвасын хил дагуу аль болохоор хөдөө аж ахуйн эдэлбэр газар дундуур дайрахгүй нутаг дэвсгэрт байрлуулж, төв шугамтай чөлөөтэй холбогдохоор төлөвлөнө.

3.18. Үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрийг хот, улсын чанартай төмөр зам, автомашины замаар хэрчүүлэн төлөвлөхийг хориглоно. Бага хот, тосгоны үйлдвэр, аж ахуйн бүсэд байрлах үйлдвэрийн объектуудын эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн өргөн нь 300 м-ээс багагүй байх ёстой. Төлөвлөлтийг энэхүү нормын 9 дүгээр бүлгийн шаардлагыг баримтлан гүйцэтгэнэ.

Дөрөв. Ландшафт – рекреацийн нутаг дэвсгэрийн төлөвлөлт

4.1. Хот, тосгоны цэцэрлэгжүүлэлтийг хүн амын ажиллаж амьдрахад тохиромжтой гоо зүй, ариун цэвэр – эрүүл ахуйн нөхцлийг хангасан, хотын орон зайн бичил уур амьсгалын тааламжтай орчинг бий болгож хүний үйл ажиллагааны элдэв хортой нөлөөллөөс хамгаалах, барилгажсан нутаг дэвсгэрийн архитектур-орон зайн зохиомжийг сайжруулсан байхаар тооцож, энэхүү нормын зөвлөмжийн 12 дугаар хавсралтын дагуу төлөвлөнө.

Хот, тосгоны цэцэрлэгжүүлэлтийг төлөвлөхдөө нийтийн хэрэгцээний, хязгаарлагдмал зориулалттай, тусгай зориулалттай гэсэн ангиллыг баримтлана.

а. Нийтийн хэрэгцээний ногоон байгууламжид хот, тосгоны нийтийн хэрэгцээний зориулалттай цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт төгөл, орон сууц, үйлдвэрийн хорооллын чанартай цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт талбай, цэцэрлэгт гудамж, модот гудамж болон зүлэгжүүлсэн гудамж хамрагдана.

БНБД 30.01.04

- б. Хязгаарлагдмал зориулалттай цэцэрлэгжүүлэлтэд сургууль, цэцэрлэг, ясли, эмнэлэгийн байгууллага, авто болон төмөр замын барилга байгууламжийн хамгаалалтын зурвас, иргэн, олон нийтийн барилгын эдэлбэр газрын цэцэрлэгжүүлэлт орно.
- в. Тусгай зориулалттай цэцэрлэгжүүлэлтэд: ботаник цэцэрлэг, орон сууцны хорооллыг үйлдвэрийн газраас тусгаарласан хамгаалалтын бүс, гудамж замын цэцэрлэгжүүлэлт, гуу жалга зэрэг хөрсний эвдрэл, элсний нүүлт зэргээс хамгаалсан ногоон суулгамал болон гол горхи, нуур цөөрмийн эргийн хамгаалалтын зурвас, хүчтэй салхи, элс, цасны хунгарлалтаас хамгаалсан ногоон байгууламж орно.

4.2. Хот, тосгоны нутаг дэвсгэрт цэцэрлэгжүүлсэн болон задгай орон зай хоршсон цогцолбор бүс төлөвлөх ёстой. Хот суурины барилгажсан нийт талбайн 40%-иас багагүй нь, сууцны хорооллын барилгажсан нутаг дэвсгэрийн 25%-иас багагүй нь цэцэрлэгжүүлсэн нутаг дэвсгэр байна. Энэ бүсэд бичил хорооллын цэцэрлэгжүүлсэн талбайг оруулан тооцно.

Тайлбар:

1. Ой, ойт хээрийн бүсийн нутаг, говь цөл, заримдаг цөлийн бүсийн барилгажсан нутаг дэвсгэрийн ногоон байгууламжийн талбайн хэмжээг зургийн даалгаврыг үндэслэн тогтооно.
2. 1 км-ээс дээш өргөнтэй ариун цэврийн хамгаалалтын бүс шаардагдах үйлдвэрүүдтэй хотуудад ногоон байгууламжийг нийт нутаг дэвсгэрийн 15 %-иас багагүй хэмжээгээр ихэсгэн төлөвлөхийг зөвшөөрнө.

4.3. Хот, тосгоны хүн амын суурьшлын бүсийн цэцэрлэгжүүлэх бүс, цэнгэлдэх хүрээлэн, цэцэрлэг, цэцэрлэгт гудамж, цэцэрлэгт талбайн нэг хүнд ногдох хэмжээг 3 дугаар хүснэгтэд зааснаар төлөвлөнө.

3 дугаар хүснэгт

Нийтийн хэрэгцээний ногоон байгууламж	Ногоон байгууламжтай талбай, м ² /хүн		
	Их хот, том хот	Дунд хот	Бага хот
Хотын чанартай цэцэрлэгт хүрээлэн	3	3	5
Хорооллын чанартай цэцэрлэгт хүрээлэн	2	2	-
Хороолол дүүргийн суурьшлын бүсийн цэцэрлэгт хүрээлэн	3	2	-
Бичил хорооллын ба хороолол дундын цэцэрлэгт хүрээлэн	3	2	2
Цэцэрлэгт талбай ба цэцэрлэгт гудамж	4	3	3
Нийт	15	12	10

Тайлбар:

1. Их хот, том хотын нутаг дэвсгэрийн хүрээний ойн паркийг хотын цэцэрлэгт хүрээлэнгийн бүтцэд хамруулан тооцож болно. Гэхдээ энэхүү хүснэгтэд заасан хэмжээг 5 м²-ээс ихгүйгээр нэмэгдүүлнэ.
2. Байгаль цаг уурын I, IV бүсэд барих хот суурины цэцэрлэгжүүлэх эдэлбэр газрын талбайг ой, ойт хээрийн бүсэд 2 м²-аас, говь цөл, хагас цөл, цөлийн бүсэд 20-30%-иас ихгүйгээр бууруулах, харин хээр, ойт хээрийн нутаг дэвсгэрт 10-20%-иар нэмэгдүүлэн төлөвлөхийг зөвшөөрнө.
3. Ойгоор хүрээлэгдсэн буюу том гол, усны сав газрын орчимд байрлах дунд, бага хот, тосгон, суурингийн цэцэрлэгжүүлэх талбайг 20%-иас хэтрүүлэхгүйгээр багасгаж төлөвлөхийг зөвшөөрнө.

4.4. Цэцэрлэгжүүлэх нийт нутаг дэвсгэрийн 10%-иас багагүй газар нь 0.5 км өргөнтэй цэцэрлэгт хүрээлэн, ойн парк байх ёстой.

Тайлбар: Хотын чанартай цэцэрлэгт хүрээлэнд тээврийн хэрэгсэл, ердийн хөсөг, явганаар очих хугацаа 20 минутаас хэтрэхгүй, дүүргийн чанартай цэцэрлэгт энэ хугацаа 15 минутаас хэтрэхгүй байх ёстой.

- 4.5. Ногоон бүс, ой, ойн бүс, цэцэрлэгт хүрээлэнд нэгэн зэрэг үйлчлүүлэх хүний тоог доор зааснаас ихгүйгээр тооцож төлөвлөнө (хүн/га). Үүнд:

Хотын цэцэрлэгт хүрээлэнд	100
Амралт, зугаалгын орчны цэцэрлэг, ногоон бүсэд	70
Амралт, сувилалын тосгоны ногоон бүсэд	50
Ойн төгөл, нуган төгөл, усан хүрээлэнд	10
Ойд	1-3

Тайлбар :

1. Уур амьсгалын IVA, IV Б, IVB дэд бүсэд буюу говь, заримдаг цөл, хагас цөлийн бүсэд энэ хэмжээг 20% бууруулахыг зөвшөөрнө. Харин хүрээгээр нь хөрс хамгаалах ногоон зурвас төлөвлөнө.
 2. Нэгэн зэрэг үйлчлүүлэгчдийн тоо 10-50 хүн/га хүртэл байх нөхцөлд хүмүүсийн хөдөлгөөнийг зохицуулах зам, талбайн захаар хөрсний суултаас хамгаалах арга хэмжээг төлөвлөнө.
- 4.6. Их хот, том хотод цэцэрлэгт хүрээлэнг хүүхдийн, биеийн тамирын, спортын, үзэсгэлэнгийн, ан амьтны ба бусад хүрээлэн, ботаникийн цэцэрлэг гэсэн төрөлжсөн байдлаар төлөвлөнө. Эдгээрийн бүтэц зохион байгуулалт, талбайн хэмжээг төслийн даалгаварыг үндэслэн тогтооно. Спортын байгууламжийг оролцуулан тооцсон хүүхдийн цэцэрлэгт хүрээлэнгийн нэг хүнд ноогдох талбайн хэмжээг 0.5 м²-аас багагүй байхаар тооцож төлөвлөнө.
- 4.7. Гоо зүй, танин мэдэхүйн үнэт зүйл бүхий байгалийн ландшафтыг хэвээр хадгалах өндөр зэрэглэлийн нутаг дэвсгэрт үндэсний ба байгалийн хүрээлэнг байгуулахаар төлөвлөхийг зөвшөөрнө. Үндэсний ба байгалийн хүрээлэнгийн нутаг дэвсгэрийн архитектурын орон зайн зохион байгуулалтыг шинжлэх ухаан, соёл судлалын, дархан цаазат-амралтын, амралтын болон дархан цаазат хэсгийн аж ахуйн бүс гэж ангилан төлөвлөнө.
- 4.8. Хот, тосгоны нутаг дэвсгэрт байгалийн ландшафт(тухайлбал усан сан, мод ургамал зэрэг)-ыг ашиглан цэцэрлэгт хүрээлэнг байгуулна. Ногоон байгууламжийн эдэлбэр газрын талбайн болон орон зайн хэмжээ, хүрэлцэн очих хугацааг 4 дүгээр хүснэгтэд зааснаас багагүйгээр төлөвлөнө.

4 дүгээр хүснэгт

Ногоон байгууламжийн төрөл	Байршил	Талбай, га	Радиус, км	Очих хугацааны хамгийн их цаг
Хотын чанартай цэцэрлэгт хүрээлэн	Суурьшлын бүсэд	15	5	Унаагаар 20 мин
Тусгай зориулалтын цэцэрлэгт хүрээлэн	Суурьшлын бүсэд эсвэл түүнтэй зэргэлдээ	3	Нормчлохгүй	
Дүүргийн чанартай цэцэрлэгт хүрээлэн	Дүүргийн нутаг дэвсгэрт	10	2	Унаагаар 10 мин
Орон сууцны хороолол дундын цэцэрлэгт хүрээлэн	Орон сууцны хорооллын доторхи нутаг дэвсгэрт	3	1	явган 15-20 мин
Бичил хороолол ба хорооллын цэцэрлэгт хүрээлэн	Орон сууцны барилгын дундах	1	0.5	явган 5-7 мин
Цэцэрлэгт талбай	Барилгуудын дундах	0.5		
Цэцэрлэгт гудамж	2 урсгалтай гудамжны дундах	өргөн нь 18-50 м		

БНБД 30.01.04

4.9. Нийтийн хэрэгцээний нутаг дэвсгэрийг усан оргилуур, усан сан, шат, налуу зам, саравч, гэрэлтүүлэг зэрэг архитектурын жижиг хэлбэрээр тоноглож тохижуулан төлөвлөнө. Гэрэлтүүлгийн тоог нормоор тодорхойлно.

Хот, тосгонд тарих мод, ургамлын нэр төрөл, бут сөөг хоорондын зай болон хөрс сайжруулах үндсэн арга хэмжээг энэхүү нормын зөвлөмжийн 12 дугаар хавсралтын дагуу төлөвлөнө.

Ногоон зурвасын өргөнийг 5 дугаар хүснэгтэд зааснаас ихгүйгээр төлөвлөнө.

5 дугаар хүснэгт

Ногоон зурвас	Өргөний хэмжээ (м-ээр)
1. Эгнээ мод буюу мод сөөг	
а. нэг эгнээ суулгах	2
б. хоёр эгнээ суулгах	5
2. Нэг эгнээ сөөг:	
а. өндөр (1.8 метрээс өндөр)	1.2
б. дунд зэргийн (1.2-1.8 м)	1.0
в. намхан (1.2 метр хүртэл)	0.8
3. Бүлэглэж тавьсан	
а. мод	4.5
б. сөөг	3.0
4. Зүлгэн зурвас	1.0

Тайлбар: Олон эгнээ сөөг тарих тохиолдолд зурвасын өргөний хэмжээг эгнээ бүрд 40-50%-иар ихэсгэн төлөвлөнө.

4.10. Амралтын бүсийн замын сүлжээ, явган замын хөдөлгөөний чиглэлийн дагуух урсгалыг аль болох бага налуутай байхаар тооцож, түүнээс нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол, тоглоомын болон спортын талбайд хамгийн дөт зайнд явж хүрэхээр төлөвлөнө. Нэг хүнд ногдох явган замын зурвас бүрийн өргөний доод хэмжээ 0.75 м байх ёстой. Амралтын бүсийн талбай, замыг бат бэх материалаар хучна.

4.11. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээнээс мод, бут сөөгийн тэнхлэг хүртлэх зайн доод хязгаарыг 6 дугаар хүснэгтэд заасны дагуу төлөвлөнө.

6 дугаар хүснэгт

Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ	Барилга байгууламж, инженерийн объектын тэнхлэг хүртэлх зай, м	
	Мод	Бут сөөг
Барилга байгууламжийн гадна хана, тоног, шугам сүлжээнээс	5.0	1.5
Троллейбусны замын далангийн захаас	5.0	3.0
Явган зам, цэцэрлэгжсэн замын хашлагын захаас	0.7	0.5
Гудамжны зорчих хэсгийн ирмэг, замын хажуугийн хашлагаас	2.0	1.0
Гудамж замын дагуух цахилгааны шугамаас	4.0	1.0
Түшиг ханын дотоод ирмэг буюу улнаас	3.0	1.0
Газар доорхи шугам сүлжээнээс	2.0	1.0

Тайлбар:

1. Энэхүү норм нь 5 м хүртэл диаметр бүхий титэмтэй модонд хамаарна. Түүнээс их диаметртэй мод хүртэлх зай хэмжээг төслийн даалгаврын дагуу төлөвлөнө.
2. Цахилгаан дамжуулах агаарын шугамнаас мод хүртэлх зайг цахилгаан байгууламжийн дүрмээр тодорхойлно.

3. Барилгын дэргэд суулгах мод нь энэхүү нормын 9 дүгээр бүлэгт заасан шаардлагын дагуу орон сууц, олон нийтийн байрны нарны шууд тусгал, гэрэлтүүлэгт саад болохгүйгээр байх ёстой.
- 4.12. Хот, тосгонд чимэглэлийн зориулалттай мод, бут үржүүлэх газар, цэцгийн хүлэмжийн аж ахуй төлөвлөнө. Мод үржүүлгийн газрыг тусгай тооцооны дагуу, гэхдээ 40 га-гаас багагүй талбайтай байхаар, цэцгийн хүлэмжийн аж ахуйг нэг оршин суугчид 0.5 м² талбай ногдохоор тус тус тооцож төлөвлөнө.

Амралт зугаалгын бүс болон рашаан сувиллын бүсийн төлөвлөлт

- 4.13. Олон нийтийн түр хугацааны амралт зугаалгын бүсийг нийтийн тээврийн хэрэгслээр 1.5 цагаас илүүгүй хугацаа зарцуулан очих зайд байрлуулна. Нэг амрагчид ногдох амралт зугаалгын бүсийн нутаг дэвсгэрийн хэмжээг 500-1000 м² байхаар төлөвлөнө. Амралт зугаалгын бүсийг амралт, рашаан сувилал, хүүхдийн зуслан, сургуулийн өмнөх насны хүүхдийн сувилал, ногоон байгууламж, хотын чанартай авто зам, төмөр замаас 500 м-ээс багагүй, амралтын газраас 300м-ээс багагүй зайд тус тус байрлуулна.
- 4.14. Ойн цэцэрлэг, амралт зугаалгын болон рашаан сувилалын бүсийн хилийн захаар байрлуулж буй автомашины зогсоолын хэмжээг төслийн даалгаврыг үндэслэн энэхүү нормын зөвлөмжийн 14 дүгээр хавсралтын дагуу төлөвлөнө.
- 4.15. Рашаан сувилалын бүсийг байгалийн рашаан амралтын нөөцтэй нь уялдуулан байгаль, цаг уур, ландшафт, ариун цэвэр эрүүл ахуйн хамгийн тааламжтай орчин бүрдсэн дэвсгэр нутагт байгуулна. Сувилалын барилгын бүтэц бүрэлдэхүүн, талбайн хэмжээг төслийн даалгаврын дагуу төлөвлөнө.
- 4.16. Рашаан сувилалын бүсийн төслийг зохиохдоо төлөвлөлтийн дараах зарчмыг баримтална. Үүнд:
- Рашаан сувиллын үйлчилгээтэй холбоогүй үйлдвэрийн болон нийтийн агуулахын объект, орон сууц, нийгмийн үйлчилгээний барилга байгууламж байрлуулахыг хориглох;
 - Бүсийн доторхи тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, эдэлбэр газраар дамжин өнгөрөхгүй байхаар тооцох;
 - Сувиллын ажиллагсдын ажилдаа хүрэх хамгийн бага хугацаа 15 минут байхаар тооцож, тэдний сууцны барилгыг бүсийн гадна байршуулна.
 - Ашиглалтын үүрэг зориулалтын хувьд ижил төрлийн буюу ойролцоо чиглэлтэй рашаан сувиллын байгууллагын үйлчилгээний барилга байгууламжийг төвлөрүүлж, архитектур-орон зайн нэгдсэн цогцолбор байдлаар төлөвлөнө.
- 4.17. Эдэлбэр газрын захаас рашаан сувиллын барилга байгууламж хүртэлх зайн доод хэмжээг доор зааснаас багагүйгээр төлөвлөнө.

Нийтийн аж ахуй ба агуулах, ажиллагсадын

сууцны барилга байгууламж хүртэл

500 м

Авто зам хүртэл

200 м-500м

Тайлбар: Автозамыг зэрэглэлээр ангилж, энэ зайн хэмжээг төслийн даалгавраар тогтооно.

- 4.18. Рашаан сувилалын бүсийн нийтийн хэрэгцээний нутаг дэвсгэрийн 1 хүнд ногдох талбайн доод хэмжээ сувилалын төвд 10 м², ногоон байгууламжид 100 м² байна.
- 4.19. Амралт зугаалга, рашаан сувиллын бүсэд орших наран шарлагын талбайн нэг хүнд ногдох талбайн доод хэмжээг том хүнд 5 м², хүүхдэд 4 м², тусгай зориулалтын эмчилгээнд 8 м²-аар тус тус төлөвлөнө.

БНБД 30.01.04

4.20. Эргийн дагуух наран шарлагын талбайд нэгэн зэрэг үйлчлүүлэгсдийн тоог наран шарлагын газрын ачааллаас хамааруулан коэффициентоор тооцож тодорхойлно.

Сувилалд	0.6-08
Амралт, жуулчлалын байгууллагад	0.7-09
Хүүхдийн зусланд	0.5-1.0
Орон нутгийн хүн амын зориулалттай амралтанд	0.2
Чөлөөт амрагсдад	0.5

Тав. Олон нийт, иргэний барилга байгууламжийн төлөвлөлт

- 5.1. Олон нийт, иргэний барилга байгууламжийг гудамж замын сүлжээ, цэцэрлэгжилтийн бүс, суурьшлын бүс, үйлдвэрийн бүстэй уялдуулан хоорондоо аль болохоор зохистой үйлчилгээний хүрээнд байхаар тооцож төлөвлөнө. Олон нийт, иргэний барилга байгууламжийн төслийн тооцоог холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулсан нийгэм хангамжийн нормативийг үндэслэн тогтооно. Олон нийт иргэний барилга байгууламжийн тоо, бүтэц бүрдэл, эдэлбэр газрын хэмжээг энэхүү нормын зөвлөмжийн 13 дугаар хавсралтын дагуу төлөвлөнө.
- 5.2. Их хот, том хотын олон нийт, иргэний барилга байгууламжийн тоо, хүчин чадал багтаамжийн тооцоонд, зэргэлдээ хот, суурингаас 2 цагт багтан эдгээр объектуудад хүрэлцэн ирэх боломжтой хүмүүс болон тухайн хотод түр оршин сууж байгаа хүмүүс, жуулчид бусад хүмүүсийг хамруулан тооцож төлөвлөнө. Харин жижиг, дунд хотын тухайд эдгээр объектуудад хүрэлцэн ирэх хүмүүсийн хугацааг 1 цагаас хэтрэхгүй байхаар тооцно.
- 5.3. Хот, тосгоны олон нийт, иргэний барилга байгууламжид ердийн хөсөг, тээврийн хэрэгсэл, явганаар хүрэлцэн очих хугацаа 30 минутаас ихгүй байна.
- 5.4. Олон нийт, иргэний барилга байгууламжийн хүн амд үйлчлэх хүрээний зай хэмжээг 7 дугаар хүснэгтэд зааснаас багагүйгээр төлөвлөнө.

7 дугаар хүснэгт

Албан газар, үйлдвэр, үйлчилгээний объектууд	Үйлчлэх хүрээ "м" - ээр
Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага: [*]	
Том хотод	300
Хөдөөгийн суурин, тосгон, бага хотод	500
Ерөнхий боловсролын сургууль	500
Бие бялдар чийрэгжүүлэлтийн төв	500
Орон сууцны хорооллын биеийн тамир, спортын төв	1500
Нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, тэдгээрийн салбар ^{**}	
Хэсгийн эмнэлэг, амбулатори	1000
Хүнсний зах	500-750
Эмийн сан	500
Нутаг дэвсгэрийн чанартай худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээний цэг салбар:	500
Хотод	500
Орон нутгийн суурин, тосгонд	1000
Холбооны салбар, хадгаламжийн банкны салбар	800

* Энэхүү үйлчлэх хүрээ нь сургуулийн өмнөх насны хүүхдийн тусгай зориулалтын төрөлжсөн сургуулиуд, цэцэрлэг яслид хамаарахгүй, харин суурин газар, хоторхуу сууринд ерөнхий боловсролын сургуулийн үйлчлэх хүрээг төслийн даалгаврын дагуу тогтооно.

** Тосгон, хоторхуу суурингийн нэгдсэн эмнэлэг, амбулатори, эмэгтэйчүүд – эх барихын байр, эмийн сан хүртэл явганаар, ердийн хөсөг, тээврийн хэрэгслээр хүрэлцэн очих хугацаа 30 минутаас хэтрэхгүй байна.

Тайлбар:

1. Уур амьсгалын I, IIА бүсэд хүснэгтэд заасан үйлчлэх хүрээний хэмжээг 30%-иар бууруулж төлөвлөхийг зөвшөөрнө. .

2. Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын явах замыг, хурдны зам, гол гудамж замтай нэг түвшинд огтлолцохоор төлөвлөхийг хориглоно.

5.5. Олон нийт, иргэн, үйлдвэр, үйлчилгээний барилгын хананаас улаан шугам хүртэлх зайг 8 дугаар хүснэгтэд зааснаас багагүйгээр төлөвлөнө.

8 дугаар хүснэгт

Нийгмийн үйлдвэр, үйлчилгээний барилга байгууламжийн эдэлбэр газар	Нийгмийн үйлдвэр, үйлчилгээний барилгын эдэлбэр газраас, (м-ээр)			
	Улаан шугам хүртэл		Орон сууцны хана хүртэл	Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдийн болон эмнэлгийн барилга хүртэл
	Хотод	Хөдөө орон нутагт		
Сургуулийн өмнөх насны хүүхдийн барилга байгууламж ЕБС-ийн барилгын хананаас	25	10	Агааржуулалт ба гэрэлтүүлгийн нормоор төлөвлөнө	
Хоёрдогч түүхий эд авах цэг	-	-	20	50
Галын депо	10	10	-	-
Оршуулгын болон цогцос чандарлах газар	6	6	300	300
оршуулах газар	6	6	100	100

Тайлбар:

1. Сургуулийн өмнөх насны хүүхдийн барилга болон эмнэлгийн барилгыг хурдны замын дэргэд барихыг хориглоно.

2. Хоёрдогч түүхий эд авах цэгийг ногоон зүлэгжүүлсэн зурвасаар тусгаарлаж, тусдаа орох замтай төлөвлөнө.

2. Эмнэлгийн паталогич - анатоми, халдвартай ба халдваргүй өвчтний байр болон аж ахуйн бүсийн эдэлбэр газар руу орох тусдаа орц, зам төлөвлөнө.

Зургаа. Хот, тосгоны гудамж, замын сүлжээний төлөвлөлт

- 6.1. Хот, тосгоны нутаг дэвсгэр, архитектур-орон зайн зохиомжийн хөгжлийн төслийг боловсруулахдаа гудамж, замын сүлжээтэй нь нягт уялдуулан төлөвлөнө. Гудамж, замын сүлжээ нь хот, тосгоны нутаг дэвсгэрийн үүргийн бүсүүдийн хоорондын уялдаа, тэдгээрийн харилцан таталцлын үндсэн тэнхлэг болж, орон зайн зохион байгуулалтын нэгдсэн системийн салшгүй хэсэг байна.
- 6.2. Гудамж, замын сүлжээг нэгдсэн систем байхаар төлөвлөнө. Гэхдээ хот, тосгоны орон зайн тогтолцоо, хүн амын өсөлт, дугуйтай болон явган зорчигч, тээврийн хөдөлгөөний эрчим, тэдгээрийн байнга өсөн тэлж байх явцтай уялдуулна.
- 6.3. Хот, тосгоны гудамж, замын сүлжээг бүрдүүлэх үндсэн элементүүд болох зорчих хэсэг, явган хүний зам, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол, дугуйн зам, хөдөлгөөн тусгаарлах зурвас, аюулгүйн тойрог, ногоон байгууламж, тээврийн хэрэгслэлийн зогсоол, явган хүний гарц, газар доорхи инженерийн байгууламж, гадаргуугийн усыг зайлуулж, дамжуулах байгууламж зэргийг хамруулан иж бүрнээр төлөвлөнө.
- 6.4. Хот, тосгоны гудамж, замын зориулалтыг 9 дүгээр хүснэгтэд заасны дагуу ангилан төлөвлөнө.

9 дүгээр хүснэгт

№	Ангилал	Тодорхойлолт	Зэрэглэл	Гудамж-замын үндсэн зориулалт
0	1	2	3	4
1	Хурдны зам	Бүрэн буюу хэсэгчилсэн хяналттай, уулзварууд нь ихэнх тохиолдолд янз бүрийн төвшинд төлөвлөгдсөн авто машины хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх зориулалт бүхий замыг хурдны зам гэнэ.	-	Хотоос онгоцны буудал, амралтын газар, хоторхуу суурин, хотын алслагдсан дүүрэг, улс, олон улсын чанартай замд нийлэх зэрэг өндөр хурдтай тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зориулагдана. Явган хүний зам, төмөр замтай нэг түвшинд огтлолцохыг хориглох зэрэг хурдны замын техникийн шаардлагууд хангагдсан байна.
2	Гол гудамж, зам	Хот, тосгоны тээврийн хөдөлгөөний үндсэн ачааллыг нэвтрүүлэх зориулалттай гудамж замыг хотын гол гудамж, зам гэнэ.	I зэрэглэлийн гол гудамж, зам	Хот, тосгон бүрдүүлэгч үндсэн элементүүдийг холбож, хот суурины доторхи тээврийн хөдөлгөөний үндсэн ачааллыг нэвтрүүлнэ. Төмөр замтай нэг түвшинд огтлолцохгүй. Хотын дотор тээврийн хэрэгслийн бүх төрөлд зориулагдана.
			II зэрэглэлийн гол гудамж, зам	Энэ гудамж зам нь ихэнх тохиолдолд төмөр замтай янз бүрийн түвшинд огтлолцоно. Гүйцэтгэх үүргийн хувьд I зэрэглэлийн замтай ижил боловч хөдөлгөөний эрчим бага байна.
3	Туслах гудамж, зам	Үүргийн бүсүүдийн доторх хөдөлгөөнийг нэвтрүүлж, гол гудамж, замтай холбоно. Гол гудамж замын хөдөлгөөнийг зохицуулан хуваарилах зориулалттай байна.	I зэрэглэл	Барилгажсан орчны тээврийн хэрэгслэлийг нэвтрүүлнэ.
			II зэрэглэл	Барилгажаагүй орчны тээврийн хэрэгслэлийг нэвтрүүлнэ.
4	Нутаг дэвсгэрийн зам	Эзэмшил нутаг дэвсгэрийн доторхи гудамж замыг хэлнэ.	тосгоны нутаг дэвсгэрийн гол гудамж, зам	Жижиг суурин газрын хөдөлгөөний үндсэн ачааллыг нэвтрүүлнэ.
			Нутаг дэвсгэрийн туслах гудамж, зам	Жижиг суурин газрын болон нутаг дэвсгэрийн нийт хөдөлгөөнийг хуваарилна.
			Явган хүний гудамж, зам	Зөвхөн явган хүн зорчиход зориулагдана. (Автомашинны замын дагуу баригдсан явган хүний зам энд хамаарахгүй)
			Дугуйн зам	Дугуйт тэшүүр ба дугуйтай хүн зорчиход зориулагдана.
			Орон сууцны хорооллын гудамж, зам	Сууцны хорооллын доторх хөдөлгөөнийг нэвтрүүлнэ.
			Үйлдвэр аж ахуйн газрын болон бусад гудамж, зам	Үйлдвэр аж ахуйн газар ба тусгай эзэмшлийн нутаг дэвсгэр дэх хөдөлгөөнийг нэвтрүүлнэ.

Тайлбар:

1. Хотын газар нутгийн хэмжээ, төлөвлөлтийн онцлог, замын зэрэглэлээс хамаарч энэхүү ангилалын гудамж, замыг түүвэрлэн сонгохыг хориглоно. Бага хот, суурингуудын гудамж, замыг нутаг дэвсгэрийн замтай адилаар сонгоно.
2. Орон сууц, үйлдвэрийн барилга байгууламж, олон нийт, иргэний барилга байгууламжийн эдэлбэр газрыг энэхүү нормын зөвлөмжийн 14 дүгээр хавсралтыг үндэслэн төслийн даалгаврын тооцоогоор тогтоосон тээврийн хэрэгслийн бие даасан зогсоолтой байхаар тооцож төлөвлөнө.
3. Орон сууц буюу ажлын байрнаас нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн буудал хүртэл 400м-ээс багагүй байна.
4. Нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн буудал хоорондын зай 600м-ээс багагүй байна.
- 6.5. Гудамж замын сүлжээ нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, иргэд богино хугацаанд тохь тухтай зорчих шаардлагад нийцсэн байх ёстой. Суурьшлын бүсээс хүмүүс нэгдсэн үйлчилгээний цогцолборын төв хүртэл нийтийн тээврийн хэрэгслээр зорчих хугацаа их хот, том хотод 30 минут, бусад хот сууринд 20 минутаас ихгүй байна.
- 6.6. Хот, суурины тээврийн хэрэгслийн хангамж болон автомашины зогсоол, тээврийн товчоо, техникийн зах, засвар үйлчилгээний цэг, гаражийн хэрэгцээг төлөвлөхдөө 1000 хүн тутамд 125 - 150 тээврийн хэрэгсэл ногдохоор тооцно.

Тайлбар: Орон нутгийн онцлогтой уялдуулан энэ тооцоог 20% хүртэл нэмэгдүүлэх буюу хорогдуулан төлөвлөж болно.

- 6.7. Суурьшлын бүсэд хурдны замыг зөвхөн техник-эдийн засгийн тооцоо, үндэслэлийн дагуу төлөвлөнө.

Гадна тээврийн замын сүлжээний төлөвлөлт

- 6.8. Төмөр зам, авто зам, усан зам, агаарын тээврийн зорчигчдын буудал нь хотын төв, буудлуудын хооронд, суурьшлын болон үйлдвэрийн бүстэй тээврийн сүлжээгээр холбоотой байх ёстой.

Тайлбар: Техник-эдийн засгийн тооцоог үндэслэн хот, тосгоны нисэх онгоцны буудлыг байгуулна. Техник-эдийн засгийн тооцоонд энэхүү нормын 7 дугаар хавсралтын шаардлагыг тусгасан байх ёстой.

- 6.9. Төмөр замын ачаа, тээш ангилж, ялган хуваарилах станцыг хот, тосгоны дэвсгэр нутгийн гадна байрлуулна. Төмөр замын болон автозамын тээврийн зорчигчдын техникийн станц, нөөц хөдөлгүүрийн парк, ачаа тээшийн станц, чингэлэгийн талбайг суурьшлын бүсийн гадна төлөвлөнө. Агуулах, удаан хугацаагаар хадгалах задгай барааны талбайг нийтийн аж ахуйн агуулахын бүсэд төлөвлөнө.
- 6.10. Их хот, том хотын захын бүсэд, дамжин өнгөрөх галт тэргийг нэвтрүүлэхэд зориулсан ачаа тээш ангилж ялгах, ачаа буулгах станц бүхий төмөр зам байх ёстой. Төв замын хөдөлгөөн цагт 10 цуваанаас илүү гарах тохиолдолд нэмэлт зам төлөвлөнө.
- 6.11. Төмөр зам хоорондоо өөр өөр түвшинд огтлолцохдоо дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- I, II зэрэглэлийн зам – хүмүүсийн оршин сууж буй суурингаас гадна, хот орчмын бүсэд;
- III, IV зэрэглэлийн зам – суурьшлын бүсийн гадна байх ёстой.

БНБД 30.01.04

Төмөр зам, хотын гудамж, авто зам болон цахилгаан тээврийн хэрэгслийн замтай нэг түвшинд огтлолцох уулзварыг холбогдох норм дүрмийн дагуу төлөвлөнө.

Төмөр замын тэнхлэгээс сууцны барилгын эдэлбэр газрын талбай хүртэл 100 м-ээс багагүй зайтай, цэцэрлэгжсэн талбай хүртэл 50 м-ээс багагүй зайтай байна.

- 6.12. Орон сууцны хорооллын эдэлбэр газраас төмөр зам хүртэлх ариун цэврийн хамгаалалтын бүсийн өргөн 50 м-ээс багагүй байна. Ариун цэврийн хамгаалалтын бүсийн эдэлбэр газрын 50 хүртэл хувь нь зүлэгжсэн байна. Ачаа тээш ангилж,ялган буулгах өртөөнөөс сууцны барилга байгууламж хүртэлх зайн хэмжээг ачаа эргэлтийн хэмжээ, ачааны тэсэрч дэлбэрэх аюул, галын аюулгүй байдал болон бусад онцлог шинж чанартай нь уялдуулан тооцож тогтооно. Ариун цэврийн хамгаалалтын бүс дэх төмөр замын ус зайлуулах зурвасын гадна автозам, гараж, автомашины зогсоол, агуулах, нийтийн аж ахуйн объектууд байрлуулан төлөвлөхийг зөвшөөрнө.
- 6.13. Хурдны зам, I, II зэрэглэлийн замын далангийн ирмэгээс барилгажилт хүртлэх зай хэмжээг энэхүү нормын 10 дугаар хүснэгтэд зааснаар төлөвлөнө.
Тээврийн хэрэгслийн дуу чимээнээс тусгаарлах зорилгоор эдгээр замын дагуу 10м-ээс багагүй өргөнтэй ногоон зурвас төлөвлөнө.
- 6.14. Хотоос хот орчмын амралтын бүс, онгоцны буудал, суурин газарт очих замын өргөнийг тухайн замаар 1 цагийн дотор зорчих хоёр талын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний тооцоо болон энэхүү нормын 10 дугаар хүснэгтэд заасны дагуу төлөвлөнө.
- 6.15. Онгоцны буудлын навигацийн төхөөрөмжийн хэвийн ажиллагаа болон нислэгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болох буудлын эдэлбэр газарт байрлуулах өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, радио релейний байгууламжийг иргэний нисэхийн удирдах газартай зөвшөөрөлцөж, энэхүү нормын заавал мөрдөх 7 дугаар хавсралт ёсоор төлөвлөнө.
- 6.16. Усан замын боомтыг суурьшлын бүсийн гадна байрлуулна. Тусгай зориулалтын ачаа ачих, буулгах, хадгалах далайн буюу гөл мөрний боомтын хилээс орон сууцны барилгажилт хүртлэх зайг доор зааснаас багагүй байхаар төлөвлөнө. Үүнд:

Тоос ихээр бужигнадаг ачаа эргэлтийн станцбн хилээс	300м
Амархан асах, шатах, шингэн хадгалдаг 1 дүгээр зэрэглэлийн агуулахаас	200 м
2 ба 3 дугаар зэрэглэлийн агуулахаас	100 м
Агнуурын газар дээрээ загас боловсруулдаггүй загас агнуурын боомтоос	100 м.

Тайлбар:

1. Боомтын эдэлбэр газарт гол мөрөн рүү салаалсан зам болон галын машины үйл ажиллагаа явуулахад зохицсон зам талбай төлөвлөнө.
2. Зорчигч, ачаа эргэлт багатай боомтод ачаа, хүн тээврийн нэгдсэн зогсоол төлөвлөхийг зөвшөөрнө.
3. Боомтын зогсоолын өргөн 150 м-ээс багагүй байна. Үйл ажиллагааны онцлогоос хамаарч, энэ өргөнийг зургийн даалгаврыг үндэслэн өргөсгөж, төлөвлөхийг зөвшөөрнө.
4. Боомтын эдэлбэр газарт байрлах шатах, тослох материалын агуулахыг сууцны барилга, амралтын байр, онгоцны зогсоол зэрэг барилга байгууламжаас 500 м зайд байрлуулна.
5. Усан замын навигацийн төхөөрөмжтэй бүсэд барилга байгууламж шинээр барих буюу хуучныг сэргээн шинэчлэх нөхцөлд холбогдох төрийн захиргааны байгууллагуудтай зөвшөөрөлцсөний үндсэнд гүйцэтгэнэ.

- 6.17. Спортын болон хувийн жижиг онгоцны зогсоолыг хотын суурьшлын бүс, нийтийн амралтын бүсийн гадна, хотын захын бүсэд байрлуулна. Онгоц хадгалах эдэлбэр газрын хэмжээ хувийн нэг онгоцонд 27 м², спортын онгоцонд 75 м² байна.

Гудамж, замын сүлжээний төлөвлөлт

- 6.18. Гудамж, замын сүлжээг, тээврийн хэрэгсэл, дугуйтай ба явган зорчигчийн хөдөлгөөний эрчимжилт, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, орон зайн зохиомж, орчны барилга байгууламжийн байршил, архитектуртай нь уялдуулан, тасралтгүй өсөн хөгжих хөдөлгөөнтэй нэгдсэн систем байхаар тооцож, төлөвлөнө. Гудамж, замын тооцооны үзүүлэлт болон гудамж замын ирмэгээс орон сууцны барилгын эдэлбэр газрын улаан шугам хүртлэх хэмжээг энэхүү бүлгийн 10 дугаар хүснэгтэд зааснаар төлөвлөнө.
- 6.19. Гол гудамж, замын зорчих хэсгийн ирмэгээс барилгажилтын улаан шугам хүртлэх зай 50 м-ээс багагүй байна.
- 6.20. I зэрэглэлийн гол гудамж, замыг хотын төв, томоохон үйлдвэрийн газар зэрэг хүн амын хөдөлгөөн ихтэй орчин болон хотын төвийн замтай уялдуулан төлөвлөнө. II зэрэглэлийн гол гудамж, замын бусад замтай огтлолцсон уулзваруудын хоорондох зай 800 м-ээс багагүй байх ёстой. Явган хүн зам хөндлөн гарах гарцыг орчинтой нь уялдуулан төлөвлөнө. Гол гудамж, замын дагуух барилгажуулалтын тээврийн үйлчилгээнд зориулж 7 метрийн өргөнтэй нэг урсгалтай дагавар зам төлөвлөнө. Гэхдээ өргөтгөл, шинэчлэлт хийх үед эдгээр барилгажуулалтын хэрэгцээг зэрэгцээ гудамж, замаар явуулан хангах боломж бүрдсэн нөхцөлд дагавар зам төлөвлөхгүй байхыг зөвшөөрнө.
- 6.21. I ба II зэрэглэлийн гол гудамж, замын дагуу дугуйтай хүн зорчих тусгай зурвас зам төлөвлөж болно. Нийтийн амралтын бүс болон цэцэрлэгт хүрээлэнд, явган хүний замаас тусдаа дугуйтай хүн зорчих зам төлөвлөхийг зөвшөөрнө. Дугуйтай хүн зорчих зам хоёр урсгалтай байж болно. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс энэ замыг автомашин зорчих хэсгийн хашлага, модноос 0.75 м-ээс, явган хүний замаас 0.5 м-ээс, зам дагуух автомашины болон нийтийн тээврийн зогсоолоос 1.5 м-ээс багагүй зайтай төлөвлөнө.
- 5.22. Гол замын зорчих хэсгийн уулзварын эргэлтийн радиусыг доор зааснаас багагүйгээр төлөвлөнө. Үүнд:

I-II зэргийн гол гудамж, замд	15 м
Хороолол доторхи замд	8 м
Тээврийн хэрэгслийн талбайд	15 м байна.

Тайлбар:

1. Тухайн төлөвлөлтийн онцлогоос хамаарч, замын зорчих хэсгийн радиусыг гол гудамж замд 12 м, хорооллын доторхи замд 5м, тээврийн хэрэгслэлийн талбайд 8 м хүртэл багасгаж төлөвлөхийг зөвшөөрөх боловч, тээврийн хэрэгслийн ашиглалтын үеийн техникийн шаардлагатай уялдуулна.
- 6.23. Гудамж замын уулзвар болон явган хүний гарц дээр харааны гурвалжинг ("метр"-ээр) төлөвлөнө. Гурвалжингийн хэмжээ нь "тээвэр – тээвэр" байх үед 40 ба 60 км/цаг хурдтай тохиолдолд 25 х 40; "явган зорчигч - тээвэр" байх үед 25 км/цаг хурдтай тохиолдолд 8 х 40; 40 км/цаг хурдтайд 10 х 50 м байна.
- Харааны гурвалжин дотор барилга байгууламж, түр байгууламж,(төрөл бүрийн мухлаг, рекламн самбар, архитектурын жижиг хэлбэрүүд гэх мэт.), 0.5 м-ээс өндөр мод, бут байрлуулахыг хориглоно.

БНБД 30.01.04

6.24. Барилгажсан орчны гол гудамж, замын нэг түвшинд байх явган хүний гарцын хоорондын зай 200 м-ээс багагүй байна. Харин өөр өөр төвшин дэх явган хүний гарцын хоорондын зай хурдтай зам, хурдтай төмөр замд 400м-ээс багагүй, I зэрэглэлийн гол гудамж, замд 300м-ээс багагүй байна.

Тайлбар:

1. Барилгажсан орчны гудамж, замын нэг түвшинд байх явган хүний гарцыг 300м-ээс, өөр өөр түвшин дэх явган хүний гарцыг хурдтай зам, хурдтай төмөр замд 800м-ээс ихгүй, тасралтгүй хөдөлгөөнтэй гудамж, замд 400м-ээс ихгүй төлөвлөхийг зөвшөөрнө.
2. Хөдөлгөөний зохицуулалттай гудамж замын гарцаар цагт 3000-аас дээш явган зорчигч хөндлөн гарах тооцоо гарч байвал явган хүний гарцыг 2 өөр төвшинд төлөвлөнө.
3. Засаг захиргаа, олон нийтийн болон худалдааны төв, зочид буудал, театр, үзэсгэлэнгийн танхим, худалдааны захуудад хамгийн их ачаалалтай үед 1 м² талбайд 0.8 хүн ногдож байвал эдгээр байгууламжийн дэргэд явган хүний гарцыг 2 төвшинд төлөвлөнө.

10 дугаар хүснэгт

Гудамж замын төлөвлөлтийн тооцооны үндэслэл

Гудамж замын зэрэглэл	Хөдөлгөөний тооцоот хурд, км/цаг	Замын нэг зурвасын өргөн, м	Замын эгнээний тоо	Тойруугийн хамгийн бага радиус, м	Хамгийн их дагуу налуу, %	Явган замын өргөн, м	Гудамж, замын ирмэгээс орон сууцны эдлэлбэр газрын улаан шугам хүртэлх зай, м
Хурдны зам	120	3.75	4-8	600	30	-	80
<u>Гол гудамж зам:</u>							
I зэрэглэлийн зам	100	3.75	4-8	600	50	4.5	80
II зэрэглэлийн зам	80	3.50	2-6	400	60	3.0	70
<u>Туслах гудамж зам:</u>							
I зэрэглэлийн зам	70	3.50	2-4	250	60	2.25	60
II зэрэглэлийн зам	50	3.50	2	250	60	3.0	50
<u>Нутаг дэвсгэрийн зам:</u>							
1.Тосгон болон нутаг дэвсгэрийн гол гудамж, зам	60	3.50	2-3*	150	60	1.5	20-25
2.Нутаг дэвсгэрийн туслах гудамж, зам	30	3.00	2	50	80	1.5	15-20
Явган хүний гудамж, зам	-	1.50	тооцоогоор	-	40	төслөөр	төслөөр
Дугуйн зам	20	1.50	1-2	30	40	төслөөр	төслөөр
Орон сууцны хорооллын гудамж зам	40	3.00	2-3	90	70	1.5	
Үйлдвэр аж ахуйн газар болон бусад гудамж, зам	40	3.50	2	150	70	1.5	

* нэг чиглэлийн замын урсгалын дагуух орон зайд суудлын авто хөсөг зогсохоор тооцож, төлөвлөж болно.

Тайлбар:

1. Гудамж, замын өргөнийг тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөний эрчим болон эрүүл ахуй-ариун цэврийн, иргэний хамгаалалтын шаардлагатай уялдуулан хөндлөн байрлуулах газар доорхи шугам сүлжээ, явган зам, гарц зэргийн тооцоог үндэслэн тогтооно.
2. Тэгш бус гадаргуутай буюу шинэчлэн засварлаж байгаа хурдны болон тасралтгүй хөдөлгөөнтэй гудамж, замын тойруугийн радиусыг багасгаж, дагуух налууугийн тооцоот хурдыг 10 км/цаг-аас багасгах зарчмаар геометрийн элементэд өөрчлөлт оруулж болно.
3. Их хот, том хотын гудамж, замын нийтийн тээврийн хэрэгсэл, ачааны машин явах замын зурвасын өргөнийг 4м-ээр, хөдөлгөөний эрчимжилт 40 нэгж/цагаас дээш нөхцөлд зорчих хэсгийн өргөнийг 8м-ээс ихгүйгээр төлөвлөхийг зөвшөөрнө. Хэрэв гол гудамж замаар

зонхилон зорчих тээврийн хэрэгсэл нь ачааны машин байвал зорчих зурвасыг 4 м хүртэл өргөсгөж болно.

4. Уур амьсгалын I бүсэд гол гудамж, замын дагуух налуугийн хэмжээг 10%-иар багасгаж төлөвлөнө.
5. Явган хүний замын зорчих хэсгийн талбайд мухлаг, сандал байрлуулахыг хориглоно. Хэрэв явган хүний хөдөлгөөн 50 хүн/цагаас бага байвал хоёр талын явган хүний замын зорчих зурвасыг 1 м өргөнтэй төлөвлөж болно.
6. Аливаа саадтай тулсан явган хүний замын тулсан хэсгийн өргөнийг 0.5м-ээс багагүйгээр өргөсгөж төлөвлөнө.
7. Гол гудамж, замыг тухайн хот, тосгоны ирээдүйн хөгжилтэй уялдуулан цаашид иж бүрэн өргөтгөн хөгжүүлэхээр тооцож, төлөвлөнө.
8. Шаардлагатай гэж үзвэл зургийн даалгаварыг үндэслэн том, дунд, жижиг хотын гудамж, замын хэмжээ, техникийн үзүүлэлтийг гол гудамж, замын түвшинд хүргэж төлөвлөхийг зөвшөөрнө.

Нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн болон явган зорчигчийн гудамж, замын сүлжээний төлөвлөлт.

- 6.25 Нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн багтаамж, хүчин чадал, төрлийг зорчигчдын тоо, хэрэгцээ шаардлага, зорчих орон зайн хэмжээг үндэслэн тогтооно. Нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдын буудлын 1 м² талбайд 4 хүн, хот хоорондын хурдан тээврийн хэрэгсэлээр зорчигчдын буудлын 1 м² талбайд 3 хүн ногдохоор тус тус тооцож төлөвлөнө.
- 6.26 Нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгсэл зорчих үндсэн гудамж, замыг зорчих хэсэг буюу хучилтаар нь тусгайлан ялгасан зурвастай байхаар тооцож төлөвлөнө.
Тайлбар: Хотын гудамж, замын нэвтрүүлэх чадвар хязгаарлагдмал нөхцөлд давхар зам буюу газрын түвшнээс доогуур хонгилон зам төлөвлөхийг зөвшөөрнө.
- 6.27 Үүргийн бүсүүдийн нутаг дэвсгэрийн нийтийн зорчигч тээврийн хэрэгсэлийн гудамж, замын нягтралыг зорчигч тээврийн эргэлтийн эрчимжилт, ашиглалтын ажиллагаатай нь уялдуулан төлөвлөнө. Гэхдээ нягтралын хязгаар 1.5 км/км²-аас багагүй байна. Суурьшлын нягтрал өндөртэй нутаг дэвсгэрт энэ хэмжээг 4.5 км/км² хүртэл нэмэгдүүлж төлөвлөхийг зөвшөөрнө.
- 6.28 Нийтийн зорчигч тээврийн хэрэгсэлийн буудал хүртэл явганаар хүрэлцэн очих зайг 300м-ээс багагүй байхаар төлөвлөнө. Харин энэ зай хотын төвийн олон хүн цуглардаг объектоос 250м-ээс ихгүй, олон нийтийн амралт ба биеийн тамир, спортын бүсэд 800м-ээс ихгүй, үйлдвэр аж ахуйн ба нийтийн агуулахын бүсэд 400м-ээс ихгүй байх ёстой.
Тайлбар: Хотын алслагдсан бүсэд байрлах суурьшлын бүс, орон сууцны хорооллын нийтийн тээврийн хэрэгслийн үйлчилгээний зарчмыг зургийн даалгаварын дагуу төлөвлөнө.
- 6.29 Суурьшлын бүс дэх нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн зогсоолын хоорондох зай 400 м-ээс багагүй, харин буухиалан явах нийтийн тээврийн хэрэгслийн тухайд энэ зай 1000 м-ээс багагүй байна. Хүн олноор цугларах объектуудын дэргэдэх нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын 1 хүнд ногдох талбайг доор зааснаас багагүйгээр төлөвлөнө. Үүнд: нэг чиглэлийн хөдөлгөөнтэй нөхцөлд 1.0м², сөрөг хөдөлгөөнтэй нөхцөлд 0.8м², билчир орчны хуваарилах талбайтай уулзварт 0.5м², буухиалан явах тээврийн хэрэгслийн төвийн болон эцсийн буудлын талбайд 0.3м² байна.

БНБД 30.01.04

Тээврийн хэрэгсэлийн үйлчилгээ, гаражийн байгууламжийн төлөвлөлт

6.30 Суурьшлын бүс болон түүнтэй залгаа үйлдвэр, аж ахуйн бүсийн эдэлбэр газарт тээврийн хэрэгсэлийн гараж, ил зогсоол төлөвлөнө. Гараж, ил зогсоолын хүчин чадлыг тухайн эдэлбэр газарт хамрагдах нийт суудлын автомашины 90%-ийг хамрахаар тооцно. Ил зогсоол, гаражид явганаар хүрэлцэн очих зайн хэмжээ 800м-ээс ихгүй, гидрогеологи, газар зүйн тааламжгүй орчинд энэ зай 1500 м-ээс ихгүй байна.

Суудлын автомашины түр зогсоолын хүчин чадлыг суудлын автомашины тооцоот паркийн 70 %-ийг хамрахаар тооцож төлөвлөнө. Үүнд:

- Сууцны хороололд	- 25%
- Үйлдвэр аж ахуйн агуулахын бүсэд	- 15%
- Хотын олон нийтийн, нийгмийн үйлдвэрлэл үйлчилгээний төрөлжсөн төвүүдэд	- 15%
- нийтийн амралтын бүсэд	- 15%

Тайлбар:

1. Суурьшлын бүсийн гадна суудлын автомашины тооцоот паркийн 10-15%-ийг улирлын чанартай гараж, ил зогсоол хэлбэрээр төлөвлөхийг зөвшөөрнө.
 2. Автомашины гараж, ил зогсоолын хүчин чадлыг тогтоохдоо мотоцикл, мотороллер, моторт дугуй, мопед зэрэг жижиг тээврийн хэрэгсэл хамрагдахаар тооцож төлөвлөнө. Тооцоог зургийн даалгавараар тогтооно.
 3. Сууцны хороололтой холбогдох гудамж, замын дагуу автомашины түр буюу байнгын зогсоол төлөвлөхийг зөвшөөрнө.
- 6.31 Орон сууцны хороолол, бичил хорооллын нутаг дэвсгэрийн газар доорхи орон зайд 1000 хүн тутамд 25-аас багагүй автомашины байр гаргаж төлөвлөнө. Мөн суудлын автомашины гаражыг сургууль, цэцэрлэг, эмнэлэгийн хэвтэж эмчлүүлэх байрын барилга байгууламжаас бусад орон сууц, олон нийт, иргэний барилгын эзлэхүүнд оруулах буюу нэмэгдлээр барихаар төлөвлөхийг зөвшөөрнө.

Тайлбар: Газар доорхи орон зайд болон барилгын эзлэхүүнд оруулан барих гараж, мөн тахир дутуу иргэдийн тээврийн хэрэгслийн гаражыг БНБД 31-01-01, БНБД31-03-03 болон төслийн даалгаварын дагуу төлөвлөнө. Тахир дутуу иргэдийн тээврийн хэрэгслийн гаражыг орон сууцны орцны ойролцоо хамгийн ойр зайд байрлуулна. Гаражын хүчин чадлыг төслийн даалгавараар тогтооно.

6.32 Автомашины түр зогсоол хүртэл явган хүрэх зайг доор зааснаас ихгүйгээр төлөвлөнө. Үүнд:

- Орон сууцны байшингийн орц хүртэл	- 150 м
- Нийтийн хоолны газар болон худалдааны барилгын орц, олон нийтийн буудлын зорчигчдын танхимын хаалга хүртэл	- 200 м
- Хүн амын ахуй үйлчилгээний байгууламж, засаг захиргааны төвийн орц хүртэл	- 250м
- Цэнгэлдэх хүрээлэн, үзэсгэлэнгийн танхим, цэцэрлэгт хүрээлэнгийн гол орц хүртэл	- 400 м

Суудлын автомашины зогсоолын хүчин чадал, төлөвлөлтийн тооцоо болон нормативыг энэхүү нормын зөвлөмжийн 14 дүгээр хавсралт ёсоор төлөвлөнө.

- 6.33. Суудлын автомашины гаражыг олон давхар барилгаар төлөвлөхийг зөвшөөрнө. Гаражын болон ил зогсоолын эдэлбэр газрын нэг автомашинд ногдох талбайг 1 давхар гаражид 12 м²-аас, 2 давхар гаражид 18 м²-аас, 3 давхар гаражид 14 м²-аас, 4 давхар гаражид 12 м²-аас, 5 давхар гаражид 10 м²-аас, газар дээрхи зогсоолд 20 м²-аас багагүй байхаар тус тус төлөвлөнө.
- 6.34. Гаражын хаалга хүртлэх зайн хамгийн бага хэмжээ гол гудамж замын уулзвараас 50 м, нутаг дэвсгэрийн гудамж замаас 20 м, нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн зогсоолоос 30 м байна. Суудлын автомашины газар доорхи гаражын хаалганаас сууцны байшингийн цонх, олон нийтийн барилгын ажлын өрөөний цонх, ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, эмнэлгийн барилгын эдэлбэр газрын хил хүртэлх зайн доод хэмжээ 15 м-ээс ихгүй байна.
- Тайлбар: Суудлын автомашины газар доорхи гаражын агаар сорох нүхний норматив, тооцоог төслийн даалгаврын дагуу тогтооно.
- 6.35. Албан байгууллагын автобааз, тусгай зориулалтын автобааз, хот хоорондын тээврийн бааз, такси бааз, троллейбусны бааз болон улирлын чанартай автомашины бааз, техникийн үйлчилгээний төвлөрсөн газар, хөлсөөр үйлчлүүлэх автомашины баазыг хотын үйлдвэрийн бүсэд байрлуулж, эдэлбэр газрынх нь хэмжээг энэхүү нормын зөвлөмжийн 15 дугаар хавсралтын дагуу төлөвлөнө.
- 6.36. Хөнгөн тэрэгний ил зогсоол, гараж, техникийн үйлчилгээний төвөөс орон сууц, олон нийтийн барилга болон суурьшлын бүсэд байрласан эмнэлэг, сургууль, цэцэрлэг хүртлэх зайг 11 дүгээр хүснэгтэд зааснаас багагүйгээр төлөвлөнө.

11 дүгээр хүснэгт

№	Барилга байгууламжийн нэр	м-ээс багагүй байх зай хэмжээ				
		Гараж ил зогсоолд байх хөнгөн тэрэгний зай			Техник үйлчилгээний төвийн хүчин чадал	
		10 хүртэл	11-50	51-ээс дээш	10 хүртэл	11-30
0	1	2	3	4	5	6
1	Орон сууцны барилга	10**	15	25	15	25
2	Орон сууцны хажуу тал	10**	10**	15	15	15
3	Олон нийтийн барилга	10**	10**	15	15	20
4	Сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдийн барилга	15	25	25	50	*
5	Эмчлэн сэргийлэх байгууллагын барилга	25	50	*	50	*

* Зайг ариун цэвэр -эрүүл ахуйн газартай тохиролцож тогтооно.

** Гал тэсвэршилтийн III-IV зэрэгтэй барилгын тухайд энэ зай 12м-ээс багагүй байна.

Тайлбар:

1. Зайн хэмжээ нь орон сууц, олон нийтийн барилгын цонх, сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын барилга болон эмчлэн сэргийлэх барилгын эдэлбэр газрын хилээс гаражын хана буюу задгай зогсоолын хил хүртэл байна.
2. Хэсэгчлэн барих орон сууцны барилгын дагуу байрлах 100-гаас дээш машинтай ил зогсоол хүртлэх зай 50 м-ээс багагүй байна.
3. Гал тэсвэршилтийн I-II зэрэгтэй гаражын барилгын цонхгүй буюу хаалга нь орон сууц, олон нийтийн барилга руу чиглэхээр бол зайг 25 % хүртэл багасгаж төлөвлөхийг зөвшөөрнө.

БНБД 30.01.04

4. 100 –гаас дээш хөнгөн тэрэг хадгалах хүчин чадалтай гараж буюу ил зогсоол, 30-аас дээш засвар техникийн үйлчилгээний цэгтэй техник, үйлчилгээний төвийг үйлдвэрийн бүсэд, гэхдээ орон сууцны барилгаас 50 м-ээс багагүй зайтай байрлуулна. Уг зайн хэмжээг эрүүл ахуй -ариун цэврийн газартай тохиролцон тогтооно.
 5. 10-аас дээш машины гаражын энэ зайн хэмжээг интерполяцийн зарчмаар төлөвлөхийг зөвшөөрнө.
 6. Модноос бусад төрлийн материалаар баригдсан нэг давхар хувийн сууцны гаражыг зоорийн хэлбэрээр тусгаарлан барихаар төлөвлөхийг зөвшөөрнө.
- 6.37. Техникийн үйлчилгээний станцын 1 цэгт 200-аас багагүй автомашин үйлчлүүлэхээр тооцож төлөвлөнө. Үйлчилгээний 10 цэгтэй техникийн үйлчилгээний төвийн эдэлбэр газрын хэмжээ 0.1 га байна. 10-аас дээш үйлчилгээний цэгтэй газрын эдэлбэр газрын хэмжээг төслийн даалгаврын дагуу төлөвлөнө.
- 6.38. Шатахуун түгээх газрын цэнэглэх хошуу бүрт 1200 автомашин ногдохоор тооцож төлөвлөнө. ШТС-ийн 2 хошуунд 0.1 га, 5 хошуунд 0.2 га, 7 хошуунд 0.3 га, 9 хошуунд 0.35 га, 11 хошуунд 0.4 га эдэлбэр газар ногдохоор тус тус төлөвлөнө.
- 6.39. Шингэн түлш хадгалах газар доорхи сантай шатахуун түгээх станцаас сургалт хүмүүжлийн барилга байгууламж, дотуур байртай сургууль, хэвтэж эмчлүүлэх хэсэгтэй эмчлэн сэргийлэх барилга байгууламжийн эдэлбэр газрын хил буюу орон сууц, олон нийтийн барилга байгууламжийн хана хүртэл 50м-ээс багагүй зайтай байна. Энэ зай хэмжээг шатахуун түгээх газрын түгээх хошуу болон шингэн түлш хадгалах газар доорхи сантай байрлалаас нь хамааралтай тогтооно. Хэрэв шатахуун түгээх газар нь хоногт 500-гаас илүүгүй зөвхөн суудлын автомашин цэнэглэх бол тухайн объект хүртэлх зай хэмжээг 25м хүртэл бууруулан төлөвлөхийг зөвшөөрнө. Тэгэхдээ эдгээр нормыг галын аюулгүйн болон нефтийн барилга байгууламжийг төлөвлөх норм дүрэмтэй уялдуулж сонгоно.

Долоо. Инженерийн шугам сүлжээний төлөвлөлт

Усан хангамж , ариутгах татуурга

- 7.1. Ус цэвэрлэх байгууламжийн эдэлбэр газрын хэмжээг, хүчин чадлаас нь (мян.м³/хон) хамааруулж дараах тооцооноос ихгүйгээр сонгож тогтооно. Үүнд:

0.8 мян.м ³ /хон хүртэл	- 1га
0.8-12 мян.м ³ /хон	- 2га
12-32 мян.м ³ /хон	- 3га
32-80 мян.м ³ /хон	- 4га
80-125 мян.м ³ /хон	- 6га
125-250 мян.м ³ /хон	- 12га
250-400 мян.м ³ /хон	- 18га
400-800 мян.м ³ /хон	- 24га

- 7.2. Бохир ус цэвэрлэх байгууламжийн эдэлбэр газрын хэмжээг 12 дугаар хүснэгтэд зааснаас ихгүйгээр төлөвлөнө.

Бохир ус цэвэрлэх байгууламжийн хүчин чадал мян.м ³ /хон	Эдэлбэр газрын хэмжээ, га		
	Цэвэрлэх байгууламж	Лагийн талбай	Бохир усны гүн цэвэрлэгээ, биологийн цөөрөм
0.7 хүртэл	0.5	0.2	-
0.7-17	4	3	3
17-40	6	9	6
40-130	12	25	20
130-175	14	30	30
175-280	18	55	-

Тайлбар. Хоногт 280 мян.м³-ээс дээш хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн эдэлбэр газрын хэмжээг эрүүл ахуй-халдвар судлалын хяналтын байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр тогтоосон журмын дагуу боловсруулсан ижил төстэй байгууламжийн төслөөр буюу мэргэжлийн байгууллагын өгөгдлөөр төлөвлөнө.

- 7.3. Ариутгах татуургын бие даасан системтэй цэвэрлэх байгууламжийн эдэлбэр газрын болон ариун цэврийн хамгаалалтын бүсийн хэмжээг холбогдох норм дүрмийн дагуу хөрсний нөхцөл, бохир усны хэмжээнээс хамааруулан 0.25 га-гаас ихгүй байхаар төлөвлөнө.
- 7.4. Ариутгах татуургын төвлөрсөн системгүй газарт орон нутгийн ариун цэвэр-эрүүл ахуйн хяналтын байгууллагатай зөвшилцсөний дагуу бохир усны халих байгууламжийг төлөвлөнө. Ус зайлуулах, халих байгууламжийн эдэлбэр газрын ба ариун цэврийн хамгаалалтын бүсийн хэмжээг 12 дугаар хүснэгтэд зааснаар төлөвлөнө.

Хот, тосгоны ариун цэвэр, эрүүл ахуйн цэвэрлэгээ

- 7.5. Том хот болон улсын чанартай амралт, сувилалын газарт ахуйн хог хаягдлыг техник- эдийн засгийн үндэслэлийн дагуу үйлдвэрийн аргаар боловсруулах үйлдвэрийн газартай байхаар төлөвлөнө.
Ахуйн хог хаягдал хуримтлуулах хэмжээг энэхүү нормын 16 дугаар хавсралтад зааснаар тооцохыг зөвшөөрнө.
- 7.6.1. Ахуйн хог хаягдлыг боловсруулах, халдваргүйжүүлэх, тээвэрлэх байгууламжийн болон үйлдвэрийн эдэлбэр газрын ба ариун цэврийн хамгаалалтын бүсийн хэмжээг энэхүү бүлгийн 13 дугаар хүснэгтэд зааснаар төлөвлөнө.

Инженерийн шугам сүлжээний байршил

- 7.7. Инженерийн шугам сүлжээг ихэвчлэн гудамж, замын дагуу, улаан шугаман дотор, тусгаарлах зурваст дараах байдлаар байрлуулна. Үүнд:
- Авто ба явган хүний зам, түүний тусгаарлах зурвас доор инженерийн шугам сүлжээг коллектор, суваг болон хонгил дотор;
 - Тусгаарлах зурваст ахуйн болон хур борооны ус, хөрсний ус зайлуулах шугам хоолойг;
 - Улаан шугам ба барилгажилтын бүсийн хооронд нам даралтын хийн болон кабелийн сүлжээ (хүчний, холбооны, дохиололын, диспетчерийн)-г тавина.

Гудамж замын зорчих хэсгийн өргөн 22 м-ээс их үед усны хоолойг гудамжны 2 талд байрлуулахаар төлөвлөнө.

- 7.8. Хатуу хучилттай гудамж, замын зорчих хэсгийг өргөтгөх, шинэчлэн засварлахдаа түүн доор байрлаж буй инженерийн шугам сүлжээг тусгаарлах зурвас болон явган хүний замын доор байрлуулахаар төлөвлөнө. Техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу гудамжны зорчих

БНБД 30.01.04

хэсгийн доор инженерийн шугам сүлжээг хэвээр нь байлгаж болох бөгөөд шинээр тавих шугам сүлжээг сувагт болон хонгилд байрлуулахыг зөвшөөрнө. Тусгаарлах зурвасгүй гудамжны зорчих хэсгийн доор шинээр инженерийн шугам сүлжээг төлөвлөхдөө тэдгээрийг суваг болон хонгилд байрлуулах ёстой.

7.9. Газар доорхи инженерийн шугам сүлжээг нэгтгэн нэг хонгилд дараах тохиолдолд байрлуулж болно. Үүнд:

- Зайлшгүй нэгэн зэрэг байрлуулах 500-900 мм хүртэл диаметртэй дулааны шугам сүлжээ, 500мм хүртэл диаметртэй ус дамжуулах хоолой, 10-аас дээш холбооны кабель, 10 кВ хүртэл хүчдэлтэй хүчний кабель шугам 10 ширхэгийг;
- Гол гудамж, түүхийн дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлахад;
- Гудамж замын хөндлөн хэсэгт шугам сүлжээг байрлуулахад зай хэмжээ нь хүрэлцэхгүй үед;
- Гол гудамжнууд ба төмөр замуудын огтолцол дээр;

Түүнчлэн хонгилд агаар дамжуулах хоолой, ариутгах татуургын даралтат хоолой, бусад инженерийн шугам сүлжээг байрлуулахыг зөвшөөрнө. Мөнх цэвдэг хөрс тархсан бүсэд инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийг төлөвлөхдөө хөрсний цэвдэг байдлыг хэвээр хадгалах бөгөөд дулаан дамжуулах хоолойг тэдгээрийн диаметрээс нь хамааралгүй, суваг буюу хонгилд байрлуулна.

Тайлбар:

1. Хөрсний төвөгтэй нөхцөл бүхий барилгажилтын талбай(суулттай, алтан химэрлэг хөрстэй)-д ус зөөвөрлөх инженерийн шугам сүлжээг, нэвтрэх гарц бүхий хонгилд байрлуулахаар төлөвлөнө. Суулттай хөрсний хэв шинжийг холбогдох норм дүрмийн дагуу авна.
2. Дэвсгэр нутгийн суурьшлын бүсийн төлөвлөлтийн төвөгтэй нөхцөлд орон нутгийн захиргаатай зөвшилцсөний дагуу дулааны шугам сүлжээг газар дээгүүр байрлуулахыг зөвшөөрнө.

13 дугаар хүснэгт

Үйлдвэрийн газар болон байгууламж	Жилд ялгаран гарах 1000тн ахуйн хатуу хог хаягдлын эдэлбэр газрын хэмжээ /га/	Ариун цэврийн хамгаалалтын бүсийн хэмжээ /м/
Үйлдвэрийн аргаар ахуйн хог хаягдлыг боловсруулах үйлдвэрийн газрын хүчин чадал жилд мян.тн		
100 хүртэл	0.05	300
100 –аас дээш	0.05	500
Шинэ бордооны агуулахууд	0.04	500
Талбай ¹	0.02-0.05	500
Бордооны талбай	0.5-1	500
Бохир ус зайлуулах талбай	2-4	1000
Юүлэх станц(сливные станции)	0.2	300
Хог хаягдал ачих станц	0.04	100
Халдваргүйжүүлсэн хуурай хог хаягдлыг агуулах, цуглуулах талбай	0.3	1000

¹ Үйлдвэрийн газрын хортой хаягдлыг хадгалах, халдваргүйжүүлэх талбайнуудыг байршуулахдаа холбогдох норм дүрмийг мөрдөнө. Эдгээрээс бусад талбайнуудыг энэ хүснэгтэд зааснаар авна.

Тайлбар: Бохир ус зайлуулах, бордооны талбай, бусад талбайнуудын эдэлбэр газрын хамгийн бага хэмжээг тогтоохдоо ус, цаг уур, хөрсний нөхцөлийг тооцож төлөвлөнө.

7.10. Ойролцоох газар доорх инженерийн шугам сүлжээнээс(гадаргуугаас гадаргууд) барилга, байгууламж хүртэлх зай хэмжээг хэвтээ чиглэлд 14 дүгээр хүснэгтэд зааснаар төлөвлөнө. Зэргэлдээх газар доорхи инженерийн шугам сүлжээнүүд зэрэгцээ байрласан үед тэдгээрийн хоорондын зайг хэвтээ чиглэлд (гадаргуугаас гадаргууд) энэхүү нормын 15 дугаар хүснэгтэд зааснаар төлөвлөнө. Харин хөдөөгийн тосгон, суурины барилга байгууламжид инженерийн шугам сүлжээний оруулга шугамын урт 0.5 м-с багагүй байна. Харилцан адилгүй түвшинд зэрэгцэж байрласан дамжуулах хоолойнуудын хоорондын зай 0.4 м-ээс их үед энэхүү нормын 15 дугаар хүснэгтэд заасан зай хэмжээг ихэсгэж авах бөгөөд энэ зай нь траншейны налууг тооцон ухсан нүхний ирмэгээс асгаас хөрсний ул хүртэлх гүнээс багагүй хэмжээтэй байх ёстой. Инженерийн шугам сүлжээ огтлолцсон үед хоорондын зайг (гадаргуугаас гадаргууд) босоо чиглэлийн дагуу холбогдох норм дүрмийг баримтлан авна.

14 дүгээр хүснэгт

Инженерийн шугам сүлжээ	Газар доорх шугам сүлжээнээс дараах цэгүүд хүртэлх зай, м (хэвтээгээр)								
	Барилга байгууламжийн суурь	Үйлдвэрийн суурийн хашлага, астакад, тулгуур, контактны сүлжээ ба холбоо, төмөр зам	Замын захын тэнхлэг		Гудамж замын хашлага чулуу (явах хэсгийн зах, хажуугийн зурвас) хүртэл	Шуудууны гадна ирмэг буюу замын асгаасан хөрсний ул	Хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуурын суурь		
			1520мм өргөнтэй төмөр зам	750мм өргөнтэй төмөр зам, трамвайны зам			1кВ хүртэл хүчдэлтэй гадна гэрэлтүүлэг, троллейбус, трамвайны контактны сүлжээ	1-35 кВ хүртэл	35-110 кВ хүртэл буюу түүнээс дээш
Ус дамжуулах хоолой ба ариутгах татуургын даралтат шугам хоолой	5	3	4	2.8	2	1	1	2	3
Өөрийн урсгалтай ариутгах татуургын шугам хоолой(ахуйн ба борооны усны)	3	1.5	4	2.8	1.5	1	1	2	3
Дренаж	3	1	4	2.8	1.5	1	1	2	3
Сопуствующий) дренаж	0.4	0.4	0.4	0	0.4	-	-	-	-
Шатдаг хий дамжуулах хоолой: даралт МПа(кгс/см ²) Нам даралтын 0.005(0.05) хүртэл	2	1	3.8	2.8	1.5	1	1	5	10
Дунд 0.005(0.05)-0.3(3) хүртэл	4	1	4.8	2.8	1.5	1	1	5	10
Өндөр 0.3(3)-0.6(6)	7	1	7.8	3.8	2.5	1	1	5	10
0.6(6)-1.2(12)	10	1	10.8	3.8	2.5	2	1	5	10
Дулааны сүлжээ: Суваг, хонгилын гадна хананаас Суваггүй тавигдсан шугам	2 (тайлбар-3-ыг үз)	1.5	4	2.8	1.5	1	1	2	3
сүлжээний гадна талаас	5	1.5	4	2.8	1.5	1	1	2	3
Бүх төрлийн хүчдэлтэй хүчний болон холбооны кабелиуд	0.6	0.5	3.2	2.8	1.5	1	0.5*	5*	10*
Шугам сүлжээний хонгил, сувгууд	2	1.5	4	2.8	1.5	1	1	2	3*
Гадна хог дамжуулах хийн шахалтын хоолой	2	1	3.8	2.8	1.5	1	1	3	5

*Энэ зай зөвхөн хүчний кабельд хамаарна.

Тайлбар*:

БНБД 30.01.04

1. Мөнх цэвдэг хөрс бүхий уур амьсгалын I, IIa, IIб дэд бүсүүдэд газар доорх шугам сүлжээнээс барилга байгууламж хүртэлх зай хэмжээг техникийн тооцоогоор авна.
2. Газар доорх инженерийн шугам сүлжээг контактны сүлжээ, дамжуулах хоолойн эстакадны суурь ба тулгуурын суурийн хязгаарт байрлуулахдаа суурийн суултнаас шугам сүлжээ гэмтэх, шугам сүлжээний аваар ослоос болж суурийг гэмтээхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан тохиолдолд төлөвлөхийг зөвшөөрнө. Барилгын ус бууруулагчтай жийргэвч дээр байрласан инженерийн шугам сүлжээг байрлуулахдаа барилга байгууламж хүртэлх зай хэмжээг буурь хөрсний бат бэх алдагдах боломжит бүсийг тооцож тогтооно.
3. Суваггүй тавигдсан дулааны шугам сүлжээнээс барилга байгууламж хүртэлх зай хэмжээг ус дамжуулах хоолойтой адилаар авна.
4. 110-220 кВ хүчдэлтэй хүчний кабелиас үйлдвэрийн барилгын суурийн хашлага, эстакад, контактны сүлжээний тулгуур ба холбооны шугам хүртэлх зайг 1.5м байхаар тооцно.
5. Усжуулалтын системтэй, суултгүй хөрстэй бүсэд газар доорхи инженерийн шугам сүлжээнээс усжуулалтын суваг хүртэлх зайг (сүлжээний ирмэг хүртэл)дор дурьдсан байдлаар авна.Үүнд:
 - нам, дунд даралтын хий дамжуулах хоолой, мөн ус дамжуулах хоолой, ариутгах татуургын, гадаргын усны болон шатдаг шингэн дамжуулах хоолойнуудаас-1м;
 - 0.6 МПа(6 кгс/см²) хүртэл өндөр даралтын дулаан дамжуулах хоолой, ахуйн болон борооны ус зайлуулах ариутгах татуургын шугам хоолойноос-2м;
 - хүчний болон холбооны кабелиас 1.5м;
 - гудамжны сүлжээний усжуулалтын сувгаас барилга байгууламжийн суурь хүртэл 5м зайтай байна.

Техникийн найдвартай, аюулгүй байдлын нөхцөл шаардлагыг бүрэн хангасан арга хэмжээнүүдийг авсан тохиолдолд энэхүү нормын 14, 15 дугаар хүснэгтүүдэд заасан зай хэмжээг багасган авахыг зөвшөөрнө.

- 7.11. Инженерийн шугам сүлжээ нь явган хүний нэвтрэх гарц бүхий хонгилтой огтлолцсон тохиолдолд дамжуулах хоолойг хонгилын доогуур, хүчний болон холбооны кабелийг хонгилын дээгүүр байрлуулахаар төлөвлөнө.

Цахилгаан, дулаан болон хөргөлтийн хангамж, холбоо, радио шугамын төлөвлөлт

- 7.12. Цахилгаан эрчим хүчний зарцуулалт, эрчим хүч хангагч үүсвэрийн хүчин чадлыг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:
- Аж үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн газруудын хувьд ажиллаж байгаа үйлдвэрийн газруудын захиалга, шинэ, шинэчлэгдэж байгаа буюу ижил төстэй үйлдвэрийн газруудын зураг төсөл, түүнчлэн томсгосон үзүүлэлтүүдийг орон нутгийн онцлогийг тусган хэрэглэнэ.
 - Аж ахуй, нийтийн үйлчилгээний газруудын хувьд батлагдсан, зөвшөөрөгдсөн норм дүрмийн дагуу тодорхойлно.
 - Энэхүү нормын 17 дугаар хавсралтын зөвлөмжийн дагуу цахилгаан хэрэглээний томсгосон үзүүлэлтүүдийг авч тооцохыг зөвшөөрнө.
- 7.12. 110 кв, түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугамыг суурьшилын бүсийн гадна байрлуулбал зохино. Их хот, том хотын суурьшилын бүсэд, гүн оруулгын бууруулах

дэд станцад орох 110 кВ ба түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан сүлжээг кабель шугамаар төлөвлөнө. Эрчим хүчний ерөнхий системд ордог цахилгаан дамжуулах шугамыг аж үйлдвэрийн бүсийн дэвсгэрт болон хөдөө аж ахуйн үйлдвэрийн газруудын үйлдвэрлэлийн бүсэд байрлуулахыг зөвшөөрөхгүй.

- 7.13. Хотын шинэчлэлтийг хийхдээ 35-110 кВ ба түүнээс дээш хүчдэлтэй ашиглагдаж байгаа цахилгаан дамжуулах агаарын шугамыг суурьшлын бүсийн гадна гаргах юм уу эсвэл кабель шугамаар солихоор тусгах ёстой. Харин их хотын хувьд чөлөөлөгдсөн газарт орон сууц, олон нийтийн барилга барьж байгуулах нь зохистой бол ашиглагдаж байгаа гүн оруулгын ил бууруулах дэд станцыг хаалттай болговол зохино. Цахилгаан эрчим хүч дамжуулах, түгээх сүлжээний хамгаалах зурвасыг тодорхой тусгах ёстой.
- 7.14. 4 ба түүнээс дээш давхар барилгажилттай хот, суурин газрын суурьшлын бүсэд 20 кВ хүртэл хүчдэлтэй цахилгаан сүлжээг кабель шугам байхаар тусгана. Харин рашаан сувилалын цогцолборын дэвсгэрт бүх хүчдэлийн сүлжээг кабель шугамаар төлөвлөх ёстой.
- 7.15. 16 мян. кВА ба түүнээс дээш чадалтай трансформатор бүхий бууруулах дэд станц болон агаарын шугам кабельд шилжих шилжвэрийг суурьшлын бүсэд байрлуулах бол, түүнчлэн рашаан сувилалын дэвсгэрт бүх төрлийн трансформаторын дэд станц, хуваарилах байгууламж байрлуулбал тэдгээрийг хаалттай хэлбэрээр төлөвлөнө. Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийг мөрдлөг болгон хамгаалалтын зурвас төлөвлөх ёстой.
- 7.16. Хаалттай бууруулах дэд станцууд болон 110-220 кВ хүчдэлтэй иж бүрэн хуваарилах байгууламжийн эдэлбэр газрын хэмжээг 0.6 га-гаас ихгүй байхаар, агаарын шугам кабельд шилжих шилжвэрийнх 0.1 га-гаас ихгүй байхаар төлөвлөнө.
- 7.17. Тус бүр 1000 кВА хүртэл хүчин чадалтай 2 хүртэл тооны трансформатор бүхий 6-20кВ хүчдэлтэй дэд станц болон хуваарилах байгууламжийг байрлуулахдаа дуу чимээнээс хамгаалах арга хэмжээ болгон орон сууц, олон нийтийн барилгын цонхноос 10 метрээс багагүй, харин эмчилгээ – урьдчилан сэргийлэх байгууллагын барилгаас 15 м-ээс багагүй зайтай төлөвлөнө.

Найм. Инженерийн бэлтгэл ажил ба нутаг дэвсгэрийн хамгаалалт

- 8.1. Инженерийн бэлтгэл ажлын арга хэмжээг нутаг дэвсгэрийн инженер-геологи, гидрогеологийн нөхцөлийн өөрчлөлтийн, газар төлөвлөлт, зохион байгуулалт, ашиглалтын байдлаас хамааруулан төлөвлөнө. Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын зураг төслийг боловсруулахдаа гадаргуугийн усыг зайлуулах, хөрсний ус доошлуулах, үерийн аюул, уруй, цасны нуралт, хөрсний гулгалт, нуралтаас хамгаалсан инженерийн барилга байгууламжийг тусгаж өгөх ёстой.

Инженерийн шугам сүлжээ	Хэвтээгээр доорх цэгүүд хүртэлх зай, м												
	Ус дамжуулах хоолой	Ахуйн бохир усны ариутгах татуургын хоолой	Ус шүүрүүлэх болон борооны ус зайлуулах хоолой	Хий дамжуулах хоолой, даралт МПа(кгс/см ²)				Бүх төрлийн хүчдэлтэй хүчний кабель	Холбооны кабель	Дулааны шугам сүлжээ		Суваг, хонгил	Гадна хог зайлуулах хийн шахалтын хоолой
				Нам 0.005 (0.05) хүртэл	Дунд 0.005(0.05)-0.3(3) хүртэл	өндөр				Хонгил сүлжээний гадна хана	Суваггүй тавигдсан шугам хоолойн гадна талаас		
				0.3(3) 0.6(6) хүртэл	0.6(6) 1.2(12) хүртэл								
Ус дамжуулах хоолой	Тайл бар-1	Тайл бар-2	1.5	1	1	1.5	2	0.5*	0.5	1.5	1.5	1.5	1
Ахуйн бохир усны ариутгах татуургын хоолой	Тайл бар-2	0.4	0.4	1	1.5	2	5	0.5*	0.5	1	1	1	1
Борооны ус зайлуулах хоолой	1.5	0.4	0.4	1	1.5	2	5	0.5*	0.5	1	1	1	1
Хий дамжуулах хоолой даралт МПа(кгс/см ²)													
Нам 0.005(0.05)	1	1	1	0.5	0.5	0.5	0.5	1	1	2	1	2	1
Дунд 0.005(0.05)-0.3(3) хүртэл	1	1.5	1.5	0.5	0.5	0.5	0.5	1	1	2	1	2	1.5
өндөр 0.3(3)-0.6(6) хүртэл	1.5	2	2	0.5	0.5	0.5	0.5	1	1	4	1.5	2	2
0.6(6)-1.2(12)	2	5	5	0.5	0.5	0.5	0.5	2	1	2	2	4	2
Бүх төрлийн хүчдэлтэй хүчний кабель	0.5*	0.5*	0.5*	1	1	1	2	0.1-0.5*	0.5	2	2	2	1.5
Холбооны кабель	0.5	0.5	0.5	1	1	1	1	0.5	-	1	1	1	1
Дулааны сүлжээ													
Суваг, хонгилын гадна хананаас	1.5	1	1	2	2	2	4	2	1	-	-	2	1
Суваггүй тавигдсан шугам сүлжээний гадна талаас (от оболочки)	1.5	1	1	1	1	1.5	2	2	1	-	-	2	1
Суваг, хонгил	1.5	1	1	2	2	2	4	2	1	2	2	-	1
Гадна хог дамжуулах хийн шахалтын хоолой	1	1	1	1	1.5	2	2	1.5	1	1	1	1	-

Тайлбар:

- Зэрэгцээ байрласан хэд хэдэн ус дамжуулах шугам сүлжээний хоорондын зайг техникийн болон инженер-геологийн нөхцлөөс хамааруулан холбогдох норм дүрмийн дагуу төлөвлөнө.
- Ахуйн ариутгах татуургын шугам хоолойноос унд-ахуйн ус дамжуулах хоолой хүртэлх зайг :
 - Төмөр бетонон болон асбестоцементэн хоолойноос ус дамжуулах хоолой хүртэл - 5м;
 - 200мм хүртэл диаметртай ширмэн хоолойноос ус дамжуулах хоолой хүртэл- 1.5м; 200мм-ээс дээш диаметртай үед -3м;
 - Хуванцар хоолойноос ус дамжуулах хоолой хүртэл -1.5м зайтай байхаар сонгож авна.

Ариутгах татуургын ба үйлдвэрийн ус дамжуулах шугам сүлжээнүүдийн хоорондын зай нь дамжуулах хоолойн материал, диаметр болон хөрсний төрөл шинж чанараас хамааран 1.5м байх ёстой.

3. Зэрэгцээ байрласан 300мм хүртэл диаметртэй хийн дамжуулах хоолойн хоорондын зай - 0.4м, нэг сувагт 2 ба түүнээс дээш хий дамжуулах хоолойг хамтад нь байрлуулсан үед хоолойн диаметр 300мм-ээс дээш бол хоорондын зайг 0.5 м-ээр авахыг зөвшөөрнө.
4. Хий дамжуулах ган хоолой хүртэлх зайг энэхүү бүлгийн 15 дугаар хүснэгтэд зааснаар, хий дамжуулах хоолойг байршуулахдаа металл биш хоолойноос холбогдох норм дүрмийн дагуу авахаар төлөвлөнө.

8.2. Талбайн өндөржилтийн төлөвлөлтийг боловсруулахдаа:

- байгалийн рельеф, ургамлын өнгөн давхарга хөрс, мод ургамлын онгон байдлыг дээд зэргээр хадгалан хэвээр үлдээх;
- гадаргуугын усыг хөрсний эвдрэлд нөлөөлөхгүйгээр зайлуулах;
- барилга барих талбайд хөрс хуулалт хийхдээ, газар шорооны ажлаас гарах хамгийн бага хэмжээтэй шороог хүртэл ашиглахаар тооцоолж зураг төслийн түвшинг тогтоох;
- Газар шорооны ажлыг гүйцэтгэх норм дүрмийг дагаж мөрдөнө.

8.3. Гадаргуугийн усыг (усан сан, ус урсгуур, гуу жалга г.м.) холбогдох норм дүрмийг баримтлан бүх усан сангаар зайлуулахаар, харин хот, тосгоны газарт хур борооны усыг далд хэлбэрээр зайлуулахдаа урсацыг нь урьдчилан тогтоож, цэвэрлэнэ. Ус зайлуулах ил задгай төхөөрөмжүүд болох суваг, шуудуу, ховилуудыг 1-2 давхар барилгажилттай тосгонд, мөн цэцэрлэгт хүрээлэн бүхий явган хүний зам талбай, жижиг гүүр, ус зайлуулах хоолой бүхий гудамжны уулваруудтай газруудад ашиглахыг зөвшөөрнө.

8.4. Суурьшлын бүсийн хөрсний усны түвшин өндөр, намгархаг газрын барилгажих хэсэгт хөрсний усны түвшинг бууруулах далд хэлбэрийн ус шүүрүүлэгч(дренаж)-ийг төхөөрөмжлөхөөр төлөвлөнө. Хот, тосгоны цэнгэлдэх хүрээлэн, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжууд бүхий олон нийтээр ашигладаг газруудад ил намаг хатаалгын шугам сүлжээг ашиглахыг зөвшөөрнө.

Дэвсгэр нутгийн хөрсний усны түвшинг бууруулахдаа холбогдох норм дүрмийн заалттай бүрэн нийцсэн арга хэмжээнүүдийг авах бөгөөд үндсэн барилгын хувьд төлөвлөж буй барилгын гадаргууны түвшингээс доош-2м, цэнгэлдэх хүрээлэн, цэцэрлэгт хүрээлэн болон бусад ногоон байгууламжид 1м-с доош байхаар төлөвлөнө.

8.5. Барилга барихаар төлөвлөж буй газар нь хүлэртэй (торф), мөн хөрсний усны түвшинг бууруулахаар бол тэдгээрийн гадаргууг эрдэс баялаг бүхий хөрсөөр баяжуулах ба мөн зохих үндэслэл бүрдсэн нөхцөлд хүлэргүйжүүлэлт хийхийг зөвшөөрнө. Эрдэс баялаг бүхий хөрсөөр булах үеийн зузааныг хүлэрийн тунаш болон гадаргуугын урсацыг тогтоох газрын налууг тооцсоны үндсэн дээр тогтооно. Эрдэс баялаг бүхий хөрсөөр булах үеийн хамгийн бага зузааныг бичил хороололуудын нутаг дэвсгэр дээр -1м, гудамжны зорчих хэсэг дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөний ачааллаас хамааруулан тодорхойлно.

8.6. Гол мөрний эрэг орчимд байрлалтай тосгоны нутаг дэвсгэрт үерийн аюул, хөрсний усны түвшин нэмэгдэж эрэг нурахаас урьдчилан сэргийлэх хамгаалалт, инженерийн барилга байгууламжийг нутаг дэвсгэрийн өндөржилттэй уялдуулан төлөвлөнө.

БНБД 30.01.04

- 8.7. Уруйн (шар усны аюул, үер) аюултай бүсэд барих барилга байгууламжийг хамгаалахын тулд ой модыг дээд зэргээр хамгаалах, мод сөөг тарьж ургуулах, хиймэл нуурын байгууламж барих, голын эрэгт далан хаалт хийж бэхлэх, уруйн урсгалыг тогтоох инженерийн барилга байгууламжуудыг зайлшгүй төлөвлөх хэрэгтэй.
- 8.8. Эрозийн үйлчлэлийн явцад гуу, жалга үүссэн газарт гадаргын усны урсгалыг зохион байгуулалттай урсгах, жалганы суурь ёроолыг бэхжүүлэх, энгэр газрыг тэгшлэх, ойжуулахаар төлөвлөнө. Онцгой тохиолдолд гуу, жалгыг бүрэн ба хэсэгчлэн тэгшлэх арга хэмжээг авахдаа тэдгээрийн доор гадаргын усыг урсган зайлуулах хоолой болон дренажны коллекторуудыг байрлуулахыг зөвшөөрнө. Гуу, жалгатай газруудад тээврийн хэрэгслийн гараж, аж ахуйн агуулах, түүнчлэн цэцэрлэгт хүрээлэнг барьж ашиглахыг зөвшөөрнө.
- 8.9. Хөрсний гулсалт, нүүлтийн явцад өртөгдөж болзошгүй нутаг дэвсгэрийн хот, суурингуудад дараах арга хэмжээнүүдийг авч, төлөвлөлт хийнэ. Үүнд:
- гадаргуугийн усны урсгалыг зохицуулан урсгах;
 - хөрсний усны урсгалыг зохицуулах арга хэмжээ авах;
 - байгалийн контрфорсыг гулсалтын хүчний эвдрэлээс хамгаалах,
 - механик болон физик химийн аргаар налуу газрын бат бэх байдлыг бэхжүүлэх, ногоон таримал тарих зэрэг ажлуудыг зайлшгүй тусгах.

Хөрсний нүүлт, гулсалтаас хамгаалах арга хэмжээг тухайн газрын геологи-гидрогеологийн нөхцөлийг иж бүрэн судалсаны үндсэн дээр авна.

Ес. Хүрээлэн буй орчин, түүх соёлын дурсгалыг хамгаалах төлөвлөлт

- 9.1. Хот, тосгоныг өргөтгөж хөгжүүлэх, шинээр хот тосгон барих нутаг дэвсгэрийг Монгол улсын "Газрын тухай" хуулийн дагуу төлөвлөнө.
Хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглах нутаг дэвсгэрт шинээр хот тосгон барьж байгуулах болон зориулалтын бус үйл ажиллагаа явуулахдаа, тогтоогдсон журмын дагуу гүйцэтгэхээс гадна дархан цаазат өндөр зэрэглэлийн нутаг дэвсгэрт дээрх үйл ажиллагааг явуулахыг хориглоно.
- 9.2. Ашигт малтмал боловсруулалтын үйлдвэр барих нутаг дэвсгэрт хайгуулын ажлын үнэлгээ болон үйлдвэр барих иж бүрэн техник эдийн засгийн үндэслэл тооцоо хийгдсэн байх ёстой.
- 9.3. Барилга байгууламж, шугам сүлжээг доорхи нөхцөлд байршуулахыг хориглоно. Үүнд:
- ◆ Дархан цаазтай газар, улсын нөөцийн газар, байгалийн үндэсний парк, ботаникийн цэцэрлэг, гоёл чимэглэлийн мод үржүүлгийн газар, усны хамгаалалтын зурвас байгуулах;
 - ◆ Хотын ойн орчин, хотын ногоон бүсийн нутаг дэвсгэрт хотын ойн аж ахуй, амралт, спортын зориулалттай объект байрлахаас бусад;
 - ◆ Гидрометеорологийн станцын хамгаалалтын бүсэд;
 - ◆ Усны эх үүсвэрийн ашиглалттай холбоотой объект байрлахаас бусад ус дамжуулах байгууламжийн талбай, усаар хангах эх үүсвэрийг ариун цэврийн хамгаалалтын нэгдүгээр бүсэд;
 - ◆ Рашаан сувиллын болон байгалийн эмчилгээний техник хэрэгслийн объект байрлахаас бусад рашаан сувилалыг ариун цэвэр хамгаалалтын нэгдүгээр бүсэд;
 - ◆ Рашаан сувиллын газрын тохижилт, ашиглалттай холбоотой объект, болон агаар мандал, хөрс, усыг бохирдуулахгүй, дуу чимээ, цахилгаан соронзоны хүчдлийн

нормативт хэмжээнд байгаа үйлчилгээний объектыг рашаан сувилалын ариун цэврийн хамгаалалтын хүрээний хоёрдугаар бүсэд, сувиллын амрагчдад зориулсан үйлчилгээний объект болон сувиллын ариун цэвэр-эрүүл ахуйн орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байгалийн эмчилгээний зориулалттай объектыг гуравдугаар бүсэд тус тус байрлуулахыг зөвшөөрнө.

Тайлбар :

1. Доорхи нөхцөлд барилга байгууламжийг байршуулахыг бүрэн хориглоно. Үүнд:
 - ◆ Органик буюу радио идэвхит хаягдлаар бохирдсон газарт;
 - ◆ Чулуун нүүрс, занарын уурхай, баяжуулах үйлдвэрийн хориотой бүс, гулсалттай, холимог чулууны урсацтай, цасан уруй их үүсдэг бүсэд;
 - ◆ Усны үерлэлтийн аюултай бүсэд (усны үерлэлтийн аюултай бүс гэдэг нь хальсан усны гүн 1.5 м, түүнээс их байж хот суурин барилга байгууламжийг эвдэх дэвсгэр нутгийг хэлнэ.);
 - ◆ Газар хөдлөлтийн идэвхитэй бүсэд;
 - ◆ Гол гудамж замын дамжуулах хоолойн хамгаалалтын бүсэд.
 2. Дархан цаазат газрын хамгаалалтын бүсэд байгалийн унаган төрхийг гэмтээхгүй, барилга байгууламжийг байршуулахыг зөвшөөрнө. Гэхдээ дархан цаазат газрыг харьяалдаг дээд байгууллагатай зөвшөөрөлцсөн байх ёстой.
 3. Холбогдох хууль тогтоомжийн дагуу тээврийн байгууламжийг хамгаалалтын бүсэд байрлуулж болно.
 4. Хүрээлэн буй байгаль орчинд дам буюу шууд нөлөөлдөг объектуудыг байршуулахдаа экологийн тэнцвэрт байдлын болон хүн амын эрүүл ахуйн шаардлагыг тооцож, байгаль хамгаалал, байгалийн нөөцийг оновчтой ашиглаж, нөхөн сэргээх, хүрээлэн буй байгаль орчинг эрүүлжүүлэх арга хэмжээг нэгэн адил төлөвлөх ёстой.
-
- 9.4. 1 дүгээр зэрэглэлд хамаарах хотын болон рашаан сувиллын орчмын ой, хотын ногоон бүсийн ойг амрах, ариун цэвэр-эрүүл ахуйн, эрүүлжүүлэх үйл ажиллагаанд ашиглахаар тооцно. Улсын ойн фондын орчинд барилгажилтын ажил хийх бол зөвхөн тогтоосон хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэх ёстой.
 - 9.5. Хотын захын нутаг дэвсгэрт ойн фонд, ногоон бүс гаргаж төлөвлөх ёстой. Хотын ногоон бүсийн нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг ойг эрүүлжүүлэх болон байгаль хамгаалах шаардлагад нийцүүлэх, хүн амын амрах нөхцөлд зохицуулах ёстой. Ногоон бүсэд экологийн тэнцвэрт байдлын эсрэг болон ариун цэвэр-эрүүл ахуй, хүн ам амрах үйл ажиллагаанд сөрөг нөлөөтэй аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
 - 9.6. Хот, тосгон орчмын ойгүй ба бага ойтой нутаг дэвсгэрт салхины хамгаалалтын болон эргийн бэхжүүлэлтийн ойн зурвасыг төлөвлөнө. Зурвасын өргөн нь их хотод 500м, том, дунд хотод 100 м, бага хот, сууринд 50 м –ээс ихгүй байна.
 - 9.7. Хот, хот орчмын нутагт дэвсгэрийн барилгажилт төлөвлөлтийн төсөлд байгалийн ландшафтыг ашиглах, түүнийг тогтвортой хамгаалах замаар амралт, зугаалгын зориулалтаар ачаалалыг зохицуулан төлөвлөнө. Мөн дархан цаазат газар, нөөц газар, байгалийн үндэсний парк, ургамал судлалын цэцэрлэг, модыг ургамлын цэцэрлэгт хүрээлэн болон байгалийн дурсгалт газруудад ойн, усны, геологийн ашиглалтын горимын шаардлагыг тодорхой тусгаж өгнө.

9.8. Мал, шувуу, ангийн аж ахуйн үйлдвэр, бордоо, хортой химийн бодис, био-бэлдмэл хадгалдаг агуулах, галын ба дэлбэрэх аюултай үйлдвэрлэл, тэдгээрийн агуулах, мал эмнэлгийн байгууллага, хаягдал устгах объект болон үйлдвэр, уурын зуух, цэвэрлэх байгууламж, өтөг хадгалах задгай станц зэргийг холбогдох норм дүрмийн дагуу хүн амын суурьшлын бүс, үйлдвэрийн бүсийн салхины доод талд, салхины зонхилох чиглэлийн дагуу байрлуулна.

Тайлбар:

1. Ариун цэврийн хамгаалалтын бүсийн хэмжээ нь 500 м-ээс дээш байдаг, агаараар дамжуулан хорт бодисоор бохирдуулдаг үйлдвэрийн газрыг зонхилох салхи нь 1м/с хүртэл хурдтай, агаарын тогтуун байдал, инверси, манан нь аажмаар буюу байнга давтагддаг, тэр нь жилд 30-40%-иас илүү ялангуяа өвлийн өдөрт хэмжээ нь 50-60% байдаг нутаг дэвсгэрт байрлуулж болохгүй.
 2. Агаарын бохирдлын тооцоог энэхүү нормын 3 дугаар бүлгийн шаардлагын дагуу хийнэ.
- 9.9. Усан сан, усны урсгал, далайн усан мандлыг хамгаалах арга хэмжээг тогтоосон журмаар ариун цэврийн норм, усны хууль тогтоомжийн шаардлагын дагуу, хүн амын амралт, бусад үйлдвэрлэлийн зорилгоор, ундны усан хангамжид ашигладаг усанд байх бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээний нормыг хадгалах үүднээс гадаргын ба газрын гүний усыг бохирдлоос хамгаалахаар төлөвлөнө.
- 9.10. Хот, тосгоны хүн амын суурьшлын бүс, рашаан сувиллын бүс, олон нийтийн амрах орчинг үйлдвэрлэл, аж ахуй, ахуйн бохир усыг оруулдаг усан сан, усны урсгалын эсрэг талд төлөвлөнө. Эдгээр орчныг зайлшгүй нөхцлөөр урсгалын дагуу байрлуулах тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.
- Тээврийн буудал, онгоцны зогсоол зэрэг бусад тоног төхөөрөмжөөр үйлчилдэг үйлдвэр, аж ахуйн газрыг голын урсгалын дагуу, хүн амын суурьшлын бүсээс 200м-ээс багагүй зайд төлөвлөнө.
- 9.11. Аж үйлдвэрийн газрын үйлдвэрлэлийн талбайг усан сангийн эрэг орчмын усан сантай шууд залгаа байлгах шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжийн дагуу усны хамгаалалт, ашиглалтыг зохицуулдаг байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр гүйцэтгэнэ. Усан сантай энэ талбайн нийлэх зурвасын тоо, урт нь хамгийн бага байна.
- Усан сангийн эрэг орчмын барилгажаагүй зурвасын өргөнийг 40м-ээс багагүйгээр төлөвлөнө.
- Ургамал хамгаалалын болон химийн бодис, эрдэс бордооны агуулах, мал аж ахуйн ба шувууны аж ахуйн үйлдвэрийг байрлуулахдаа тэдгээрээс ялгарах хорт бодис, өтөг шивх, цангасыг усан санд орохоос хамгаалж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөнө.
- Ургамал хамгаалалын болон химийн бодис, эрдэс бордооны агуулахыг загасны аж ахуй болон усан сангаас 2 км-ээс багагүй зайд байршуулах ёстой. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд дээр дурьдсан агуулахаас загасны аж ахуйн усан сан хүртэлх зайг загасны аж ахуйг эрхлэх дээд байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр багасгахыг зөвшөөрнө.
- 9.12. Усны халилтын олон жилийн дундажаар тогтоогдсон гол мөрний сав газрын эргээс суурингийн ус хамгаалалтын бүсийн өргөний доод хязгаарыг дараах тооцоогоор тогтооно.

Үүнд:

10 км хүртэл	- 15м
11-ээс 50 км	- 100 м
51-ээс 100 км	- 200 м
101-ээс 200 км	- 300 м
201-ээс 500 км	- 400 м
500 км-ээс дээш	- 500 м

Мөн олон жилийн дунджаар авсан нуурын сав газрын эргээс хамаарч усан мандлын талбай 2 км^2 хүртэл байхад 300 м, 2 км^2 -аас дээш бол 500 м-ээр тогтооно. Гол мөрөн, нуур, усан сангийн эрэг дагуу аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хязгаарласан дэвсгэр нутаг бүхий эрэг орчмын зурвас төлөвлөнө.

Гол, мөрөн, нуур, усан сангийн усны хамгаалалтын бүсэд байрлуулахыг хориглох объект:

- ахуйн хатуу хог хаягдал, аж үйлдвэрийн ашигладаггүй хаягдалд зориулсан полигон, хортой химийн бодис, эрдэс бордоо, шатах, тослох материалын агуулах, хортой химийн бодисоор аппарат цэнэглэх талбай, мал аж ахуйн цогцолбор ба ферм, оршуулгын газар;
- байгаль хамгаалах болон ариун цэвэр - гоц халдвартын хяналтын байгууллагатай тохиролцоогүй бол үйлдвэрлэлийн ба нийгмийн хүрээний объектыг өргөтгөх, шинээр барих;
- эрэг орчмын зурвасын дотор дээр дурьдсан хязгаарлалтаас гадна жижиг хотхон барих, зуны улиралд мал билчээхийг хориглоно.

Усан сан, түүний доод хэсгийг ашиглах, ахуй-ундны ба соёл-ахуйн усны хэрэгцээний эх үүсвэр болгон хэрэглэх буюу хэрэглэхийг төлөвлөж байгаа бол усан сангийн төсөл зохиох, байгуулах, ашиглахад зориулсан ариун цэврийн дүрмийг мөрдөж, тогтоож батлагдсан журмын дагуу хэрэгжүүлэх ёстой.

Усан сан, усны урсгалын эрэг дээр байрлах амралтын бүсийг байгуулах зураг төслийг зохиохдоо усны хамгаалалтын талаар авах арга хэмжээ холбогдох норм дүрмийн шаардлагыг хангасан байвал зохино.

Усан сан, гол мөрний эрэг дээр амралтын бүс байгуулах төслийг зохиохдоо усны хамгаалалтын талаар авах арга хэмжээг тусгаж, холбогдох техникийн баримт бичгийн шаардлагыг мөрдөх ёстой.

9.13. Гадаргын усыг задгай усанд юүлэхдээ (хайхад) цэвэрлэх ёстой. Үйлдвэрийн бүсээс гадаргын усны урсацыг усны объектод оруулахыг үйлдвэрлэлийн усан хангамжид ашиглах техникийн боломжгүй, эдийн засгийн үр ашиггүй нөхцөлд зөвшөөрнө.

9.14. Хот, тосгоны нутаг дэвсгэр дэх усан оргилуур, усанд орох зориулалттай усан сангийн усыг усан толины талбайгаас нь хамааруулан намрын улиралд тогтмол сольж байхаар төлөвлөнө. Тухайлбал, усан оргилуурын тухайд усан толины гадаргуугийн талбай 3 га хүртэл бол хоёр удаа, 3 га-гаас дээш бол нэг удаа, усанд орох зориулалттай усан сангийн усыг 3-аас доошгүй удаа, харин 6 га-гаас дээш талбайтай бол хоёр удаа солино.

Суурьшлын бүсэд 1.5 м-ээс ихгүй гүнтэй усан сан төлөвлөхийг зөвшөөрнө. Усан толь болон наран шарлагын талбайг энэхүү нормын 4.20 зүйлд заасан болон холбогдох норм дүрмийн дагуу төлөвлөнө. Усан сангийн эрэг орчмыг тохижуулж, усан санг гадаргын усны бохирдолоос хамгаалахаар төлөвлөнө.

9.15. Хот, тосгоны нутаг дэвсгэрийн хөрсийг хамгаалах арга хэмжээг тогтоогдсон хууль тогтоомж ёсоор төлөвлөнө. Хот, тосгоны үндсэн элементүүдийг дуу чимээ, цахилгаан, соронзон

БНБД 30.01.04

талбай, цацраг туяанаас хамгаалах, нутаг дэвсгэрийг дуу чимээ, доргио, цахилгаан ба соронзон гүйдэл элдэв хорт туяаны цацрагаас хамгаалж төлөвлөнө.

- 9.16. Орон сууц, олон нийтийн барилга байгууламж, тэдгээрийн орон зайн орчны дуу чимээний хэмжээ, шуугианаас хамгаалах арга хэмжээг холбогдох норм дүрмийн дагуу төлөвлөнө.
- 9.17. Орон сууцны барилгын чичиргээ доргилтыг зөвшөөрөгдөх хэмжээнд холбогдох норм дүрмийн дагуу төлөвлөнө. Орон сууцны барилга болон ойролцоох чичиргээ, доргио үүсэх барилга хоорондын зайг оновчтой тогтоож, сууцны барилга байгууламжид нь дуу чимээнээс тусгаарлах материал, хийц бүтээц төлөвлөх ёстой.
- 9.18. Цахилгаан соронзон цацруулдаг өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, радиотехникийн объектуудыг эрүүл ахуй - ариун цэврийн норм дүрмийн дагуу байрлуулж төлөвлөнө. Гэхдээ эдгээр объектын радио идэвхит бодис, цацрагийн иончлогдох бусад эх үүсвэрийг үйлдвэрлэх, боловсруулах, дахин боловсруулах, амьдрал ахуйдаа ашиглах, хадгалах, тээвэрлэх, хоргүйжүүлэх үеийн аюулгүй байдлыг хангах асуудлыг ариун цэвэр – эрүүл ахуйн норм дүрмийн дагуу төлөвлөнө.

Бичил уур амьсгалын төлөвлөлт

- 9.19. Сургууль, цэцэрлэг, дотуур байртай сургуулиас бусад орон сууц, олон нийт, иргэний барилга байгууламжийн цонхоор хавар, зун, намрын улирлын нэг өдөрт тусах нарны тусгалын үргэлжлэх хамгийн бага хугацааны нийлбэр нь уур амьсгалын I, II бүсэд 3 цаг, уур амьсгалын III, IV бүсэд 2.5 цаг байхаар тооцож төлөвлөнө. Харин ерөнхий боловсролын сургууль цэцэрлэг, эмчлэн сэргийлэх зориулалттай болон амралт сувилалын барилгын цонхоор нэг удаагийн тасралтгүй үргэлжлэн тусах хамгийн бага хугацаа 3 цаг байх ёстой.

Тайлбар:

1. 9 ба түүнээс дээш давхар барилга байгууламжийн сууцны өрөөний цонхоор тусах нарны үргэлжлэх хугацааны нэг өдрийн нийлбэр уур амьсгалын бүх бүсэд 0.5 цаг байж болно
2. Бүх өрөөнүүдэд нар жигд үргэлжлэн тусах боломжтой архитектурын төлөвлөлтэй барилга байгууламж болон нутаг дэвсгэр зохион байгуулалтын хувьд ихээхэн төвөгшилтэй орчинд барих барилгын сууцны өрөөнүүдэд нарны үргэлжлэн тусах хугацааг уур амьсгалын бүх бүсэд 0.5 цагаар хорогдуулж төлөвлөхийг зөвшөөрнө.
3. Уур амьсгалын I бүсэд барих орон сууц, олон нийт, иргэний барилга болон хэт ягаан туяаны хангамжийг тэгшитгэн зохицуулсан ерөнхий боловсролын сургуулийн барилгад тусах нарны тусгалын үргэлжлэх хугацааг 0.5 цагаар хорогдуулж төлөвлөхийг зөвшөөрнө.

Түүхийн ба соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах төлөвлөлт

- 9.20. Хот, тосгоны барилгажилт, төлөвлөлтийн төслийг боловсруулахдаа түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах, дархан цаазтай газрыг ашиглах, хамгаалах талаар гарсан хууль тогтоомж, архитектурын болон түүх - соёлын холбогдолтой эрх зүйн баримт бичгийг дагаж мөрдөнө. Төслөөр хот, тосгоны нутаг дэвсгэр дэх соёлын дурсгалт газрууд, дархан цаазат, байгалийн тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрийн бүсчлэлийг тогтооно.

Бүсчлэлийг тогтоохдоо барилга байгууламж, уран барилгын чуулга, хөшөө дурсгал, нутаг дэвсгэрийн ландшафтын онцлог, түүх, археологи, архитектурын ховор үнэт зүйлсийг хамруулан авч үзнэ.

9.21. Хот, тосгоны барилгажилт, төлөвлөлтийн төслийг боловсруулахдаа түүх-соёлын дурсгалт газрыг сэргээн засварлах, шинэчлэн сайжруулах, шинээр барьж байгуулах болон инженерийн тоног төхөөрөмжийн хангамжийн асуудлыг тусгана.

9.22. Хөшөө дурсгал, гудамж зам, инженерийн шугам сүлжээ хүртэлх зай хэмжээг "м"-ээр тогтоож, доор зааснаас багагүйгээр төлөвлөнө. Үүнд:

Газрын рельефийн төвөгтэй нөхцөлд	- 100м
Тэгш гадаргуутай нөхцөлд	- 50м
Цэвэр бохир ус дулааны шугам	- 15м
Газар доорх бусад шугам сүлжээ	- 5м

Энэ зайг ус дамжуулах шугам сүлжээ хүртэл 5 м, усгүй шугам сүлжээ хүртэл 2 м-ээр бууруулж төлөвлөхийг зөвшөөрнө. Гэхдээ барилга угсралтын ажил гүйцэтгэхэд саад болохгүйгээр арга хэмжээг авах шаардлагатай.

Хот, тосгоны барилгажилт төлөвлөлтийн төслийг боловсруулахад мөрдөх хууль эрх зүйн баримт бичгийн жагсаалт.

1. Монгол улсын Үндсэн хууль
2. Монгол улсын Хот байгуулалтын тухай хууль
3. Монгол улсын Газрын тухай хууль
4. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль
5. Монгол улсын Барилгын тухай хууль
6. Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай багц хууль
7. Монгол улсын Эрүүгийн хууль
8. Монгол улсын Захиргааны хариуцлагын тухай хууль
9. Монгол улсын Орон сууцны тухай хууль
10. Монгол улсын Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль
11. Монгол улсын Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль
12. Монгол улсын Ариун цэврийн тухай хууль
13. Монгол улсын Галын аюулгүй байдлын тухай хууль
14. Монгол улсын Усны тухай хууль
15. Монгол улсын Засгийн газрын 100 дугаар тогтоол
16. Монгол улсын Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм
17. Монгол улсын Барилгын техник хяналтын улсын дүрэм

Нэр томъёоны тайлбар толь

1. *Бус нутаг* – Аймаг, сум, нийслэл, дүүрэг, хот тосгоны хоорондын нийгэм, эдийн засгийн харилцаа холбоо, тусгай хамгаалалттай газар нутаг, тэдгээрийн орчны бүс, хүн амын нутагшилт, хөдөө аж ахуй, аялал жуулчлал болон аж ахуйн бусад салбар (салбар хооронд)-ын уялдаа холбоо, орон зайн хөгжил, байршлын хүрээг хамарсан Монгол улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг буюу эдийн засаг, нийгмийн цогцолборыг хэлнэ.
2. *Орон сууцны бичил хороолол*- Орон сууцны хэд хэдэн бүлэглэлээс бүрдсэн хотын бүтэц дэх хот төлөвлөлтийн нэгэн нэгжийг хэлнэ. 8 000-10 000 хүн амтай, 10-25 га талбайд төлөвлөгдөж болно. Өдөр тутмын үйлчилгээний радиус нь 500 м-ээс ихгүй байна.
3. *Тосгон* – Нутаг дэвсгэр дэх хүн амын суурьшлыг бүрдүүлж буй засаг захиргааны бие даасан нэгж
4. *Капитал барилга* – Он удаан жил ашиглагдах хийц бүтээц, чанар сайтай барилга байгууламж
5. *Интерполяци* – Завсрын хэмжээ тогтоолт
6. *Ландшафт* – Байгалийн өвөрмөц тогтоцтой газар
7. *Рекреаци* – Амралт зугаалгын орон зайн орчин
8. *Орон сууцны хороолол*- Хэд хэдэн бичил хороололоос бүрдсэн хотын бүтэц дэхь хот төлөвлөлтийн нэгэн нэгжийг хэлнэ. 30 000-80 000 хүн амтай, 80-250 га талбай бүхий орон зайн цогцолбор. Үйлчилгээний радиус нь 1500 м-ээс ихгүй үйлчилгээний барилгууд буюу хотын чанартай үйлчилгээний барилгууд байрласан, гол гудамж ба хотын чанартай гудамж, нэвтрэхэд төвөгтэй ердийн болон хиймэл заагаар хязгаарлагдсан суурьшлын элемент юм.
9. *Дренаж* – Энэхүү нормын 8.4 дүгээр зүйлд заасан төхөөрөмж гэдэг үг нь хөрсний усыг татан зайлуулах насос, усны горимыг хянах худаг зэргийг хэлнэ.
10. *Хотын төв цэнгэлдэх хүрээлэн /общегородской парк/* - хотын бүх иргэдэд зориулагдсан соёл-үйлчилгээ, амралт цэнгүүн, биеийн тамир, урлаг спортын арга хэмжээ зохион явуулдаг, тоглоом ба үзвэрийн газар бүхий ногоон байгууламжийн хөвч юм.
11. *Хорооллын цэцэрлэг /районный парк/* - хорооллын иргэдийн амралт чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх зориулалттай газар бүхий ногоон байгууламж .
12. *Цэцэрлэгт талбай /сквер/* - иргэдийг түр амарч, алжаал тайлах зориулалттай 0.15 аас 2 га бүхий талбайтай ногоон байгууламж.
13. *Цэцэрлэгт гудамж /бульвар/* - явган хүний хөдөлгөөнийг цэгцлэх ба иргэдийн түр амарч, алжаал тайлах зориулалттай газар бүхий ногоон байгууламж юм.
14. *Цэцэрлэгт явган хүний зам /аллей/* - цэнгэлдэх хүрээлэнгийн ногоон байгууламж бүхий гол ба салбар замыг хэлнэ.
15. *Аллея* – модот гудамж

ОЛОН НИЙТ, ИРГЭНИЙ БАРИЛГЫН ТӨЛӨВЛӨЛТӨД МӨРДӨХ УУР АМЬСГАЛЫН
БҮСЧЛЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Галын аюулаас хамгаалах шаардлага

1. Орон сууц, олон нийтийн барилга болон үйлдвэр, үйлдвэрийн туслах барилга байгууламжийн хоорондох гал тусгаарлах хамгаалалтын зайг 1 дүгээр хүснэгтэд зааснаас багагүйгээр төлөвлөнө. Харин үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрийн барилга хоорондын гал эсэргүүцэх хамгаалалтын зайг холбогдох норм дүрмийн дагуу төлөвлөнө.

Гал тэсвэршилтийн I, II зэрэгтэй орон сууц, олон нийтийн барилга болон тэдгээрийн туслах барилгаас гал тэсвэршилтийн I, II зэрэгтэй гараж буюу үйлдвэрийн барилга хүртэлх зайг 9 м-ээс багагүйгээр, харин полимер болон галд хялбар шатдаг материалаар барьсан үйлдвэрийн барилга хоорондын зай 15 м-ээс багагүй байхаар төлөвлөнө.

1 дүгээр хүснэгт

Барилгын гал тэсвэршилтийн зэрэг	Барилга хоорондын гал тусгаарлах хамгаалалтын зай, м-ээр		
	I, II	III	IV
I, II	6	8	10
III	8	8	10
IV	10	10	15

Тайлбар:

- Барилгын гал тэсвэршлийн зэргийг БНБД 21-01-02-ын дагуу тогтооно.
- Барилга байгууламжийн хоорондох гал тусгаарлах хамгаалалтын зайг гадна хавтгайлжин ханын гадаргуу хоорондын хэмжээгээр тодорхойлно. Хэрвээ гадна хананд 1м-ээс дээш гадагш илүү гарсан бүтээц байвал гал тусгаарлах хамгаалалтын хэмжээг тухайн бүтээцийн гадаргуугаас тооцож төлөвлөнө.
- Гадна ханандаа цонхгүй барилгын гал тусгаарлах хамгаалалтын зайг гал тэсвэршилтийн III-IV зэрэгтэй барилгаас бусад барилгад 20% хүртэл бууруулахыг зөвшөөрнө.
- Газар хөдлөлтийн 9 баллын бүсэд барих орон сууцны барилга хоорондын болон орон сууц, олон нийтийн барилга хоорондын гал тусгаарлах хамгаалалтын зайн норматив хэмжээг гал тэсвэршилтийн IV зэрэгтэй барилгад 20% хүртэл ихэсгэж төлөвлөнө..
- Уур амьсгалын I бүсэд барих, гал тэсвэршилтийн бүх зэрэглэлд хамаарах барилгаас гал тэсвэршилтийн III - IV зэрэгтэй барилга хүртэлх зайн норматив хэмжээг 25% ихэсгэж төлөвлөнө.
- Уур амьсгалын I бүсэд барих, гал тэсвэршилтийн IV зэрэгтэй барилгуудын хоорондох гал тусгаарлах хамгаалалтын зайг 50% хүртэл ихэсгэн төлөвлөнө.
- Шатдаг материалаар барьсан 2 хүртэл давхар барилга хоорондын гал тусгаарлах хамгаалалтын зайг 20% нэмэгдүүлж төлөвлөнө.
- Хэрвээ эсрэг талын барилгын хана нь гал тэсвэршлийн зэрэгтэй бол гал тэсвэршилтийн I-II зэргийн барилга хоорондын гал тусгаарлах хамгаалалтын зайг 6 м хүртэл төлөвлөхийг зөвшөөрнө.
- Хувийн сууцны эдэлбэр газрын хоорондын гал тусгаарлах хамгаалалтын бүсийн зайг энэхүү хавсралтын 1 дүгээр хүснэгтэд зааснаар тогтоож, БНБД 21-01-02-ын шаардлагын дагуу төлөвлөнө.

БНБД 30.01.04

10. Галын норм БНБД 21-01-02-ын хүрээнд гал эсэргүүцэх ханагүй барих барилгын эдэлбэр газрын талбай нийт барилгажилтын талбайтай тэнцүү байх нөхцөлд сууц хоорондын болон сууц, аж ахуйн байгууламж хоорондын зайг нормчлохгүй.
11. Хувийн сууцны эдэлбэр газраас салгаж барих аж ахуйн байгууламжийн эдэлбэр газрын талбайн хэмжээ 800 м²-аас ихгүй байвал барилга хоорондын зайг нормчлохгүй. Харин аж ахуйн барилгыг зориулалтаар нь бүлэглэсэн хэсгүүдийн хоорондын зайг энэхүү хавсралтын 1 дүгээр хүснэгтэд зааснаар тооцож төлөвлөнө.
12. Явган зам, гарцыг орон сууц, олон нийтийн барилгын гал гарсан хэсэг болон туслах барилгууд, галын шат руу саадгүй очих, галын машин чөлөөтэй зорчих боломжтой төлөвлөнө.
Зам, гарцаас 10 хүртэл давхар барилгын хана хүртэлх зай 5м-ээс багагүй, 10-аас дээш давхар барилгын хана хүртэлх зай 8м-ээс багагүй байхаар тооцож төлөвлөнө. Энэ бүсэд ямар нэгэн хаалт, цахилгаан дамжуулах агаарын шугам болон мод эгнүүлэн тарихыг хориглоно.
Барилгын орцгүй ханын дагуу галын машин зорчих 6 м-ээс ихгүй өргөнтэй зурвас зай гаргаж төлөвлөхийг зөвшөөрнө.
13. Орон сууц, олон нийтийн барилгаас нефьтийн бүтээгдэхүүний агуулах хүртэлх зайн хэмжээг холбогдох норм дүрмийн дагуу тогтооно. Харин уурын зуух, дизель цахилгаан станц, бусад цахилгаан шугам сүлжээний объектуудын түлшний агуулахаас орон сууц, олон нийтийн барилга хүртэл зайн хэмжээг 2 дугаар хүснэгтэд зааснаас багагүйгээр тооцож төлөвлөнө .

2 дугаар хүснэгт

Агуулахын багтаамж, м ³	Орон сууц олон нийтийн барилгын гал тэсвэршилтийн зэрэг		
	I, II	III	IV
800-гаас 10000 хүртэл	40	45	50
100-гаас 800 хүртэл	30	35	40
100 хүртэл	20	25	30

Тайлбар: Цэцэрлэг, сургууль, дотуур байрт сургууль, эмнэлэг, амралт, үзвэрийн болон спортын барилга байгууламжаас 100 м³ хүртэл багтаамжтай агуулах хүртэлх зайг 2 дахин нэмэгдүүлж төлөвлөнө. Харин 100 м³-ээс дээш багтаамжтай агуулахын тухайд энэ зайг БНБД21-03-04-ийн шаардлагын дагуу төлөвлөнө.

14. Гол мөрөн, усан сан руу очих галын машин ус авах зориулалттай зам төлөвлөнө.
15. Хотын барилгажсан бүсийн хилээс хот орчмын ойн бүсийн зах хүртэлх зайг 50 м-ээс багагүй,
.
15. Хотын барилгажсан бүсийн хилээс хот орчмын ойн бүсийн зах хүртэлх зайг 50 м-ээс багагүй, хувийн сууцны 1 - 2 давхар барилгатай хороолол буюу хөдөөгийн тосгон, сум, суурингийн барилгажсан бүсийн хилээс 15 м-ээс багагүй зайтай байхаар тус тус тооцож төлөвлөнө.
16. Галын депогийн газрын үйлчлэх хүрээ 3 км-ээс ихгүй байх ёстой.
Галын депогийн газрын барилгажилтыг холбогдох норм дүрмийн дагуу төлөвлөнө.

Хот, тосгоны нутаг дэвсгэр ашиглалт, барилгажилт болон хүн амын төлөвлөлтийн шалгуур үзүүлэлтүүдийг тооцох зарчим

Хот, тосгоныг нийгэм-эдийн засгийн нийлмэл систем гэж үзнэ. Иймээс барилга байгууламжийн хувьд үндсэн зургаан дэд системд ангилагдана. Үүнд:

1. Эдийн засгийн үйл ажиллагааны салбар;
2. Соёл ахуйн болон нийтийн ахуйн үйлчилгээ;
3. Орон сууцны фонд;
4. Гудамж, замын сүлжээ;
5. Тээврийн байгууламж;
6. Инженерийн барилга байгууламж.

Хот, тосгоны нутаг дэвсгэрийг энэ ёсоор зориулалтын бүсчлэлээр ангилан орон сууц, суурьшил, үйлдвэрийн бүсийн газар эзэмшилт, ашиглалтыг бүс тус бүрээр дараахи зарчмаар тооцно. Орон сууцны хорооллын барилгажилтын нягтралыг тооцохдоо сууцны фонд, барилгын талбай, эзэлхүүн, давхрын үзүүлэлтүүдийг тулгуур үзүүлэлт болгон авах бөгөөд харин үйлдвэрийн бүсийн тухайд үйлдвэрлэлийн болон туслах талбай, зүлэгжүүлсэн талбай, нөөц талбайг авч хамруулан тооцно.

Хот байгуулалтын төслийн боловсруулалтын үе шатнаас хамаарч, төлөвлөлтийн шийдлийн эдийн засгийн үнэлгээнд техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг ашиглана. Энэ үзүүлэлтийг дотор нь орон сууц, олон нийтийн барилгын үзүүлэлтүүд гэж ангилна.

Нэг. Орон сууцны барилгын үзүүлэлтүүдийг дараах өгөгдлүүдээр тодорхойлно.

- Сууцны талбай, m^2 - Үндсэн өрөөнүүдийн нийлбэр талбай;
- Нийт талбай, m^2 - Үндсэн болон туслах өрөөнүүдийн талбайн нийлбэр (ашигтай) ханын шүүгээ, орон сууцны доторхи хонгил, хаалт;
- Орон сууцны дундаж - Орон сууцны нийт талбайг нийт сууцны тоонд нийт талбай, m^2 харьцуулсан харьцаагаар илэрхийлэгдэнэ.
- Төлөвлөлтийн коэффициент K_1 - Тухайн суурьшлын бүсийн сууцны талбайг нийт талбайд харьцуулсан харьцаагаар илэрхийлэгдэнэ. Сууцны төлөвлөлтийн чанараас хамаарч K_1 коэффициент нь орчин үеийн тохилог барилгад 0.55-0.7 байх бөгөөд төлөвлөлтийн хугацаанд доод хязгаарруу туслах өрөөнүүдийн талбайг нэмэгдүүлэх зорилго баримтлах ёстой.
- Эзлэхүүний коэффициент K_2 - Орон сууцны барилгын эзлэхүүнийг бүх талбайд харьцуулсан харьцаагаар илэрхийлэгдэнэ. Тухайн коэффициент нь давхрын өндрөөс хамаарч 3.4-4.7 байна.
- Коэффициент K_3 - Ямар нэгэн давхрын бүх талбайг барилгажилтын талбайд харьцуулсан харьцаагаар илэрхийлэгдэнэ. Энэ коэффициент нь давхраас хамаарч ялгавартай тогтоогддог ба 5 давхар сууцанд 0.66-0.81; 9 давхар сууцанд 0.59-0.75 байна. Тухайн коэффициентийн өөрчлөлт нь төрөл бүрийн давхар бүхий хийц, бүтээцийн төлөвлөлтөөс голлон хамаарах ба ялангуяа босоо зөөврийн

байгууламжтай (лифт, өргөгч цамхаг, г.м) байшингуудад илүү өөрчлөгддөг байна. K_3 нь онолын үндсэн дээр ашиглагддаг.

- Орон сууцны дундаж давхар \mathcal{E} - Дундаж гармоник харьцуулалтыг дараахи томъёогоор илэрхийлнэ.

$$\mathcal{E} = \frac{0}{0_1 + \frac{0_2}{2} + \frac{0_3}{3} + \frac{0_4}{4} + \dots + \frac{0_n}{n}}$$

O - орон сууцны барилгын нийт талбай, m^2 ;

$O_1; O_2; O_3; \dots O_n$ - 1; 2; 3; 4; ... n давхрын нийт талбай, m^2 ;

1; 2; 3; ... n - давхрын тоо;

Дундаж давхар нь тухайн хот болон районы өндөр-жилтийн нүүр царайг илэрхийлнэ. Түүнээс гадна хот байгуулалтын норм, нормативын үзүүлэлтүүд давхрын хэмжээнээс ихээхэн шалтгаалж, ялгардаг учир бодит үзүүлэлтийг нормативын үзүүлэлттэй харьцуулан хянах нөхцөл буюу шалгуур үзүүлэлт болдог.

- Суурьшлын бүсийн барилгажилтын нягтрал Π - Барилгажсан болон нөөц, барилгажаагүй талбайг суурьшлын нийт талбайд харьцуулсан харьцаагаар илэрхийлэгдэнэ.

$$\Pi = \frac{10^2 C}{T_{\text{ж}}}; \%$$

C - орон сууцны барилгажсан талбайн нийлбэр, га;

$T_{\text{ж}}$ - суурьшлын талбай, га

- Орон сууцны фондын цэвэр нягтрал $\sigma_{\text{НЕТТО}}$ - 1 га суурьшлын талбайд ногдох орон сууцны нийт талбайн хэмжээгээр илэрхийлэгдэнэ.

$$\sigma_{\text{НЕТТО}} = \frac{O}{T_{\text{ж}}} \quad (m^2 \text{ нийт талбай/га})$$

O - орон сууцны нийт талбай, m^2 ;

$T_{\text{ж}}$ - суурьшлын талбай, га

- Орон сууцны фондын бохир нягтрал $\sigma_{\text{БРУТТО}}$ - 1 га нийт талбайд ногдох орон сууцны нийт талбайн хэмжээгээр илэрхийлэгдэнэ.

$$\sigma_{\text{БРУТТО}} = \frac{O}{T_{\text{м}}}$$

O - орон сууцны нийт талбай, m^2 ;

$T_{\text{м}}$ - тухайн хорооллын (мэдээлэл судалгааны бүсийн) нийт талбай, га.

- Хүн амын суурьшлын - 1 га нутаг дэвсгэрт ногдох хүн амын тоогоор илэрхийлэгдэнэ.

нягтрал σ^H

$$\sigma^H = \frac{H}{T}$$

H - тухайн бүсийн хүн амын тоо, хүн;

T - тухайн бүсийн нийт нутаг дэвсгэр, га

Хоёр. Газар ашиглалт, эзэмшилтийн шалгуур үзүүлэлтийг тооцох зарчим

$$K' = \frac{(T_n + T_o + T_p)}{T}$$

- Газар эзэмшилтийн коэффициент K'

T_n - үйлдвэр аж ахуйн газрын барилгажсан талбайн нийлбэр, га;

T_o - үйлдвэрлэлийн туслах талбайн нийлбэр (үйлдвэрлэлийн дотоод тээврийн талбай, цахилгаан эрчим хүчний байгууламж, сантехникийн байгууламж, туслах барилга байгууламж, отвал болон бусад), га;

T_p - үйлдвэрийн нөөц талбай, га;

T- үйлдвэрийн бүсийн нийт талбай, га.

Газар эзэмшилтийн коэффициент нь газар нутгийн 20.0-35.0 хувьд хэлбэлзэнэ.

- Газар ашиглалтын коэффициент K''

$$K'' = \frac{(T_n + T_o + T_p + T_r)}{T}$$

T_r - автозам, төмөр замын салаа, орц, эстакад г.м. бусад барилга байгууламжийн нийт талбай, га.

Эдэлбэр газрын ашиглалтын коэффициент нь өндрийн байдлаас хамаарч 0.7-1.5 байна

- Цэцэрлэгжүүлэлтийн коэффициент K'''

$$K''' = \frac{T_3}{T}$$

T_3 - цэцэрлэгжүүлсэн талбай, га.

- Үйлдвэр аж ахуйн бүсийн барилгажилтын цэвэр нягтрал D_n

$$D_n = \frac{10^2 C}{T_n}$$

C- үйлдвэрийн бүсэд байрлах барилга байгууламжийн эзлэх нийлбэр талбай, га;

T_n - үйлдвэрийн бүсийн талбай, га.

Хот байгуулалтын эдийн засгийн үнэлгээ нь тухайн хот, төв, суурингийн газар ашиглалтын одоогийн байдал, үндсэн хөрөнгийн балансын өртгийн үзүүлэлтэд дүн шинжилгээ өгч, хотын дэвсгэр нутаг ашиглалтын хэтийн төлөвийн гол шийдэл, тоон үзүүлэлтэд тулгуурлан, хотын нийт нутаг дэвсгэрт буюу тухайн хэсгийн үнэлгээг үндэслэлтэй тогтооход чиглэгдэнэ.

БНБД 30.01.04

Үнэлгээнд тулгуурлан тухайн хот, суурины нутаг дэвсгэрт байршиж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийн газар эзэмшсэний болон инженерийн тоног төхөөрөмжийн барилга байгууламж, зам талбайн үндсэн хөрөнгийг ашигласны зохих төлбөрийг тогтооно.

Заавал мөрдөх 6 дугаар хавсралт

Нутаг дэвсгэрийн хүн амын багтаамжийг тооцох зарчим

Газар нутгийн хүн амын багтаамжийг тодорхойлох асуудал газар нутгийн иж бүрэн үнэлгээний үр дүнд нөлөөлөх нэгэн хүчин зүйл болно.

Газар нутгийн хүн амын багтаамжийг тогтоосноор хүн амыг өдөр тутмын хэрэгцээт бараа болон соёл, ахуйн үйлчилгээгээр ойрын зайнаас хангах, байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, хамгаалах ач холбогдолтой.

Үйлдвэрлэлийн нилээд хэд хэдэн салбар хөгжсөн их хот, том хот тосгон, мөн амралт аялал жуулчлалын чиглэлээр хөгжих хот маягийн сууринд болон бусад газар нутгийн хүн амын багтаамжийг тооцох зайлшгүй шаардлагатай болно.

Газар нутгийн хүн амын багтаамжийг тэдний өдөр тутмын амьдрал ахуйд зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байгалийн нөөцийн судалгаанд тулгуурлан тооцож гаргана. Энэ судалгаанд:

- Үйлдвэрийн болон иргэний барилга байгууламжид тохиромжтой газар нутаг;
- Хот орчмын хөдөө аж ахуйн баазад зориулагдсан хөдөө аж ахуй эрхлэхэд тохиромжтой газар нутаг;
- Газрын гадаргын дээрхи болон хөрсөн (гадаргын) доорхи усны нөөц;
- Хүн амын амралт зугаалгыг зохион байгуулах газар нутаг тус тус багтана.

Газар нутгийн иж бүрэн үнэлгээний үр дүнг үндэслэн дээр дурдсан байгалийн нөөцийг тодорхойлж, газар нутгийн хүн амын багтаамжийг тооцоолон гаргана. Мөн энэ үнэлгээний үр дүнд байгалийн нөөц, үйлдвэр болон иргэний барилга байгууламжийн талбайд орших хүн ам, ус, рекреацийн нөөц, хот орчмын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хангамж зэрэг асуудлуудтай харилцан уялдаатайгаар газар нутгийн хүн амын багтаамжийг тухайн хүчин зүйлээр ойролцоогоор тооцож тогтооно.

Газар нутгийн хүн амын тухайн багтаамжийг гаргаж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр эцсийн байдлаар хүн амын багтаамжийн хамгийн бага үзүүлэлтийг сонгон авна.

Үйлдвэрлэлийн болон олон нийтийн барилга байгууламжид зориулсан газар нутгийн хүн амын багтаамжийг тодорхойлох томъёо нь:

$$D_1 = \frac{\sum_{i=1}^n T_i \times 1000}{H}$$

D_1 - газар нутгийн тухайн хүчин зүйлд тохирох хүн амын багтаамж, хүн

T_i - i районы нэн тохиромжтой гэж үнэлэгдсэн газар нутаг, га

H - 1000 хүнд ногдох газар нутгийн ойролцоо хэрэгцээ, (үйлдвэрлэлийн онцлогоос хамааран 1 км²-т 20.0-25.0 мян.хүн)

- Усны нөөцөөр газар нутгийн хүн амын багтаамжийг дараах томъёогоор тодорхойлно. Үүнд:

$$D_2 = D_3 + D_4$$

D_2 - газар нутгийн хүн амын усны нөөцөөр нийлбэр багтаамж, хүн

D_3 - газар нутгийн хүн амын гадаргын дээрх усны нөөцөөр хүн амын багтаамж, хүн

D_4 - газар нутгийн хүн амын хөрсний доорхи усны нөөцөөр багтаамж, хүн

- Газрын дээрх усны нөөцөөр нутгийн гадаргын дээрх усны нөөцөд тохирох хүн амын багтаамжийг дараахи томъёогоор тодорхойлно. Үүнд:

$$D_3 = \frac{\sum_{i=1}^n P_i \times K \times 1000}{P}$$

- D_3 -газар нутгийн гадаргын дээрх усны нөөцөд тохирох хүн амын багтаамж, хүн
 P_i -i районы ус зарцуулалтын байдал, м³/хоног
 P -1000 хүнд ногдох усан хангамжийн хэрэгцээ, м³/хоног (тухайн районы хөгжлөөс хамаарч 1000-2000 м³/хоног)
 K -бохир усыг цэвэршүүлэн халдваргүйжүүлэх итгэлцүүр, (өмнөд хэсэгт 0.25; хойд хэсэгт 0.1)

- Хөрсөн доорхи усны нөөцөөр газар нутгийн хүн амын багтаамжийг дараахь томъёогоор тодорхойлно.

$$D_4 = \frac{\sum_{i=1}^n \Xi_i \times T_i \times 1000}{P_0}$$

- D_4 -газар нутгийн хөрсний доорхи усны нөөцөд тохирох хүн амын багтаамж, хүн
 Ξ_i -i районы газар нутгийн гүний усны ундаргын модуль, м³/хоног-га
 T_i -i районы газар нутаг, га
 P_0 -1000 хүнд ногдох усны хэрэглээний норматив, м³/хоног (40 м³/хоног)

- Рекреацийн нөөцөөр газар нутгийн хүн амын багтаамжийг тухайн районы рекреацийн оргил ачааллын үед 40.0 хувь нь амрахаар, сэрүүвтэр уур амьсгалтай газарт: ойд-75.0%, усанд-25%; халуун, хуурай уур амьсгалтай нутагт эсрэгээр ойд-25%, усанд-75.0 % байхаар зохион байгуулж, дараахь томъёог хэрэглэн тооцно.

$$D_5 = \frac{\sum_{i=1}^n T_i \times L \times 0.5 \times 1000}{100 \times H \times M}$$

- D_5 - рекреацийн нөөцөөрх газар нутгийн хүн амын багтаамж, хүн
 T_i - рекреацид нэн тохиромжтой гэж үнэлэгдсэн газар нутаг, га
 L - тухайн газар нутагт ойн эзлэх хувийн жин, %
 0.5 - хотын ногоон бүсийн зөвшөөрөгдсөн хэмжээг харгалзсан итгэлцүүр
 H - 1000 хүнд ногдох рекреацийн газар нутгийн ойролцоо хэрэгцээ, га (дундаж үзүүлэлт нь 1 га-д 5 хүн ноогддог учраас энэ нормативыг 2 км²-аар авна)
 M - усны болон ойн ойролцоо рекреацийг зохион байгуулах итгэлцүүр (сэрүүвтэр уур амьсгалд $M=0.3$; халуун дулаан уур амьсгалд $M=0.1$)

- Рекреацийг усны ойролцоо зохион байгуулахад дараах томъёог хэрэглэнэ. Үүнд:

- D_6 - рекреацийн нөөцөөрх газар нутгийн хүн амын багтаамж, хүн

$$D_6 = \frac{2 \sum_{i=1}^n B_i \times C \times 1000}{0.5 M}$$

БНБД 30.01.04

- В_r- (i) районы усанд сэлэхэд тохиромжтой зурвас газар, км
- С- наран шарлагын газрын боломжийг харгалзсан итгэлцүүр (ой болон ойт хээрийн бүст С=0.5; хээр талын бүст С=0.3)
- 0.5- 1000 хүнд ногдох наран шарлагын газрын ойролцоо норматив хэмжээ, км
- М- Өмнөх М-тэй ижил (сэрүүвтэр уур амьсгалд М=0.1-0.15 халуун дулаан уур амьсгалд М=0.3-0.4)

Хот орчмын хөдөө аж ахуйн баазын зохион байгуулалтын нөөцөөрх газар нутгийн хүн амын багтаамж нь түүнд ногдож болох газрын тооцоонд үндэслэн (зэлжлэн тариалах системийн шаардлагатай харьцааг баримтлах нөхцлийг анхаарах) тодорхойлогдоно. Түүнчлэн тухайн газар нутагт тээвэрлэлтийн даац муутай, түргэн муудах бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх ач холбогдлыг тооцох шаардлагатай.

Заавал мөрдөх 7 дугаар хавсралт

Нисэх онгоцны буудлын эдэлбэр газрын төлөвлөлтөд тавих шаардлага

Нисэх онгоцны буудлын байршил, эдэлбэр газрын төлөвлөлтийг тогтоогдсон хууль, эрх зүйн хүрээнд, баримт бичгийг хот, тосгон, орон нутгийн захиргаатай тохиролцож шийдвэрлэнэ.

А. Байршлын сонгоход анхаарах асуудал:

1. Онгоц буудалд ойртох агаарын зурвас хил дотор буюу онгоц бууж хөөрөх талбайн хяналтын цэгээс 10 км радиусын дотор онгоцны буудлын бүх объектуудыг байрлуулна.
2. Аэродромын хяналтын цэгээс 30км-ийн радиусын дотор байрлаж байгаа 50м, түүнээс өндөр объектууд;

Б. Байршлаас хамааралгүй объектууд:

3. Газрын түвшнээс 50 м, түүнээс өндөр объектууд;
4. Радиотехникийн хэрэгслийн хэвийн ажиллагаанд нөлөөлж болох холбоо, цахилгааны шугам болон электромагнитын бусад объектууд;
5. Тэсэрч дэлбэрэх объектууд;
6. Оргилох хийн асаалтад зориулсан бамбарын төхөөрөмж ⁽¹⁾;

⁽¹⁾ Бамбарын төхөөрөмжийн өндрийг тодорхойлохдоо хаях хамгийн их боломжит өндрийг тооцоолох ёстой.

7. Онгоц буух, хөөрөх буудлын талбайн харагдах байдалд нөлөөлөх үйлдвэрийн болон бусад объектууд;

Энэхүү хавсралтын 3-7 дугаар зүйлд заасан объектуудыг байрлуулах асуудлыг холбогдох дээд байгууллагатай урьдчилан зөвшөөрөлцөх ёстой. Онгоц буудлын хяналтын цэгээс 15 км-ийн дотор хаягдал ялгаруулах болон мал нядалгааны объект байрлуулахыг хориглоно.

Тайлбар:

1. Шинээр барих объектыг 3 жилийн дотор эхлээгүй нөхцөлд хүчингүйд тооцно.
2. Онгоцны буудлын талбайн геометр төвийн орчинд онгоц буух талбайн хяналтын цэг байрлах ёстой. Үүнд:
 - Онгоц буух, хөөрөх нэг зурвастай нөхцөлд энэ цэг геометр төвд нь байх;
 - Зэрэгцээ хоёр зурвастай нөхцөлд, тэдгээрийн төвийг холбосон шулуун шугамын төвд байх;

- Зэрэгцээ буух 2 зурвастай байх нөхцөлд, төвүүдээс босгосон тэгш өнцөгтийн огтлолцсон цэг дээр байх;
- 3. Өндөр барилга барих нөхцөлд тухайн барилгын байршлын солбилцлыг зааж өгнө.

Заавал мөрдөх 8 дугаар хавсралт

**Инженерийн төвлөрсөн болон хэсэгчилсэн хангамжтай сууцны
эдэлбэр газрын зөвшөөрөгдөх хэмжээ.**

Орон сууцны барилга болон эдлэн газар бүхий сууцанд ногдох эдэлбэр газрын хэмжээг тухайн барилгын хэв маяг, өндөр (давхрын тоо), сууцны тоо, орчны барилгажилтын онцлог, хот суурины ангилалаас хамааруулан 1 дүгээр хүснэгтийн дагуу тогтоож төлөвлөнө.

1 дүгээр хүснэгт

№	Талбайн хэмжээ, барилгын хэв маяг	Сууцны давхар	Айлын тоо	Байрших хот тосгоны ангилал	Байрших үүрэг зориулалтын бүс	Тайлбар
1	600-800 (эдлэн газартай сууц)	1-2	1-2	Бага хот	Нам давхар сууцны хороололд	Барилгажих талбайг оруулна. (инженерийн хэсэгчилсэн хангамжтай сууц)
				Хөдөөгийн тосгон	Суурьшлын хэсэгт	
				Дунд хот	Нөөц газарт	
				Бүх төрлийн хот	Хот орчмын бүсэд	
2	300-600 (коттедж хэлбэрийн эдлэн газартай сууц)	1-2	1-4	Том хот	Нөөц газарт	Барилгажих талбайг оруулна. (инженерийн хэсэгчилсэн хангамжтай сууц)
				Бага хот	Суурьшлын хэсэгт	
				Дунд хот	Нам давхар сууцны хороололд	
				Хоторхуу тосгон	Суурьшлын хэсэгт	
				Хөдөөгийн тосгон	Суурьшлын хэсэгт	
Бүх хот	Хот орчмын бүс					
3	100-300 (коттедж хэлбэрийн эдлэн газартай сууц)	1-3	1-4	Их хот	Нам давхар сууцны хороололд	Барилгажих талбайг оруулна. (инженерийн хэсэгчилсэн хангамжтай сууц)
				Том хот	Нам давхар сууцны хороололд	
				Бага дунд хот	Нөөц газарт	
				Хөдөөгийн тосгон	Суурьшлын хэсэгт төв хэсэгт	
4	60-100 (блокчилсон болон террас маягийн сууц)	1-4	хязгаарлахгүй	Их, том, дунд, бага хот	Суурьшлын хэсэгт	Барилгажих талбайг оруулахгүй. (инженерийн төвлөрсөн хангамжтай сууц) - үйлчилгээтэй сууц
				Хоторхуу тосгон	Суурьшлын хэсэгт	
				Бүх төрлийн хот, тосгон	Сэргээн шинэчилж буй хэсэг, нөөц талбайд	
5	30-60 (эзлэхүүний нарийн цогц архитектур төлөвлөлтийн шийдэл бүхий сууц)	2-5 давхар хязгаарлахгүй	хязгаарлахгүй	Их, том, дунд, бага хот	Суурьшлын хэсэгт	Барилгажих талбайг оруулахгүй. (инженерийн төвлөрсөн хангамжтай сууц) - үйлчилгээтэй сууц
				Хоторхуу тосгон	Суурьшлын хэсэгт	
				Бүх төрлийн хот, тосгон	Сэргээн шинэчилж буй хэсэг, нөөц талбайд	

Суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийн хүн амын нягтралын тооцоо

Суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийн хүн амын нягтралыг 1 дүгээр хүснэгтэд зааснаас багагүй; орон сууцны хорооллын эдэлбэр газрын хүн амын нягтралыг 2 дугаар хүснэгтэд зааснаас багагүй; хөдөөгийн суурингийн суурьшлын бүсийн хүн амын нягтралыг 3 дугаар хүснэгтэд зааснаас багагүй хэмжээгээр төлөвлөнө.

Хот, тосгоны дэвсгэр газрын хот байгуулалтын бүсчлэлийг “Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ”-ний судалгаа, тооцоонд тулгуурлан тогтоож, дэвсгэр газрын хот байгуулалтын зэрэглэлийн дагуу хүн амын нягтралыг нь тогтооно.

1 дүгээр хүснэгт

Суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийн хүн амын нягтрал, хүн/га

Дэвсгэр газрын хот байгуулалтын зэрэглэл	Хүн амын тооны дараахи ангилалаар (мян. хүн)							
	1.0-3.0	3.0-7.5	7.5-15.0	15.0-30.0	30.0-50.0	50.0 - 100.0	100.0 - 500.0	500.0 мян-аас дээш
Дээд	100	125	140	150	175	195	210	220
Дунд	-	-	-	-	-	190	200	210
Доод	50	85	120	135	150	170	180	190

Тайлбар:

- Инженерийн бэлтгэл ажил гүйцэтгэхэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийх шаардлагатай бол хүн амын нягтралыг 20%-иас ихгүй хувиар нэмэгдүүлнэ.

$$H_x = \left(\frac{X_b}{X_{\text{ИБД}}} - 1 \right) \times 100\%$$

Үүнд: X_b – нийт хөрөнгө оруулалтын томсгосон хэмжээ

$X_{\text{ИБД}}$ – инженерийн бэлтгэл ажилд шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ

- Инженерийн хэсэгчилсэн хангамж бүхий эдэлбэр газартай нам давхар сууцны хороололтой хот, тосгоны эдэлбэр газрын хүн амын нягтралыг 40 хүн/га-гаас ихгүйгээр бууруулан төлөвлөхийг зөвшөөрнө.
- Улсын болон тусгай хамгаалалттай суурьшилын газар нутагт хүн амын нягтралыг төслийн техникийн даалгаврыг үндсэнлэн шийднэ.

2 дугаар хүснэгт

Орон сууцны хорооллын эдэлбэр газрын хүн амын нягтралыг тооцох үндсэн зарчим, хүн/га

Уур амьсгалын бүс	Орон сууцны хорооллын нутаг дэвсгэрийн зориулалтын ангилал		
	өндөр давхар сууцны	Нам давхар сууцны	Олон нийтийн эдэлбэр газрын зонхилох хувь эзэлбэл
I бүс	200	110	50
II бүс (II а; II б дэд бүс)	320	150	60

III (III а; III б дэд бүс)	390	180	75
IV (IV а; IV б; IVв дэд бүс)	460	210	90

Тайлбар:

- Орон сууцны хорооллын нутаг дэвсгэрийн хилийг гол гудамж ба хорооллын чанартай замын улаан шугамаар, хорооллын доторхи зам, явган зам, гарцын тэнхлэгээр болон ердийн зурвасын дагуу тогтоох бөгөөд эдгээрийн аль нь ч байхгүй тохиолдолд барилгажилтын улаан шугамаас 3 м зайд тогтооно. Нутаг дэвсгэрийн тооцооноос дүүргийн ба хотын чанартай барилга байгууламжийн талбай, түүх, соёлын дурсгалт зүйлс болон архитектур-ландшафтын үнэт бүтэц бүхий талбай, түүнчлэн үйлчлэх хүрээгээр зэргэлдээ орших хэд хэдэн хорооллын хэрэгцээг хангахаар тооцогдсон соёл ахуйн үйлчилгээний барилга байгууламж (үйлчлэх хүн амын тоонд тохирсон)-ийн талбайг хасна. Нутаг дэвсгэрийн хэмжээг тооцоход хүн амын өдөр тутмын хэрэгцээг хангах олон нийтийн үйлчилгээний барилга байгууламжийн талбай, түүний дотор зэргэлдээ орших соёл-ахуйн үйлчилгээний барилга байгууламжийн нутаг дэвсгэр, түүнчлэн газрын доорхи болон дээрхи орон зайг хамруулна. Сэргээн шинэчлэх үед, орон сууцны хорооллыг шинээр байгуулахад, орон сууцны хорооллын нутаг дэвсгэрийн бүрэлдэхүүнд орон сууцны бүлэглэлүүдэд хуваагдсан гудамж, талбай, хороолол доторхи явган зам талбай, барилгуудын орц довжоонд зориулагдсан талбайг оруулан тооцно.
- Инженер-геологийн хүндрэлтэй нөхцөлд ногоон байгууламжийн 1 хүнд ногдох талбайгаас хамааруулан 1 хүнд 5 м² талбай ногдох хүртэл хүн амын нягтрал өсч болно.
- Хотын төвийн хэсгийн орон сууцны хорооллын хүн амын нягтрал өндөр байж болно. Гэхдээ 460 хүн/га-гаас хэтрүүлж болохгүй.
- Барилгажуулж буй нутаг дэвсгэр нь ой болон ойн цэцэрлэгт ойр дөт буюу эсвэл эргэн тойрон ойгоор хүрээлэгдсэн орчинд ногоон байгууламжийн нийт талбайн хэмжээг 30 хувиас ихээр багасахгүй бөгөөд үүнтэй харьцуулан хүн амын тооцооны нягтралыг дээрхи хувь хэмжээнээс илүү өсгөхгүй.
- Хүн амын нягтралын үзүүлэлтийг орон сууцны хангамжийн хэвийн түвшин болох 1 хүнд ногдох 13.5м² сууцны талбайгаар тогтооно. Энэ нормативыг техник эдийн засгийн тооцоог үндэслэж тогтооно. . Гэхдээ 9 м²-аас багагүй байх ёстой.

Хэрэв орон сууцны хангамжийн түвшинг өөрөөр тооцох болбол:

$$П = \frac{П_{13.5} \times 13.5}{0} \text{ томъёогоор тооцно.}$$

Үүнд: $П_{13.5}$ – нягтралыг 13.5 м²/хүн байх үеийн үзүүлэлт
0 – орон сууцны хангамжийн байдал, м²

3 дугаар хүснэгт

Хөдөөгийн тосгоны суурьшлын бүсийн хүн амын нягтрал, хүн/га

Хөдөөгийн тосгоны үйлдвэрлэлийн чиглэл	Инженерийн хэсэгчилсэн хангамжтай сууцны эдэлбэр газрын хэмжээгээр, м ²								
	100	200	300	400	500	600	700	800	900<
Газар тариалан	80	74	62	55	46	40	32	26	21
Мал аж ахуй	70	65	54	48	40	35	28	22	18
Холимог	75	69	58	51	43	38	31	25	20

Тосгоны суурьшлын бүсийн хүн амын тооцооны нягтрал

Барилгын хэв шинж		Хүн амын нягтрал, хүн/га (Өрхийн дундаж хүн амаар, хүн)							
		2.5	3.0	3.5	4.0	4.5	5.0	5.5	6.0
Эдлэн газар бүхий сууцны нийт эдэлбэр газрын хэмжээ, м ²	2000	10	12	14	16	18	20	22	24
	1500	13	15	17	20	22	25	27	30
	1200	17	21	23	25	28	32	33	37
	1000	20	24	28	30	32	35	38	44
	800	25	30	33	35	38	42	45	50
	600	30	33	40	41	44	48	50	60
	400	35	40	44	45	50	54	56	65
Давхрын тоог заасан бүлэглэсэн сууц,	2	-	130	-	-	-	-	-	-
	3	-	150	-	-	-	-	-	-
	4	-	170	-	-	-	-	-	-

Зөвлөмжийн 11 дүгээр хэвсрэлт

1 дүгээр хүснэгт

**Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний агуулахын 1000 хүнд
ногдох эдэлбэр газрын доод хэмжээ, талбай**

Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний агуулах	Агуулахын талбай, м ²		Эдэлбэр газрын хэмжээ, м ²	
	хотод	хөдөөгийн суурин, тосгонд	хотод	хөдөөгийн суурин, тосгонд
Аж үйлдвэрийн барааны	77	19	310*/210	60
Хүнсний бүтээгдэхүүний	217	193	740*/490	580

* -Хүртвэрт 1 давхар, хуваарьт олон давхар (дунджаар 6 м өндөртэй гэж үзэхэд) агуулахын нормуудыг үзүүлсэн болно.

Тайлбар:

1. Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний агуулахуудыг төрөлжүүлэн байршуулсан тохиолдолд эдэлбэр газрын хэмжээг 30 хүртэл хувиар бууруулж болно.
2. Бараа бүтээгдэхүүнийг урьдчилан зөөх бүсэд эдэлбэр газрын хэмжээг 40 хувь хүртэл өсгөж болно.
3. Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний агуулахын бэлтгэл нөөцийн түвшинг жижиглэн худалдаа явуулах өдрөөр (барааны эргэлт) тооцож, орон нутгийн удирдлагаас тогтооно.

2 дугаар хүснэгт

**Төрөлжсөн агуулахуудын 1000 хүнд ногдох багтаамж,
эдэлбэр газрын доод хэмжээ**

Төрөлжсөн агуулах	Багтаамж, тн		Эдэлбэр газрын хэмжээ, м ²	
	хотод	хөдөөгийн суурин тосгонд	хотод	хөдөөгийн суурин тосгонд
Түгээх, хуваарилах хөргөгч (мах, махан бүтээгдэхүүн, загас, загасан бүтээгдэхүүн, цөцгийн тос, өөхөн тос, сүү, цагаан идээ, өндөг хадгалах)	20	12	1.0	(30)
Жимс жимсгэнэ хадгалах	75	45	500	300
Хүнсний ногоо хадгалах				
Төмс хадгалах				

Тайлбар:

1. Төмс, хүнсний ногоо тариалдаг болон бэлтгэдэг бүсэд агуулахуудын багтаамж болон эдэлбэр газрын талбайн хэмжээг 0.6 коэффициентийг хэрэглэн тооцно.
2. Төмс, хүнсний ногоо хадгалах газрын багтаамж, эдэлбэр газрыг хотод, хотын гадна бий болгон зохион байгуулснаар багасгаж болох ба түүний хувь хэмжээг орон нутгийн удирдлагын шийдвэрээр зохицуулна.
3. Тэсэрч дэлбэрэх, шатах тослох материалын 30 мян.м³ багтаамжтай агуулахыг орон сууц, олон нийтийн барилга байгууламжаас 200 м-ээс багагүй, 30 мян.м³ хүртэл багтаамжтай агуулахыг 100 м-ээс багагүй зайтай байрлуулна.

3 дугаар хүснэгт

**Барилгын материал, хатуу түлшний агуулахуудын
1000 хүнд ногдох эдэлбэр газрын доод хэмжээ**

Агуулах	Эдэлбэр газрын хэмжээ, м ²
Хэрэглэгчдийн барилгын материалын агуулах	300
Хатуу түлшний агуулах, ашиглалтын илүү байдлаар	Нүүрс
	Түлээ

Тайлбар:

Хатуу түлшний агуулахын эдэлбэр газрын хэмжээг уур амьсгалын I бүсэд 1.5 коэффициентийг, уур амьсгалын IV бүсэд 0.6 коэффициентийг хэрэглэн тооцно.

Хот, тосгоны цэцэрлэгжүүлэлтийн зураг төсөл зохиох аргачилсан зөвлөмж

1. Цэцэрлэгжүүлэлтийн төсөлд хот, тосгонд нийтийн, хязгаарлагдмал болон тусгай хэрэгцээний зориулалттай цэцэрлэгт байгууламжуудын нэгдмэл системийг бий болгох иж бүрэн арга хэмжээг тусгасан байх ёстой. Мөн хөрс бэлтгэх, суулгацын материалын нэр төрөл, тарих арга хэлбэрийг сонгох зэрэг асуудлыг шийдвэрлэж, мод сөөгийг тарьсны дараах эхний жилд арчлан тордоход зайлшгүй шаардлагатай барилга байгууламжийг тодорхойлно.
2. Хот, тосгоны тухайн орон нутгийн хөрс, уур амьсгалын нөхцөл, мөнх цэвдэг хөрстэй эсэх, түүний үеийн гүн зэргийг тооцож, суулгацын төрөл, зориулалт, түүнчлэн суулгацын материалыг зөөвөрлөн авчрах боломж зэрэгтэй уялдаатайгаар цэцэрлэгжүүлнэ. Элсний нүүлт, гуу жалга, хөрсний эвдрэл элэгдлийн тархалт бүхий хот суурины нөхцөлд ойн зурвас байгуулах асуудлыг мэргэжлийн байгууллагатай хамтран дээрх нөлөөллүү-дийн эх үндсийг таслан зогсоох арга хэмжээтэйгээр иж бүрнээр шийдвэрлэсэн байх ёстой.
3. Цэцэрлэгжүүлэлтийн зураг төсөл боловсруулахдаа дараах үндсэн зарчмуудыг баримтлана. Үүнд:
 - Хуучин байсан ургамал, ялангуяа мод сөөг, үржил шимт өнгөн хөрсийг аль болохоор хадгалан үлдээх;
 - Цэцэрлэгжүүлэлтийн зориулалт болон нар, салхины нөлөөлөл, агаарын бохирдолт, хөрсний нөхцөл зэрэг тухайн нөхцөл байдалтай уялдаатайгаар мод, сөөгийн нэр төрөл, тарих хэлбэрийг сонгон авах;
 - Бүх хэлбэрийн цэцэрлэгжүүлэлтийг хийхдээ хүрээлэн байгаа орчны архитектурын нэгэн чухал элементийн хувьд төрөл бүрийн мод сөөгний өнгө, титмийн хэлбэрийг оновчтой тохируулан ашиглах;
 - Ногоон ургамлыг хамгаалалтын бүс, барилга байгууламжийн дэвсгэр газрын зааг болгох зэргээр боломжтой газар бүхэнд ашиглах.
4. Цэцэрлэгжүүлэхэд зориулан хөрсийг сайжруулах арга хэмжээг боловсруулахдаа тухайн хөрсний үржил шим, хөрсийг зөөвөрлөх, хадгалах талаар зураг төсөлд тусгагдсан арга хэмжээ, цэцэрлэгжүүлэлтийн зориулалт, цэцэрлэгжүүлэхэд хэрэглэх мод, ургамлын нэр төрөл зэргийг үндэслэл болгоно.
5. Бэлтгэл ажлыг эхлэхийн өмнө цэцэрлэгжүүлэх талбайн хог хаягдал, хатаж шарласан болон өвчилсөн мод, сөөг, том ширхэгтэй чулуу зэргийг цэвэрлэж зайлуулсан байх ёстой. Мод, сөөг тарих ажил эхлэхээс өмнө цэцэрлэгжүүлэх тохиромжийг дараах байдлаар ангилна. Үүнд:
 - Үржил шимтэй хөрс. (Хар шороон, хүрэн, нугын хөрс гэх мэт.) Түүний ялзмагт үеийн зузаан 15 см-ээс багагүй, хөрсний усны (давсгүй) түвшин нь 1м-ээс доош байх.
 - Үржил шим багатай хөрс. (Нуга – намгийн бор саарал, элсэнцэр, давсархаг хөрс гэх мэт.) Түүнийг хатаах, давсгүйжүүлэх, бордох, шинээр хөрс авчирч механик бүтцийг нь сайжруулах зэрэг арга хэмжээг зураг төсөлд тусгасан байх.
 - Үржил шимгүй хөрс. (Элс, чулуулаг, шаварлаг, хөрс болон тэдгээрийн хольц) Огт хөрсгүй нүцгэн чулуулаг хурдас мөн энэ ангилалд хамаарна..

Үржил шим багатай хөрсөнд нийтийн хэрэгцээний болон тусгай зориулалтын цэцэрлэгжүүлэлтийн ажлыг хийхдээ хуучин байсан хөрсийг сайжруулах талаар 2-3 жилийн хугацаанд гүйцэтгэх агротехникийн арга хэмжээ (хөрсийг ялзмагжуулах, механик бүтцийг нь сайжруулах, намагт хөрсийг хатаах, бордох г.м.)-г төлөвлөнө.

Дээрхи хэлбэрийн цэцэрлэгжүүлэлтийг үржил шимгүй хөрсөнд хийхдээ тухайн орон нутгийн нөхцлөөс хамааран үржил шимт хөрс зөөвөрлөн авчирч ашиглах, ургамлын нөмрө-

гийг нь олон жилийн хөтөлбөрт ажилбараар байгалийн нөхцөлд сэргээн бий болгох арга хэмжээг хослуулан хэрэгжүүлэхэд тулгуурласан янз бүрийн арга хэлбэрүүдийг ашиглана.

Хязгаарлагдмал зориулалттай цэцэрлэгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэх, гудамжны дагууд цэцэрлэгжүүлэлтийн ажлыг хийхдээ шаардлагатай тохиолдлуудад хөрсний усны түвшинийг доошлуулах, давсгүйжүүлэх, түүнчлэн үржил шим багатай хөрсийг зүлэгжүүлэхэд үржил шимтэй хөрсөөр нэмж ялзмагт хөрсийн зузааныг 20 см хүргэж хучих, мод, сөөг тарих нүхний шороог бүрэн солих, үржил шимгүй хөрстэй газарт мод, сөөг, зүлэг тарихаар тухайн хөрсийг бүрэн солих зэрэг арга хэмжээг төлөвлөнө.

- Барилга байгууламжийн суурийн нүх ухах, газар доорхи шугам сүлжээний суваг, шуудуу малтах, өндөржилтийн зургийн дагуу хөрс хуулах буюу нэмж хучих зэрэг газар шорооны ажлын үед үржил шимт болон зарим үржил шим багатай (нугын бор, саарал гэх мэт) хөрсний ялзмагжсан өнгө үеийг 20 см, зүлгэн хөрсийг 6 – 8 см зузаан хуулан авсан байх. Хуулан авсан ширэг, үржил шимт хөрсийг түр хугацаагаар хадгалах газрыг барилгын талбай дахь барилгын ажлыг явуулахад саад болохооргүй, барилгын хог, орчны үржил шимгүй хөрс зэрэгтэй холилдож нийлэхээргүй газарт сонгон авна. Хуулан авсан хөрсийг буцааж хучих, түүнчлэн өнгөн үеийг үржил шимтэй хөрсөөр нэмж хучих буюу солихын өмнө ул хөрсийг 15 – 10 см гүн сийрэгжүүлсэн байна.

Тайлбар: Үржил шимтэй хөрсийг хөлдүүгээр нь мод, сөөгний шороонд ашиглахыг хориглоно.

- Мөнх цэвдэгтэй газрын улирлын хөлдөлтийн үе нь 1.5 м-ээс нимгэнгүй байдаг хэсгийг цэцэрлэгжүүлж болох бөгөөд үүнээс нимгэн байх хот, суурины нөхцөлд онцгой шаардлагатай гэж үзвэл дээрхи үеийн зузааныг 1.5 м хүртэл ихэсгэх арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн дээр цэцэрлэгжүүлэхийг зөвшөөрнө.
- Хөрсний үржил шимийг сайжруулахаар бордохдоо 1 дүгээр хүснэгт дэх барагцаалсан нормыг баримтлана.

1 дүгээр хүснэгт

Суулгацын төрөл	Хэмж нэгж	Органик бордоо	Эрдэс бордоо гр - р						Бордох хугацаа
			Азот	Фосфор	Кали	33% аммиакан догшин шүү	16% супер фосфат	30% хлорт кали	
Бүлэг ба ганцаарчилан тарьсан сөөгүүд	1ш	3-5	12	12	8	40	80	30	Жилийн дараа
Амьд хашаа ба эмжээрлэн тарьсан сөөгүүд	1м	5-7	15	15	12	50	100	40	-,-
6 – 10 настай модод	1ш	6-8	18	18	12	60	110	40	-,-
10 –аас дээш настай модод	1ш	10-12	30	30	25	90	180	90	-,-
5 м хүртэлх өндөртэй явган зам дагуух модод	1ш	8-10	30	30	20	80	150	50	Жил бүр тогтмол усалгаатай үед
5 м-ээс дээш өндөртэй явган зам дагуух модод	1ш	10-12	35	35	30	120	250	100	-,-

- Мод ургамлыг тарих арга хэлбэр, хугацааг цэцэрлэгжүүлж байгаа нутаг дэвсгэрийн зориулалт, хөрс, уур амьсгалын онцлог, суулгацын материалыг зөөвөрлөн авчрах нөхцөл зэргээс хамааруулан сонгож авсан байна.

Мод, сөөгийг тарих хугацаа нь ургамлын амьдарлын үйл ажиллагаа суларсан үе, хавар хөрс гэсэхдээ эхлээд мод навчлах үе, намар навч унах үеэс эхлээд хоногийн дундаж халуун, хүйтэний хэмжээ 0°C-оос бага болох үеийн хооронд байна.

Мод, сөөгийг тарих хэлбэрийг ганц нэгээр, эгнээгээр, бүлэглэж тарих зэргээр ангилна.

Тарих аргыг үндэсний шороотой нь авчирч тарих, үндэсний шороогүй тарих гэж 2 ангилна. 6 – 10 настай, 10 – 15 настай модыг эхний аргаар тарих бөгөөд түүнээс бага буюу 5 – 7 настай мод, сөөгийг хоёр дахь аргаар тарина. Модыг үндэсний шороотой нь тарихыг үндсэн арга гэж үзвэл зохино. Шилмүүст модны үндэсний шороог 120 x 120 x 100 см, навчит

БНБД 30.01.04

модныхыг 80 х 80 х 50 см, бут сөөгийнхийг 50 х 50 х 40 см-ын хэмжээтэйгээр авна. Суулгах нүхний хэмжээ нь үүнээс 10 – 15 см өргөн бөгөөд гүн байх ёстой. Үндэсний шороог үржил шимтэй хөрсөөр чигжинэ.

Модны өөр хоорондын зайг: эгнээлэн тарихад 3 – 5 метр, эгнээний хооронд 4 – 6 метр, бүлэглэж тарихад 2 – 4 метрээр авна.

Бут сөөгний хоорондын зайг нормчлохгүй. Бут сөөгөөр таримал хашаа байгуулахдаа тусгай шуудуунд суулгах бөгөөд түүний хэмжээг бут сөөгийг нэг эгнээгээр тарихад 50 х 50 см, хоёр эгнээгээр тарихад 70 х 50 см, гурван эгнээгээр тарихад 90 х 60 см, өөрөөр хэлбэл эгнээний тоо өсөх тутамд шуудууны өргөн 20 см-ээр ихэсч байхаар авна.

10. Нийтийн хэрэгцээний болон хязгаарлагдмал хэрэгцээний зориулалттай цэцэрлэгжүүлэлтийг энэхүү хавсралтын 2-р хүснэгтэд заасанчлан мод сөөгний онцлог шинж чанаруудыг харгалзан, үзэмжтэй сайхнаар тарихаар төлөвлөнө.

Мод, сөөг таригдаагүй сул газарт зүлэг, цэцгийн мандал байгуулах, орон нутгийн чулуу зэрэг материалаар өнгөлж хучихаар төлөвлөвөл зохино. Зүлэгжүүлсэн талбайд эзлэх цэцгийн мандлын хэмжээг доор заагдсанаас ихгүйгээр тогтоох нь зүйтэй. Үүнд:

- Нийт талбайн хэмжээ нь 10 га-гаас багагүй цэцэрлэгт хүрээлэн ба цэцэрлэгт 1%;
- Мөн 10 га-гаас ихгүй үед 2%;
- Цэцэрлэгт гудамж, цэцэрлэгт талбайд 3%;
- Бусад хэсэгт 0.5%;

11. Хот, тосгон, суурины гудамжыг цэцэрлэгжүүлэх мод, сөөгний нэр төрлийг сонгохдоо өнгө үзэмж, хөрс, уур амьсгалын шаардлагыг нь харгалзах төдийгүй, агаарын бохирдолтонд тэсвэртэй байдал болон гэрэлтлэг, сүүдэрлэг байдлыг тооцно.

Замын уулзвар, явган хүний гарцын орчинд мод, сөөг тарихдаа замын хөдөлгөөний дүрмийн дагуу харааны чөлөө гаргах шаардлагыг тооцно.

12. Салхинаас хамгаалах ойн зурвасыг 30-50 метрийн өргөнтэй хэд хэдэн эгнээ байдалтайгаар хийж, хот суурины салхин талд, газрын нилээд өндөр хэсгийг сонгон байрлуулна.

Салхинаас хамгаалах ногоон байгууламжийн эгнээ бүрийг сийрэг хэлбэртэйгээр, мөнх ногоон мод, сөөгийг бүрэлдэхүүнд нь оруулж төлөвлөх ёстой.

13. Ариун цэврийн хамгаалалтын бүсийг 20-50 метрийн өргөнтэй, мод сөөгний эгнээнүүдийг 30 метрээс багагүй өргөнтэй цулгүй зурвас газар дараалах байдлаар цэцэрлэгжүүлбэл зохино.

Ариун цэврийн хамгаалалтын бүсэд тарих мод, сөөгний нэр төрлийг сонгохдоо тухайн үйлдвэрийн агаар бохирдуулах нөлөөллийг үндэслэнэ.

14. Мод, сөөг тарьсан эхний жилд тэдгээрийг арчлан тордох талаар дараах арга хэмжээнүүдийг төлөвлөвөл зохино. Үүнд:

- Цэцэрлэгжүүлсэн хэсгийг тойруулан мод, төмөр, торон материалаар 5-7 жилээс багагүй эдэлгээтэй, хөнгөн маягийн хайс хийх;
- Хөрс, уур амьсгалын байдалд нь тохируулан усалгаа, сийрэгжүүлэлт, бордолтыг тогтмол хийх;

Хангай, тал хээрийн бүсэд тогтмол усалгааг 3-4 хоногт 1 удаа шүрших аргаар, оройн цагаар усалгааны шугам буюу усалгааны машинаар хийнэ.

Говийн болон заримдаг говийн бүсэд усалгааг өдөр бүр буюу 2-3 хоногт нэг удаа, усалгааны шугамаар болон жижиг сувгаар хийх шаардлагатай. Давсгүйжүүлж байгаа хужир, мараалаг хөрсөнд бол ус зайлуулах сувагтайгаар төлөвлөвөл зохино. Элсэнцэр болон бусад шүүлттэй хөрсөнд ус тусгаарлагч арга хэмжээгүйгээр сувгаар услахыг хориглоно.